

АГУУЛГА

• Эрхлэгчийн зурвас	3
• С. Цэрэндорж Сонгох, сонгогдох эрхийн хэрэгжилт	4
• Ж. Дашдорж Эрүү шүүлтээс хамгаалах нь төрийн үүрэг	17
• Г. Далайжамц, Д. Чимэддулам Зохистой аюулгүй хоол хүнсээр жигд, хүртээмжтэй хангагдах эрхийн тухайд	24
• П. Оюунчимэг Сэжигтэн яллагдагчийн эрхийг баталгаатай хангах зарим асуудал	39
• Б. Хишигсайхан Үндэстний цөөнхийн эрх: Цаатан	46
• Ж. Бямбаа Шүүн таслах ажиллагаан дахь мэтгэлцэх зарчим ба хүний эрх, эрх чөлөө	54
• О. Жамбалдорж Өмчийн эрхийн хөгжлийн эрх зүйн орчин, өмчийн эрхийн зарим эгзэгтэй асуудал	60
• П. Оюунтунгалаг Хүний экологийн эрх ба агаарын бохирдол	73
• Б. Алтангэрэл Ярилцлага	79
• Эрүүдэн шүүх болон бусад хэлбэрээр хэрцгий, хүнлэг бусаар хүний нэр төрийг доромжлон харьцах, шийтгэхийг хориглох олон нийтийн нээлттэй хэлэлцүүлэг, хяналт шалгалт явуулах удирдамж	81
• Монголын Өмгөөлөгчдийн Холбооны захидал	84
• Эмнести Интернэшнл Байгууллагын Монгол дахь салбарын захидал	85
• ХЭҮК-оос 2005 оны 1-р улиралд хийсэн сургалтын жагсаалт	86

CONTENT

• Message from editor	3
• S. Tserendorj The right to elect and to be elected	4
• J. Dashdorj State obligation protect from torture	17
• G. Dalaijamts, D. Chimeddulam Right to an adequate food	24
• P. Oyunchimeg The protection of the rights of suspects and accused	39
• B. Khishigsaik han The rights of national minority: Tsaatan	46
• J. Byambaa Principle of defense in court trail, human rights and freedom	54
• O. Jambaldorj Property rights: Critical issues and development of legal environment	60
• P. Oyuntungalag Human rights and environment	73
• Interview	79
• Terms of reference: Public inquiry on Torture, and Other Cruel, Inhuman or Degrading Treatment or Punishment	81
• Letter of support from: Mongolian Bar Association	84
• Letter of support from: Amnesty International Mongolia	85
• Human rights training by MNHRC /first quarter 2005/	86

ЭРХЛЭГЧИЙН ЗУРВАС

Эрхэм хүндэт уншигчидаа!

Та бүхний гар дээр «Хүний Эрх» сэтгүүлийн 2005 оны эхний дугаарыг өргөн барьж байгаадаа баяртай байна. Уг сэтгүүлийг Монгол Улсын Засгийн газар болон НҮБ-ын Хөгжлийн Хөтөлбөрийн дэмжлэгтэйгээр хэрэгжиж байсан «Монгол Улсад Хүний эрхийг хангах хөтөлбөр боловсруулах төсөл» хамтран санаачилж эрхлэн гаргаж байсан билээ. Харин энэ дугаараас эхлэн Монгол Улсын Хүний Эрхийн Үндэсний Комиссоос хариуцан Хүний Эрхийн Үндэсний Комиссын Чадавхийг дээшлүүлэх төслийн санхүүжилтээр гаргаж байхаар болсон явдалд бид нэн талархалтай байна.

Энэ сэтгүүлд манай улс дахь хүний эрхийн тулгамдсан, бэрхшээлтэй асуудлууд, тэдгээрийг шийдвэрлэх арга зам, олон улсын хүний эрхийн баримт бичгүүд ба дотоодын хууль тогтоомжийн уялдаа холбоо, хүний эрхийн онол практикийн сэдвээрх судлаачид, эрдэмтэд, төрийн болон төрийн бус байгууллагын ажилтан, идэвхтэнүүдийн бичсэн өгүүлэл нийтлэлийг нийтэлж байхын зэрэгцээ холбогдох байгууллагуудын хүний эрхийг хамгаалах, сурталчлах талаар явуулж буй үйл ажиллагаануудаас өргөн хүрээгээр сурталчлах болно.

Түүнчлэн Хүний Эрхийн Үндэсний Комиссын зарим үйл ажиллагааны мэдээлэл, тухайлбал, олны анхаарлыг татсан томоохон хэмжээний шалгалт судалгааны дүн, тэдгээрийн мөрөөр авсан арга хэмжээ, шаардлага, зөвлөмж, саналыг энэхүү сэтгүүлд гаргана.

Хүний эрхийн мэргэжилтэн, судлаач, эрдэмтэдтэй хийсэн ярилцлага, сурвалжлагыг ч манай сэтгүүлийн хуудаснаас та бүхэн унших болно.

Энэ сэтгүүл нь цаашидаа Монгол улсад хүний эрхийг түгээн дэлгэрүүлэх, хүн бүрийн эрхийг баталгаатай болгоход өөрийн хувь нэмрээ оруулна гэдэгт итгэлтэй байна.

Уншигч олон түмэндээ хүний эрхийг эрхэмлэн дээдлэхийн ерөөлийг өргөн дэвшүүлье!

*Сэтгүүлийн эрхлэгч:
Монгол Улсын Хүний Эрхийн Үндэсний
Комиссын дарга, доктор
С. Цэрэндорж*

СОНГОХ, СОНГОГДОХ ЭРХИЙН ХЭРЭГЖИЛТ

С.Цэрэндорж,
ХЭҮК-ын дарга (Ph.D.)

Сонгууль бол нэг талаасаа төвийн /УИХ/ болон орон нутгийн /Иргэдийн төлөөлөгчдийн хурал/ засаглалын эрхийг барих байгууллагуудыг байгуулах үндсэн арга, нөгөө талаасаа иргэдийн улс төрийн эрхийн амин сүнс болсон сонгох, сонгогдох эрхийн хэрэгжилтийн бодит үзүүлэлт юм.

2004 оны УИХ-ийн сонгууль болон орон нутгийн сонгууль нь манай сонгуулийн тогтолцоо, хууль тогтоомжийг шинэчлэх, боловсронгуй болгоход түлхэц, дохио сургамж болохуйц үр дүнг өгсөн ба хүний эрхийн талаас нь ч авч үзүүштэй асуудлууд бийг гарган тавьсан гэж үзэх бүрэн үндэслэлтэй юм.

ХЭҮК-оос МУИС-ийн Нийгмийн судалгааны хүрээлэнтэй хамтарч 2004 оны орон нутгийн сонгуулийн явцад судалгаа хийсэн /мөн 2004 оны УИХ-ийн сонгуулийн талаар бичиг баримтын судалгаа хийсэн/ юм.

Хуульд заасан сонгох, сонгогдох эрхийн бүрэн дүүрэн, шударга хэрэгжих үндсэн нөхцөл нь сонгууль, түүнийг зохион явуулах үйл ажиллагаатай шууд холбоотой юм.

Сонгууль хэдийгээр нэгдмэл үйл явц хэдий ч судалгааны хүрээнд сонгуулийг:

- Эхэн буюу бэлтгэл
- Дунд буюу санал хураах
- Төгсгөл буюу дүнг тоолж, гаргах

гэж хуваан, үе шат бүрд сонгох, сонгогдох эрхийн хэрэгжилтийн төлөв байдлыг дүгнэн шинжилсэн болно.

Эхэн буюу бэлтгэл үе шатанд сонгуулийн хороодыг байгуулах, нэр дэвшигчдийг бүртгэх, сонгогчдын нэрийн жагсаалтыг гаргах болон нэр дэвшигчид, нам эвслийн сурталчилгааг; дунд буюу санал авах шатанд санал хураах байр, нууцаар санал гаргах, зөөврийн хайрцагар санал авах нөхцөл, ажиглагчдын үйл ажиллагаа; төгсгөлийн шатанд санал тоолох, сонгууль, санал хураах үйл явцтай холбогдсон санал гомдол зэргийг хамруулан авч үзэж болно.

А. Сонгуулийн бэлтгэл үе шат

Сонгуулийг шударгаар зохион байгуулах, иргэдийн сонгох, сонгогдох эрхийн хэрэгжилтийн үндсэн суурь нөхцлийн нэг бол сонгуулийн тойрог, хэсгийн хороодыг хуулийн дагуу байгуулах явдал юм.

Сонгуулийн хэсэг, тойрогийн хороодод нам, эвсэл, нам бусчуудын төлөөллийн тэнцвэртэй байдал алдагдах, нам, эвслүүд, нам бусчуудын төлөөллийг оруулахад саад тотгор учруулах, тойрог, хэсгийн хороодыг хуульд заасан хугацаанаас хоцроож байгуулах зөрчил нь иргэдийн сонгох, сонгогдох эрхэд сөргөөр нөлөөлж байна.

Түүнчлэн “нам бус” гэдэг нэрийн дор аль нэгэн намд гишүүнчлэлтэй хүн тойрог, хэсгийн хороонд ажиллаж буйг сонгогчид шүүмжилдэг.

Энэ тухай нам эвсэл, нэр дэвшигчдээс цөөнгүй санал, гомдол гардаг ч холбогдох хуульд “...тойрог хэсгийн хороодын дарга, нарийн бичгийн дарга, гишүүд ...нэр дэвшигч байж болохгүй” гэснээс өөр хязгаарлалтыг, тухайлбал, Сонгуулийн хороодын бүрэлдэхүүнд аль нэг нам эвслийн төлөөлөл давамгайлахыг хориглосон зүйл байхгүй нь тойрог, хэсгийн хороодын бүрэлдэхүүний төлөөллийг тэнцвэртэй бус болгоход нөлөөлж байна.

Хуульд зааснаар сонгуулийн бүх шатны хороодын дарга, нарийн бичгийн дарга, гишүүд аль нэг нам, эвсэл, нэр дэвшигчийн талаар сурталчилгаа хийхийг хориглодог боловч, нэг гэр бүлийн хүмүүсийн нэг нь нэр дэвшиж, нөгөө нь сонгуулийн хороонд ажиллах тохиолдол хөдөө, орон нутагт цөөнгүй байв. Хуульд тодорхой заалтгүйн улмаас сонгуулийн хороод аль нэгэн улс төрийн хүчин, нэр дэвшигчийг талархан дэмжигчдээс дагнан бүрдэхгүй гэсэн баталгаа үгүйн зэрэгцээ, нөлөө бүхий нам, эвслүүд хороодын бүрэлдэхүүнийг хоорондоо хуваах, нам бусчуудыг хороодын бүрэлдэхүүнд аль болох оруулахгүй байх нь 2004 оны орон нутгийн сонгуулиар ажиглагдаж байлаа.

Хэдийгээр нам эвслийн тохиролцож байгаа нь хууль зөрчөөгүй мэт боловч намын харьяалалгүй иргэд болоод өөр бусад жижиг намын гишүүдийг ялгаварлан гадуурхаж буй нэгэн хэлбэр гэж хэлж болно.

УИХ-ын сонгуулийн үеэр манай аймагт сонгуулийн хороонд ажиллаж байсан МАХН, Эвслийн гишүүн хоёр нөхөр тохиролцоод зөврийн хайригаар санал авах хуудсаа тэнцүү тоогоор хувааж өөрийн намаас нэр дэвшигчдийн нэрийг дугуйлчихсан явдал гарсан /Увс, ХЭҮК-ын төлөөлөгчийн ярилцлагаас/.

УИХ хийгээд орон нутгийн сонгууль бол зөвхөн нам, эвслийн гишүүдийн сонгууль бус сонгуульд оролцох эрх бүхий бүх иргэдийн хүсэл зоригийн илэрхийлэл тул түүнийг эрхлэн явуулах сонгуулийн хороодыг байгуулах эрх зүйн орчинг боловсронгуй болгож, иргэдийн эрхийг тэгш, шударгаар хангах асуудал тулгамдсан шинжтэй болж байна.

Сонгуулийн хороодыг хуульд заасан хугацаанаас олон, цөөн хоногоор хоцроож байгуулах явдал түгээмэл байгаа нь судалгаанаас харагдаж байна.

Орон нутгийн сонгуулийн үйл ажиллагаанаас харахад сонгуулийн хэсгийн хороод хуульд заасан хугацаанаас даруй 9-13 хоног хэтэрч байгуулагдсан /Дундговь аймагт хийсэн судалгаанаас/.

Тойрог, хэсгийн хороодыг хугацаа хэтрүүлэн байгуулж буй нь хороодын гишүүд, ажил үүрэгтэйгээ танилцах, сонгуулийн хууль тогтоомжийг судлах зэрэгт муугаар нөлөөлж улмаар зөрчил гаргах нөхцлийг бүрдүүлж байна.

Сонгуулийн хороодыг байгуулах явцад гардаг өөр нэгэн хүндрэлтэй зүйл бол боловсон хүчний хомсдол, тэнд ажиллах хүмүүсийн сонгуулийн талаарх мэдлэг боловсрол, эдийн засгийн болоод эрх зүйн баталгааны тухай асуудал юм.

Жирийн иргэдийг сонгуулийн хороодын үйл ажиллагаанд татан оролцуулах арга хөшүүрэг хангалтгүй, ажиллах хүнийг зөвхөн нам эвслийн гишүүд, эсхүл

төр, төсвийн байгууллагад ажилладаг цөөн бүлэг хүмүүсээс үүсдэг байгаа эл хүндрэл зонхилон гардаг нь судалгааны явцад ажиглагдаж байлаа.

Ялангуяа орон нутгийн сонгуулийн үед хороод байгуулахад хамгийн бэрхшээлтэй асуудал нь чадварлаг, боловсролтой хүмүүс дутагддаг явдал байв.

Ялангуяа орон нутгийн сонгуулийн тойрог хэсгийн хороонд яг газар дээр нь ажиллаж байгаа хүмүүс асуудал шийдэх чадваргүй учир бүх юмаа дээд шатны хороо руу явуулахаас хугацаа алдагдаж, хүмүүс чирэгддэг. Мөн хийх ажлаа сайн мэддэггүй учраас алдаа гаргаж хүний эрх зөрчих тохиолдол их гардаг гэж судалгаанд оролцогчид тайлбарлаж байв.

Хэдийгээр хуульд сонгуулийн хорооны гишүүдэд сарын дундаж цалинтай нь тэнцэх хөлс, тэтгэвэрт байгаа хүнд, төсвөөс зохих урамшуулал олгохоор заасан байдаг боловч энэ нь хангалттай биш гэж тойрог, хэсгийн хороонд ажилласан хүмүүс үзэж байна.

Сонгуулийн хороодын гишүүдийн ажлын ачаалал их, өдөр бүр шөнө дөл хүртэл сууж ажилладаг төдийгүй амралтын өдрүүдээр ч ажиллахад хүрдэг. Гэтэл илүү цагийн хөлс, нэмэгдэл урамшуулал байдаггүй бөгөөд тодорхой ажил эрхэлдэггүй бол ямар нэг цалин хөлс олгогдоггүй.

Сонгуулийн хороонд /ялангуяа орон нутагт/ ажиллахад ямар нэг урамшуулал, хөнгөлөлт байхгүй учраас нэр дэвшигч, нам эвслийн нөлөө, бэлэг сэлтэд автагдахгүй гэх баталгаа байдаггүй.

Сонгуулийн хороодын үйл ажиллагаа

Санал хураах цаг хугацаа, байр, журмыг мэдээлэх

Сонгуулийн аливаа хэсгийн хорооны тэргүүн ээлжинд гүйцэтгэх үүрэг бол иргэдэд сонгуулийн санал хураалт явагдах байр, цаг хугацаа, журмыг бүгдэд нь хүртээмжтэй зарлан мэдээлэх явдал юм.

Сонгуулийн тойрог, хэсгийн хорооны зүгээс санал хураалтын цаг хугацаа, байр зэргийг хэрхэн мэдээлж ирсэн талаарх иргэдийн үнэлгээний судалгааг гаргасан болно.

Санал хураах цаг хугацаа, байр, журмыг мэдээлэх үйл ажиллагааны талаарх иргэдийн үнэлгээ

	УИХ-ын сонгууль		Орон нутгийн сонгууль	
Хангалттай	654	65,4	510	51,0
Дунд зэрэг	164	16,4	183	18,3
Хангалтгүй	69	6,9	83	8,3
Мэдэхгүй	113	11,9	224	2,4
Нийт	1000	100,0	1000	100,0

“Сонгох, сонгогдох эрхийн хэрэгжилтийн төлөв байдал” судалгаа НСХ 2004 он.

Сонгуулийн санал хураалт хаана, хэзээ явагдах талаар судалгаанд хамрагдсан иргэдийн 50-60 гаруйхан хувь нь хангалттай, эргэлзээгүй мэдээлэлтэй байсан нь анхаарал татах асуудлын нэг мөн.

сонсон орон нутгуудад дээрх үзүүлэлт харилцан адилгүй авч иргэдийн дунд санал өгөх байр, журмын талаар төдийлөн мэддэггүй байх нь нийтлэг тааралдаж байсан болно.

Саналаа хаана, хэрхэн өгөх талаарх сонгогчдын мэдлэг хангалтгүй байна. Тэд санал өгөх байрыг мэдэхгүй, бодвол хуучин өгдөгтөө л өгөх байхдаа гэжгээж байсан. Энэ нь тус аймагт цахилгаангүй харанхуй, олныг хамарсан сурталчилгаа явагдахгүй байгаатай холбоотой болов уу/Завхан аймаг, судлаачийн ажиглалтаас/.

Орон нутгийн хэвлэл, мэдээллийн хэрэгслээр гарах нийтлэлүүдэд нэр дэвшигчдийн сурталчилгаа зонхилж байсан боловч, иргэдийн сонгох, сонгогдох эрхийг нь тайлбарлан таниулах, сонгуулийн хуулийн иргэдтэй холбоотой, тэдний зайлшгүй мэдэх ёстой зүйл заалтуудыг сурталчлах талаар ямар ч зүйл яригдахгүй байлаа /Хөвсгөл аймаг, судлаачийн ажиглалтаас/.

Нийслэл хотын захын дүүргүүдэд УИХ-ын болон орон нутгийн сонгуулийн хэсгийн хороо санал хураалтын талаар сонгогчдод хангалттай мэдээлэл хүргэж чадаагүй байв. Баянзүрх, Сонгинохайрхан, Хан-Уул дүүргийн судалгаанд оролцсон 10 сонгогч тутмын нэг нь санал хураах цаг хугацаа, байр, журмын талаар тодорхой ойлголтгүй байв.

2004 онд явагдсан хоёр сонгуулийн үед хамгийн их маргаан дэгдээж, нэр дэвшигчдийн нэг нэгнээ буруутган зэмлэх үндэс болсон асуудлын нэг бол сонгогчдын нэрийн жагсаалт гаргах үйл явц байсан.

Сонгогчдын нэрийн жагсаалтыг гаргахад олон талын хүндрэл, бэрхшээл үүсч иргэдийн сонгох, сонгогдох эрхийг зөрчиж, хууль ёсыг гажуудуулах явдал байгаа нь судалгаагаар харагдаж байна.

Эдгээр зөрчил нь сум дүүрэг, хороо, багийн засаг дарга нарын, сонгуулийн хэсгийн хороодын, нэр дэвшигчид болон сонгогчдын үйл ажиллагаанаас болж гардаг.

Сонгогчдын нэрийн жагсаалтыг хуульд заасан журмын дагуу үйлдэх үүргийг хүлээсэн холбогдох шатны засаг дарга нар өөрсдийн албан үүрэгтээ хайхрамжгүй ханддагаас нэрийн жагсаалтыг үнэн зөв гаргаж, сонгуулийн хэсгийн хороонд хүргэх хуулийн хугацааг хэтрүүлэх, сонгогчдын нэр овог, хаяг, иргэний үнэмлэх, регистрын дугаарыг буруу бичих, шилжилт хөдөлгөөнийг цаг тухайд нь бүртгэж байгаагүйн улмаас байхгүй хүнийг жагсаалтанд оруулах, орох ёстой хүнийг орхигдуулах зэрэг хууль бус үйлдэл их хэмжээгээр гарч, нэрийн жагсаалтыг гаргаж танилцуулах журам, хугацааг зөрчих нь аль ч шатны сонгуулийн үед нийтлэг зөрчил байв.

Багийн засаг дарга нар сонгогчдын нэрийн жагсаалтыг хуулийн дагуу гаргаж өгөөгүй, сонгогчдын нэрийн жагсаалт сонгууль болохоос хоёрхон хоногийн өмнө л хагас дутуу бэлэн болж байв/Төв аймаг, судлаачийн ажиглалтаас/.

Ийм байдал бүх аймаг, Улаанбаатар хотод орон нутгийн сонгуулийн тойрог хэсэг дээр ямар нэг хэлбэрээр давтагдаж байсан.

Түүнчлэн судалгаанаас үзэхэд, бэлэн болсон гэх нэрийн жагсаалтад бүртгэгдсэн хүмүүсийн 30 хүртэлх хувьд ямар нэг зөрчил илэрч байсан бөгөөд нэр овог, иргэний үнэмлэх, регистрын дугаар буруу бүртгэгдэх, орхигдуулах зэрэг нь

тун түгээмэл төдийгүй зориудын шинжтэй байсныг тэмдэглэх нь зүйтэй.

Нэрийн жагсаалтад байсан 24 оюутны нэгнийх нь нэр буруу, бүгдийнх нь регистр, үнэмлэхний дугаар зөрж байсан/Ховд аймагт хийсэн бичиг баримтын судалгаанаас/.

Сонгуулийн Ерөнхий Хороонд УИХ-ын сонгуультай холбоотой өргөдөл гомдлын 7 хувь, орон нутгийн сонгуультай холбоотой өргөдөл гомдлын 25,4 хувь нь сонгогчдын нэрийн жагсаалттай холбоотой байв /СЕХороонд ирсэн өргөдөл гомдолд хийсэн судалгаанаас/.

Аймгуудад сонгогчдын нэрийн жагсаалтыг хаягаар тулган шалгаж үзэхэд, бараг бүх аймагт сонгогчийн нэрийн жагсаалтыг үнэн зөв гаргахтай холбоотой зөрчлүүд гарсан.

Эдгээрийг нийтэд нь авч үзвэл: нэрийн жагсаалтаас нас барсан, шилжин явагчдыг хасаагүй, байнгын оршин суугчдыг бүртгээгүй байх, нэрийн жагсаалтанд бичигдсэн хаяг оршин суугаа газрын хаяг хоёр зөрөх, нэг гэр бүлийн хүмүүсийг өөр өөр хаягаар бүртгэх нь элбэг тохиолдож байв.

...Бэлэн болгосон нэрийн жагсаалтаас 38 хүнийг сонгож уулзахад 3 нь иргэний үнэмлэхгүй, огт байхгүй 5 хүний нэрийг /нас барсан болон шилжсэн/ сонгогчийн жагсаалтыг оруулсан байлаа /Говь-Алтай аймагт хийгдсэн судалгаанаас/.

...Нэрийн жагсаалтаас 100 иргэнийг сонгон авч нэрсийн жагсаалттай тулган үзэхэд өөр газар шилжсэн 8, хаяг буруу буюу хаа байгаа нь мэдэгдэхгүй 16, хөдөө байгаа 3, үнэмлэхээ үрэгдүүлсэн 1, нийт 34 хүн зөрчилтэй байв /Говь-сүмбэр аймагт хийгдсэн судалгаанаас/.

...7-р тойргийн 178-р хэсгийн сонгогчдын нэрийн жагсаалтнаас 100 гаруй хүнийг түүвэрлэн шалгахад 22 иргэн зөрчилтэй /Баянхонгор аймагт хийгдсэн судалгаанаас/ байв.

...Сонгуулийн 48-р хэсгийн нэрийн жагсаалтыг шалгахад байнгын оршин суугч 22 хүн нэрийн жагсаалтанд байхгүй, нас бараад 1 жил болсон хүн нэрийн жагсаалтанд бүртгэгдсэн зэрэг зөрчлүүд илэрсэн /Дундговь аймагт хийгдсэн судалгаанаас/.

Мөн түүнчлэн сонгогчдын нэрийн жагсаалтыг үнэн зөв гаргахад оршин суугчдын зүгээс хаягийн бүртгэлээ цаг хугацаанд хийлгэдэггүй, засаг захиргаа завсардан амьдрах нь их байгаа нь сөргөөр нөлөөлж буйг тэмдэглэж байна.

Шилжин суурьшигчид болон оюутнууд зэрэг томоохон социаль бүлгийн хувьд сонгуульд оролцож, саналаа өгөх боломжгүй байгаа нь нэгэнт хэвшсэн зүйл болжээ.

Шилжин суурьшигсад, оюутнуудтай холбоотой асуудал ихэнх тойрог, хэсгийн хороод дээр байсан бөгөөд Дорнод, Баян-Өлгий, Эрдэнэт, Дорноговь, Төв аймагт харьцангуй олон гомдол гарч байлаа.

Нэр дэвшигчид элдэв амлалт өгөх, бэлэн мөнгө, архи, эд бараа тараах зэргээр сонгуулийн насны иргэдийг өөртөө татаж, олноор нь шилжүүлж, өөрийнхөө тойрогт санал өгүүлэх, эл үйлдэлд нь засаг дарга нар, сонгуулийн хороодын гишүүд хамсан оролцох нь ердийн үзэгдэл болжээ.

УИХ-ын 2004 оны сонгуульд нэр дэвшигчид хүмүүс зөөж, өөрийн төлөө санал өгүүлэх явдал тун нийтлэг байсан бөгөөд орон нутгийн сонгуульд ч ийм зөрчил байсныг судлаачид дурдаж байна.

Хэдийгээр Монгол Улсын Үндсэн хуульд /Арванзургадугаар зүйлийн 9/ иргэд

шууд буюу төлөөлөгчдийн байгууллагаар уламжлан төрийг удирдах хэрэгт оролцох, сонгох, сонгогдох эрхтэй гэж заасан боловч сонгуульд нэрээ дэвшүүлэх, бусдын нэрийг дэвшүүлэх боломжгүй шахам бөгөөд энэхүү эрх нь үнэн хэрэгтээ санал авах хуудсан дээрх нэр дэвшигчдийн аль нэгийг л дэмжих төдийгээр хязгаарлагдаж байна.

Улс төрийн намуудаас иргэдэд нэр дэвшигчийг санал болгон, түүнийг нь л иргэд сонгож байх ёстой мэтээр хүлээн авах сэтгэлгээ хүчтэй байгаа бөгөөд “Манай орны хувьд олон нам хэрэггүй хоёр нам байхад л болно. Чухамдаа гэвэл АН ба МАХН хоёр л яг болж байгаа юм” гэсэн сурталчилгаа сонгуулийн үеэр гарч байлаа.

Сонгуульд нэр дэвшүүлэхэд оршиж буй зөрчлийг сонгогчид дараах хууль бус үйл ажиллагаатай холбон тайлбарлаж буйг анхаарах шаардлагатай юм.

- Бүх ард түмний хүсэл зоригийн илэрхийлэл байх ёстой сонгуулийг ганц хоёрхон улс төрийн нам, тэдний удирдлагын сонирхлоор явуулж, хүний сонгох, сонгогдох эрхийг бүдүүлгээр зөрчиж байна.
- УИХ-ын болоод орон нутгийн сонгуульд нэр дэвшигчдийг сонгохдоо намуудын цөөн тооны удирдагчдын хүрээнд хувийн үнэнч байдал, хөрөнгө чинээний үзүүлэлт зэрэг тэвчишгүй шинжүүдийг шалгуур болгох явдал даамжирч байна.
- Иргэдийн сонгогдох эрх дан ганц улс төрийн намаас шууд шалтгаалдаг эрүүл бус тогтолцоо бий болж байгаа нь хүний эрхийн хэрэгжилтэнд сөрөг нөлөө үзүүлж байна.
- Орон нутгийн сонгууль чухамдаа нутгийн өөрөө удирдах ёсыг хэрэгжүүлэх үндсэн арга зам байх ёстой атал хэт улс төржүүлсэн, намын харьяалаар нь оршин суугчдыг хагаралдуулан зөрчилдүүлэх явдал гаарсан.
- Нөлөө бүхий улс төрийн намуудын дотоод ардчилал хангалтгүй, цөөн тооны удирдагчдыг даган хуваагдсан бүлэглэлүүдийн шинжтэй болсон нь нууц биш бөгөөд намын сахилга, эрх ашгийн нэр дор ард түмний язгуур ашиг сонирхлыг огоорох байдал түгээмэл байгаа нөхцөлд нэр дэвшигчдийг дэвшүүлэх механизмыг боловсронгуй болгох, иргэд, иргэний нийгмийн байгууллагуудын оролцоог нэмэгдүүлэх эрх зүйн орчинг бүрдүүлэх нь тулгамдсан асуудал болон гарч ирж байгаа гэж үзэж байна.

Иргэдийн сонгох, сонгогдох эрхээ ухамсартайгаар хэрэгжүүлэхэд олон хүчин зүйл нөлөөлдөг нь мэдээж боловч сонгуулийн сурталчилгаа онцгой байрыг эзэлдэг.

Сонгуулийн сурталчилгааг дотор нь нэр дэвшигчийн тухай мэдээлэл /сурталчилгаа/, сонгуульд оролцогч нам эвслийн сурталчилгаа гэж ангилж болох юм.

Сонгогчидод зайлшгүй шаардлагатай мэдээллийн нэг чухал хэсэг нь нэр дэвшигчдийн тухай мэдээлэл байдаг.

Сонгогчид УИХ-д нэр дэвшигчийн тухай мэдээллийг орон нутгийн

УИХ-ын сонгуульд нэр дэвшигчдийн талаарх мэдээллийн хүртээмж



“Сонгох, сонгогдох эрхийн хэрэгжилтийн төлөв байдал” судалгаа НСХ 2004 он.


ХҮНИЙ ЭРХ 2005/1

сонгуульд нэр дэвшигчдээс илүү ихээр хүлээн авдаг байна.

Иргэдийн олонхи нь буюу 63.4 хувь нь тус шатны сонгуульд нэр дэвшигчдийн талаарх мэдээлэл хангалттай авдаг гэсэн байхад дөнгөж 6 хан хувь нь энэ талын мэдээлэл хангалтгүй гэж үзсэн байна.

Харин орон нутгийн сонгуульд нэр дэвшигчдийн талаарх мэдээллийн хүртээмж доогуур түвшинд гарч байна.

Аймаг, нийслэлийн ИТХ-ын сонгуульд нэр дэвшигчдийн талаарх мэдээллийн хүртээмж



“Сонгох, сонгогдох эрхийн хэрэгжилтийн төлөв байдал” судалгаа НСХ 2004 он.

Сонгогчдын тал хүрэхгүй хувь нь аймаг, нийслэлийн сонгуульд нэр дэвшигчдийн талаар хангалттай мэдээлэлтэй байдаг гэж үзсэн байна.

10 сонгогч тутмын нэг нь эл шатны сонгуульд нэр дэвшигчдийн тухай мэдээллийг сонирхон хүлээдэггүй байхад харин түүнээс арай илүү хувь нь сонирхсон ч энэ талаар хангалттай мэдээлэл авч чаддаггүй гэжээ.

Аймаг нийслэлийн ИТХ-д нэр дэвшигчдийн талаарх мэдээллээр хангагдсан байдал

/орон нутаг хувиар/

Дүүргүүд	Хангалттай	Дунд зэрэг	Хангалтгүй	Өөрөө сонирхоогүй	Нийт
Сонгинохайрхан	57.9	21.4	13.5	7.1	100.0
Хан-Уул	42.1	27.8	15.9	14.3	100.0
Баянгол	58.4	28.8	7.2	5.6	100.0
Баянзүрх	32.8	39.2	16.0	12.0	100.0
Аймгууд					
Өмнөговь	59.8	27.4	7.7	5.1	100.0
Ховд	42.7	40.0	12.7	4.5	100.0
Дархан-Уул	45.9	30.8	17.0	6.3	100.0
Дорнод	32.1	34.8	14.3	18.8	100.0

“Сонгох, сонгогдох эрхийн хэрэгжилтийн төлөв байдал” судалгаа НСХ 2004 он.

Орон нутгийн сонгуулийн нэр дэвшигчдийн талаарх мэдээллийг УИХ-ын сонгуультай харьцуулахад иргэдэд хүрэх хэмжээний хувьд ч, иргэдийн зүгээс сонирхох хандлага ч харьцангуй бага байна.

Аймгуудын сонгогчдын хувьд зарим газарт 60 орчим хувь нь нэр дэвшигчийн тухай мэдээллээр хангагдсан байхад зарим газар тухайлбал: Дорнодод тун доогуур

Сонгох, сонгогдох эрхийн хэрэгжилт

үзүүлэлттэй, иргэд энэ талын мэдээллийг хүлээн авч чадахгүй байх нь нэлээд өндөр хувьтай байв. Санал асуулгын үр дүнгээс харахад дүүргүүдэд сонгогчдын 13-16 хүртэл хувь нь нэр дэвшигчдийн талаар огт хангалтгүй мэдээлэлтэй байсан.

Мөн түүнчлэн иргэд орон нутгийн сонгуульд ач холбогдол өгөх, анхаарлаа хандуулах нь бага байгаа нь харагдаж байна.

Нэр дэвшигчдийн талаарх мэдээлэл нь хүртээмжтэй, хангалттай байхаас гадна түүний агуулга нь бодитой үнэн байж чадах эсэх нь иргэдийн сонгох эрхээ хэрэгжүүлэхэд чухал ач холбогдолтой.

Нэр дэвшигчийн тухай мэдээллийн агуулгын талаарх иргэдийн үнэлгээ

Мэдээллийн агуулга	Хариултын тоо	Хувь
Нэр дэвшигчийг танилцуулах мэдээлэл байсан	522	52.2
Хов жив гүтгэлгийн шинжтэй зүйл байсан	102	10.2
Ихэвчлэн гутаан доромжлох зүйл байсан	29	2.9
Хэт өрөөсгөл, нэг нам хүчнийг дэмжсэн мэдээлэл байсан	186	18.6
Сонирхолтой олон талыг хамарсан мэдээлэл байсан	123	12.3
Өөр	38	3.8
Нийт	1000	100.0

“Сонгох, сонгогдох эрхийн хэрэгжилтийн төлөв байдал” судалгаа НСХ 2004 он.

Судалгаанд оролцогчдын 30 гаруй хувь нь сурталчилгааны үе дэх нэр дэвшигчдийн тухай мэдээлэл нь ямар нэг байдлаар хууль ёсны дагуу байж чадаагүй гэжээ. Тухайлбал: сонгогчдод ирсэн мэдээлэл хэт өрөөсгөл, нэг нам, хүчнийг

Дээрх үеэр халдсан	Танилцуулах зэргээс	Хов жив гүтгэлгийн шинжтэй зүйл	Ихэвчлэн гутаан доромжлох зүйл	Хэт өрөөсгөл, нэг нам хүчнийг дэмжсэн	Сонирхолтой олон талыг хамарсан	Өөр	Нийт
Сонгино-хайрхан	59.5	11.1	1.6	19.0	7.9	0.8	100.0
Хан-Уул	54.0	9.5	2.4	17.5	11.9	4.8	100.0

Бид хэд амьдардаг хумс хэср нарын сурталчилгаа адил хэср бид муулсан байдлаар явагдсан - Итгэмжлэгдсэн төлөөлөгчид. Шууд орж ирээд манай намд санал өгнө шүү гээд янз бүрийн юм ярьж ухуулж эхэлдэг /Өмнөговь аймаг. Бүлгийн ярилцлагаас/.

Сонгуулийн үеэр Засгийн эрх барьж буй нам эрх мэдлийн байдлаа ашиглан хэвлэл мэдээллийн хэрэгслийг давуу байдлаар эзэмшсэнээс үүдэн нэг нам, хүчний нэр дэвшигчийн тухай мэдээлэл сонгогчдод зонхилон хүрч, сонгуулийн сурталчилгаанд хэт өрөөсгөл байдал бүрдсэнийг олон нийт шүүмжилж байв.

Улс төрийн нам, хүчнүүд болон нэр дэвшигчид сурталчилгааны ажилдаа олон нийттэй харилцах хар ажиллагаа болох хов жив, гүтгэлэг, гутаах зэрэг үйлдлийг эрээ цээргүй, өргөн хүрээгээр хийх нь хүний эрхэд туйлын сөргөөр нөлөөлж байна.

Нэр дэвшигчийн талаарх мэдээллийн агуулгад иргэдийн зүгээс өгсөн үнэлгээг тэдний орон нутгийн харьяаллаар харвал доорх байдалтай байна.

Сонгуулийн үеэр нэр дэвшигчийн талаарх мэдээллийн агуулга



ХҮНИЙ ЭРХ 2005/1

Баянгол	56.8	7.2	4.8	11.2	15.2	4.8	100.0
Баянзүрх	53.6	12.0	3.2	16.8	12.8	1.6	100.0
Аймгууд							
Өмнөговь	65.8	2.6	.0	11.1	13.7	6.8	100.0
Ховд	41.8	9.1	1.8	33.6	13.6	.0	100.0
Дархан –Уул	42.8	13.8	3.8	20.8	14.5	4.4	100.0
Дорнод	44.6	15.2	5.4	19.6	8.0	7.1	100.0

“Сонгох, сонгогдох эрхийн хэрэгжилтийн төлөв байдал” судалгаа НСХ 2004 он.

Орон нутгууд дахь улс төрийн нам хүчнүүдийн хүчний харьцаа, тэнцвэргүй байдал, эрх мэдэл, албан тушаалаас нь хамаараад зарим нэр дэвшигчийн талаарх мэдээлэл нь хэт өрөөсгөл, нэг талыг барьсан шинжтэй байсан талаар иргэд шүүмжилж байна. Нийслэлийн Сонгинохайрхан, Хан-Уул, Баянзүрх дүүрэг, Ховд, Дархан-Уул, Дорнод зэрэг аймгуудад ийм зөрчил дутагдал харьцангуй их, нэр дэвшигчдийн талаар хэт өрөөсгөл, нэг талыг барьсан мэдээлэлтэй байсан гэж иргэдийн 16-аас 30 хүртэл хувь нь хариулсан.

Хэвлэл мэдээллийн хэрэгсэлээр сонгуулийн үеэр цацагдсан нийтлэлийн агуулгад хийсэн судалгааны дүнгээс харахад өрөөсгөл, гуйвуулсан, өрсөлдөгчөө гутаан доромжилсон мэдээллүүд их хэмжээгээр цацагддаг байна. Орон нутгийн сонгуулийн үеэр нийслэлийн телевизүүдээр гарсан сонгуулийн сурталчилгааны төрлүүдэд шинжилгээ хийснээс 66.7 хувь нь энгийн сурталчилгаа, 8.4 хувь нь нэр дэвшигчтэй хийсэн ярилцлага, 11.1 хувь нь мэдээ, мэдээлэл, 12.0 хувь нь нам хүчний захиалгат нэвтрүүлэг, 0.5 хувь нь мэдэгдэл байсан байна.

Тэдгээр нийтлэлийн төрлүүдээс агуулгын хувьд сонирхвол нэр дэвшигч нам хүчин, бие хүмүүсээс өөрсдийн талаар танилцуулах, мэдээлэх шинжтэй нь олонхи болж байгаа ч гүтгэх, гутаан доромжлох, нэр төрд нь халдах зорилгыг агуулсан тохиодлууд цөөнгүй тааралдсан юм.


2004 оны сонгуулийн үед нэр дэвшигчид өрсөлдөхдөө бие биенээ гүтгэх, доромжлох нь ердийн үзэгдэл болсон нь хүний эрхэд шууд халдсан үйлдэл болж байна.

Улс төрийн хүрээнд шударга бусаар өрсөлдөж, харилцан бие биенээ үгүйсгэх хийгээд гүтгэн доромжилсон үйлдлүүд нь /хар PR ч гэж ярьдаг/ иргэдийн дунд улс төрд үл итгэх байдлыг бий болгох төдийгүй иргэдийг зөв, бодит сонголт хийх боломжгүй болгох зэрэг сөрөг үр дагаврыг дагуулж байна.

Улс төрийн намуудын хувьд харилцан бие биенээ гүтгэх, доромжлох явдал сонгуулийн явцад цаг үргэлж гарч буй боловч нэр дэвшигчийн эрхийг зөрчсөн, үндэслэлгүйгээр гүтгэн доромжилсон үйлдлүүдэд хариуцлага хүлээлгэдэггүйн улмаас энэ зөрчил цаашид улам даамжрах төлөвтэй байна.

Сонгогчдын саналыг авахын тулд худал амлалт өгөх, сонгогчдыг хуурч мэхлэх, хууль бус аргыг их хэрэглэх болсон нь зүй ёсоор анхаарал татаж байна. Ялангуяа ийм хууль бус аргыг УИХ-ын сонгуулийн үеэр нэр дэвшигчид их хийх болсон. Сонгогчдын 34.4 хувь ийм байдал их гардаг гэж үзсэн. Харин орон нутгийн сонгуулийн үеэр худал ойлголт амлалт өгөх явдал УИХ-ын сонгуультай харьцуулахад харьцангуй бага гардаг боловч, бага гэж сонгогчид үздэг хэдий ч ийм явдал 18.9% байгаа нь анхаарал татах зүйл юм.

Сонгогчдын саналыг авахын тулд худал ойлголт амалт өгөх



“Сонгох, сонгогдох эрхийн хэрэгжилтийн төлөв байдал” судалгаа НСХ 2004 он.

Сонгуулийн ерөнхий хороонд 2004 онд ирсэн УИХ-ын сонгуультай холбоотой өргөдөл гомдлыг /600 орчим/ судалж үзэхэд сонгуулийн өмнөх, ухуулга, сурталчилгааны үеийн зөрчил бүртгэгдсэн байв.

Иргэдийн зүгээс сонгуульд нэр дэвшигчдийн худал амлалтанд шүүмжлэлтэй хандаж, дургүйцэх болсон нь судалгаанаас харагдаж байна.

Сонгуульд нэр дэвшигчид бодитой зүйлийг амлаж, цаашид амлалтаа хэрэгжүүлэх нь улс төрийн соёл төлөвших нэгэн чухал хүчин зүйл болно.

Худал, биелэгдэхгүй амлалт нь сонгогчдыг төөрөгдүүлж, зарим тохиолдолд итгэл үнэмшлийг бий болгон, тэдний сонголтонд нөлөөлдөг. 2004 оны УИХ-ын сонгуулийн үеэр худал биелэшгүй амлалтууд үнэхээр их гарч, өрсөлдөгч нам, эвсэл, нэр дэвшигчид хэн нь илүү худал амлаж чадахаараа уралдаж байсан гэж хэлэхэд нэг их хэлсдүүлсэн болохгүй юм.

Сонгуулийн сурталчилгааны явцад нэр дэвшигчид ятгах, ухуулах, гүтгэх, ажил төрөл бүтээж өгнө, сургуульд хүүхэд оруулж өгнө гэж амлах, буцалтгүй тусламж олгох зэрэг арга хэлбэрүүдийг ашиглаж байна. Тойрогт нь амьжиргааны түвшин тааруу өрхүүд байгаа бол хүнсний зүйл, мөнгө тараах гэр хорооллын айлуудын өрхийн хогийг ачих, оюутан хүүхдийнх нь сургалтын төлбөрийг хөнгөлөх, ажилгүй залуучуудыг мэргэжил курс дамжаанд хөнгөлөлттэй сургах зэрэг зүйлийг хийж байв /Орхон аймагт хийсэн ажиглалтын судалгаанаас/

Иргэдэд худал мэдээлэл өгөх явдал гарч байсан. Тухайлбал, Хөдөөгийн ядуурлыг бууруулж өсөлтийг дэмжих зээлийг нэр дэвшигч өгч байгаа мэтээр харуулах ярих явдал гарч байлаа /Булган аймагт хийсэн ажиглалтын судалгаанаас/

2004 оны УИХ-ын сонгуульд өрсөлдсөн хоёр гол хүчин болох МАХН ба “Эх орон - Ардчилал” эвслийн сонгуулийн мөрийн хөтөлбөрөөс одоо нэгэнт хоосон амлалт болсон зарим нэг амлалтыг дурдвал:

МАХН-ын мөрийн хөтөлбөрт:

- 145.000 ажлын байр шинээр бий болгох
- Анх удаа гэрлэж буй шинэ гэр бүлд нэг удаа 500.000 төгрөгийн буцалтгүй тусламж олгоно
- Шинээр мэндэлсэн хүүхэд бүрт нэг удаа 100.000 төгрөгийг тэднийг өсгөж бойжуулахад нь дэмжлэг үзүүлэх зорилгоор олгоно

ХҮНИЙ ЭРХ 2005/1

- 3 ба түүнээс дээш хүүхэдтэй өрхийг олон хүүхэдтэйд тооцон өргөтгөж, 1 өрхөд жилд 100.000 төгрөгийн буцалтгүй тусламж олгоно.

“Эх орон-Ардчилал” эвслийн мөрийн хөтөлбөрт:

- 18 хүртэлх насны бүх хүүхэд сар бүр 10.000 төгрөгийг олгоно.
- Хувьсгалт намын дарангуйлалын дарамтаас ангижирч улс төрийн бүх хүчнүүд улс орондоо иргэний нийгмийг бэхжүүлж, улс орноо хамтарч хөгжүүлнэ.
- Төрийн албанд танил тал, хамаатан саднаараа нэг удирдлагын дор ажиллаж, хууль завхруулдаг явдлыг таслан зогсооно.

Сонгогчдын саналыг худалдан авах, сонгогчдыг татах зорилгоор төлбөртэйгээр болон үнэ төлбөргүйгээр бараа тараах, тусламж олгох, урлаг спорт, ахуйн болон эрүүл мэндийн үйлчилгээ үзүүлэхийг хориглосон байдаг боловч ийм төрлийн зөрчил аль ч сонгуулийн үеэр хавтгайран гаарч, үнэн хэрэгтээ энэ нь сонгуулийн сурталчилгааны гол арга хэрэгсэл болсон.

Нэр дэвшсэн хүмүүс ихэнх нь бизнесмен хүмүүс байдаг. Тэд дандаа мөнгө төгрөгөөр цохиж ядарсан ард түмний саналыг худалдаж авч байна /Дархан-Уул аймагт хийсэн бүлгийн ярилцлагаас/.

Сонгогчдын саналыг худалдан авахыг оролдох байдлыг иргэдийн зүгээс хэрхэн үзэж буйг судалгаагаар харуулбал:

“Сонгох, сонгогдох эрхийн хэрэгжилтийн төлөв байдал” судалгаа НСХ 2004 он.

Хүснэгтээс харахад иргэдийн саналыг худалдан авахыг оролдох нь ихээхэн түгээмэл байдаг гэж 3 сонгогч тутмын нэг нь хариулжээ. Иргэдийн саналыг худалдан авах явдал нь өөрт нь буюу сайн мэдэх хүнээр, эсвэл танил талаар нь дамжуулан мөнгө төгрөг өгөх, бэлэг сэлт, ойр зуурын хэрэгсэл дурсгах, хүнс хувцас тараах, тусламжийн барааг олгох хэлбэрээр ихэвчлэн гарч байлаа.

Сонгуулийн сурталчилгааны үед санал худалдан авахын тулд нэр дэвшигчдийн зүгээс явуулсан үйл ажиллагаа “Танд болон танай гэр бүлд тохиолдож байсан уу?” гэсэн асуултад иргэдийн зүгээс дараах хариултыг өгсөн.

Нэлээд их гардаг
Бэлэн мөнгө өгөх
Бэлэн мөнгө гардуулах
Албан тушаал амлах
Найрч наадам цайл
урих

“Сонгох, сонгогдох эрхийн хэрэгжилтийн төлөв байдал” судалгаа НСХ 2004 он.

Судалгааны дүнгээс харахад нэр дэвшигчийн зүгээс сонгогчдын саналд нөлөөлөх буюу худалдан авах зорилгоор хувь хүнийг найр наадам, дайллага, цайллагад урих нь ихээхэн түгээмэл байгаа ба бэлэг сэлт гардуулах /7.2%/ , бэлэн мөнгө өгөх /6.8%/ , албан тушаал амлах /3.6%/ зэрэг хууль бус үйлдлүүд ч гарсаар байгаа юм.

Сонгуулийн сурталчилгаанд төрийн өмч хөрөнгө, төсвийн мөнгийг ашиглах, төрийн албан хаагчид нэр дэвшигчдийн сурталчилгааг хийх бас их түгээмэл байлаа.

Төрийн алба хааж буй нэр дэвшигчид албаны машин, утас, байрыг сурталчилгаа хийхдээ ашиглах, сурталчилгаандаа томилолтын зардал авах, төсвийн мөнгөөр сурталчилгаа хийж буйг судалгааны дүн, сонгогчдын санал, шүүмжлэл харуулж байна.

Нэр дэвшигчдийн сурталчилгаанд төрийн өмч хөрөнгө, төсвийн мөнгийг зарцуулж буй эсэх тухай санал асуулгаас:

	УИХ		Орон нутгийн сонгууль	
Их гардаг	248	24.8%	177	17.7%
Ер нь гардаг	240	24%	231	23.1%
Хааяа гардаг	182	18.2%	203	20.3%
Гардаггүй	323	32.3%	371	37.1%
Хариулаагүй	7	0.7%	18	1.8%

“Сонгох, сонгогдох эрхийн хэрэгжилтийн төлөв байдал” тоон судалгаа НСХ 2004 он.

Иргэдийн хариултаас харахад төрийн өмч хөрөнгө, төсвийн мөнгийг сонгуулийн сурталчилгаанд хууль бусаар ашиглах явдал УИХ-ын сонгуулийн үед гардаг гэж иргэдийн бараг тал хувь /48.8%/ нь үзжээ.

Энэ хувь хэмжээ орон нутгийн сонгуулийн үеэр ч мөн адил /40.8%/ байгааг тэмдэглэх нь зүйтэй.

Өнгөрсөн сонгуулиудын сургамжаас харахад нэр дэвшигчдийн сонгуулийн сурталчилгаанд төрийн байгууллагын ажилтнууд оролцож, үндсэндээ зарим байгууллагын үйл ажиллагаа нэр дэвшигчийг сонгуульд ялуулахад чиглэгдэж байсан.

...МАХН-аас нэр дэвшигчид бараг 100% төрийн болон төсвийн, ААН байгууллагуудын дарга, удирдах ажилтнууд байсан учраас сонгуулийн сурталчилгаанд албан тушаалаа дээд зэргээр ашиглаж, 10-р сарын 1-нээс эхлэн Зуунмод сумын ЗДТГ нь дежур, үйлчлэгчдээс өөр ажилтангүй, бүгд 27 суманд хуваагдан сонгуулийн сурталчилгаанд ажилласан байна /Төв аймагт хийсэн судалгааны дүнгээс/.

Төрийн байгууллагын ажилчдыг дайчлан ажиллуулах явдал УИХ-ын сонгуулийн үеэр болон орон нутгийн сонгуулийн аль алинд их байдаг /47.7 ба 41.7 хувь/ гэж иргэд үзсэн. Төрийн байгууллагын ажилчид нэр дэвшигчдийн сурталчилгаанд ажиллах хэлбэр нь янз бүр байна.

Зарим нь өөрийн албан тушаал, эрх мэдлийн хүрээнд зайлшгүй үзүүлэх ёстой төрийн үйлчилгээг иргэдэд хүргэхдээ дэмжиж буй нэр дэвшигч дээрхийг хийсэн мэтээр олон нийтэд ойлгуулан сурталчилгаандаа ашиглах тохиолдол байдаг

/төсвийн мөнгөөр зам тавих, цалин тэтгэврийг олгох, ОУ-ын тусламж дэмжлэгийг өөрийн биеэр сонгогчдод тараах гм/.

Түүнчлэн сүүлийн үед гарч буй сонгуулийн үе дэх нэгэн булхайт үйлдэл бол өөрийн удирдлагад байдаг төрийн байгууллагын албан тушаалтнуудыг нэр дэвшиж буй тойрогтоо ажиллуулах нэрийдлээр санал өгүүлэх явдал юм. Ийм зөрчил өмнөх УИХ-ын сонгуулиар нэлээдгүй тохиолдож байсныг СЕХ-нд ирсэн зөрчил, гомдлын баримтууд нотолдог.

Б. Сонгуульд санал авах үе шат

Сонгогчид саналаа гадны нөлөөгүй, бие дааж, өөрийн дотоод итгэл, үнэмшлээр өгч чадаж буй эсэх нь сонгуулийн ажлын хамгийн чухал хэсэг болно. Сонгуульд санал өгөх үе шатанд иргэдийн сонгох эрхийн хэрэгжилтэнд сөргөөр нөлөөлж, эрхийг нь зөрчиж буй байдлууд байгааг судалгаа, ажиглалтын дүн харуулж байна.

Сонгууль болох өдөр санал өгөх байранд саналаа өгөхөөр ирсэн зарим сонгогчийн хувьд дараах саад бэрхшээлүүд гардаг. Үүнд:

- Сонгогчдын нэрсийн жагсаалтанд нэр нь байхгүй
- Сонгогч саналаа өгөөгүй байхад “санал өгсөн байна” - гэдэг үндэслэлээр саналын хуудсыг өгдөггүй
- Сонгуулийн хэсгийн хорооны ажилтны зүгээс санал өгөхөд нь нөлөөлөхийг оролддог
- Намуудын ажиглагчдын зүгээс нөлөөлөхийг оролддог
- Тамга тэмдэггүй, сонгуулийн хэсгийн хорооны дарга, нарийн бичгийн даргын гарын үсэггүй саналын хуудсаар санал авсан зэргийг дурдаж болно. Ийм зөрчил нь 2004 оны Улсын Их Хурлын болон орон нутгийн сонгуулийн үеэр ихээхэн нийтлэг шинжтэй байсан.

Нийгмийн судалгааны хүрээлэнгээс 1000 хүний дунд хийсэн судалгаагаар судалгаанд оролцогчдын 118 нь /11.8 хувь/ санал өгөхөд нөлөөлөхийг оролдсон, 65 нь /6.5 хувь/ нэрийн жагсаалтанд нэр нь байхгүй байсан, 11 нь /1.1 хувь/ тамга тэмдэггүй, хэсгийн хорооны дарга, нарийн бичгийн даргын гарын үсэггүй хуудсаар санал өгүүлсэн гэж хариулсан нь зүй ёсоор анхаарал татаж байна.

Санал өгөх байр, кабины байршил, тоноглол нь сонгогч саналаа нууцаар, бусдын хараа хяналт, нөлөөлөөс ангид гаргах боломжийг тэр бүр олгохгүй байгаа, зарим тохиолдолд сонгогч аль нэр дэвшигчийн төлөө саналаа өгч байгаа нь ил харагдах нөхцөл байдалтай байсныг судлаачид шүүмжилж байна.

Зөврийн хайрцагаар санал авахад ихээхэн хэмжээний зөрчил гарч байсан нь 2004 оны сонгуулиудын нэг онцлог байв.

Сонгуулийн хэсгийн хороод зөврийн хайрцагаар санал авах сонгогчдын нэрийг урьдчилж гаргадаггүй, зарим тохиолдолд зөврийн хайрцагаар санал авах шаардлагагүй сонгогчдоос оролцогч намуудын ажиглагчидгүйгээр, эсхүл аль нэг намын ажиглагчийг оролцуулахгүйгээс болж үлэмж хэмжээний санал, гомдол, зөрчил гарч байв.

ЭРҮҮ ШҮҮЛТЭЭС ХАМГААЛАХ НЬ ТӨРИЙН ҮҮРЭГ

Ж.Дашдорж,
ХЭҮК-ын гишүүн

Эрүү шүүлтийн тухай ойлголт, олон улсын эрх зүйн систем бүрэлдэн тогтсон нь

Эрүүдэн шүүхийн тухай асуудал нь хүн төрлөхтний хөгжил дэвшлийн явцад хүн өөрөө бий болгон хэрэглэж ирсэн хүний эрхийн хамгийн ноцтой зөрчил мөн. Тухайн улс орны түүхэнд гарч байсан эрүү шүүлт нь улс орны нийгэм, улс төрийн нөхцөл байдалтай нягт уялдаа холбоотойгоор тус тусын өвөрмөц шинж чанартай байсан.

Монгол Улсын түүхэнд гэхэд л 1921 оны Ардын Хувьсгалаас өмнөх үеүдэд эрүү шүүлтийг аливаа хэрэг маргааныг таслан шийтгэх гол арга болгон хэрэглэж байсан.

Энэ нь түүхэнд “9 эрүү тулгах” хэмээн нэрлэгдэж биеийн болон сэтгэл зүйн 13 төрлийн эрүү шүүлтийн аргыг багтааж байжээ.

1921 оны Ардын Хувьсгалаас хойш эрүү шүүлтийг халах, эрх зүйн үндсийг бүрдүүлж ирсэн байдаг. Монгол Улсын удаа дараагийн Үндсэн хууль, Эрүүгийн байцаан шийтгэх хуулиудад эрүү шүүлтийг хориглож гэмт хэрэг хэмээн үзэж ирсэн.

Тэгсэн хэдий ч эрүүдэн шүүх үйл ажиллагаа бүрэн арилаагүй өдийг хүрсэн. Ялангуяа 1930, 1940 оны үеийн их хэлмэгдүүлэлтийн үед улс төрийн хэргийг мөрдөн байцаах гол арга нь эрүү шүүлт хэрэглэж хэрэг тулган хүлээлгэх явдал байжээ.

Эрүүдэн шүүх явдал нь арьсны өнгөөр, яс үндсээр, улс төрийн үзэл бодлоор нь ялгаварлан гадуурхахад хамгийн нийтлэг хэрэглэгдэж, Дэлхийн 2-р дайны үед нууц албаныхны хэрэглэж байсан эрүү шүүлт эрс хэрцгий байжээ.

Эрүү шүүлтэд өртөж, зовлон зүдгүүр амссан улс орнуудын туршлага эрүү шүүлттэй дэлхий нийтээрээ хамтран тэмцэхэд хүргэсэн.

1945 онд НҮБ байгуулагдаж, НҮБ-ын Ерөнхий Ассамблейгаас “Хүний Эрхийн Түгээмэл Тунхаглал”-ыг баталсан нь хүн төрөлхтөн эрүү шүүлтийн эсрэг хамтран тэмцэх эхлэл нь болсон.

Энэхүү Тунхаглалд “Хэнд ч эрүү шүүлт тулгах буюу хэрцгий хүний ёсноос гадуур эсхүл нэр төрийг нь доромжлон харьцаж, шийтгэхийг хориглоно” гэж заасан. Энэхүү заалт нь улс орнуудад уриалсан тунхаглалын шинжтэй байсан тул улс орнууд нэгдэн орж, биелүүлэх үүрэг хариуцлага хүлээдэг Иргэний болон улс төрийн эрхийн тухай олон улсын Пактад энэ заалтыг тусгаж өгсөн байна. Уг Пакт 1966 онд батлагдаж, 2002 оны байдлаар 148 улс орон /Монгол Улс 1974 онд нэгдсэн/ нэгдэн оржээ.

Тунхаглал болон Пактын энэхүү заалт улам бүр өргөжиж, 1984 онд Эрүүдэн шүүх болон бусад хэлбэрээр хэрцгий, хүнлэг бусаар хүний нэр төрийг доромжлон харьцах, шийтгэхийн эсрэг бүхэл бүтэн Конвенци болон гарсан.

Уг Конвенцид одоогийн байдлаар 130 орчим улс орон нэгджээ. Үүнээс үзвэл эрүү шүүлтийн тухай асуудал улам бүр хурцаар тавигдаж байна. Энэхүү Конвенци

нь эрүү шүүлтийн тухай тодорхойлолтыг өгөөд зогсохгүй түүнтэй тэмцэх, хохирогчдыг хамгаалах талаар улс орнуудад юу хийхийг заасан чухал баримт юм.

Түүнчлэн эрүү шүүлтэй тэмцэх чиглэлээр бүс нутгийн хэмжээнд гаргасан баримт бичиг цөөнгүй байна. Тэдгээрээс дурьдвал “Эрүү шүүлт, хүнлэг бүс хэрцгий, хүний нэр төрийг доромжлон харьцах, шийтгэхээс урьдчилан сэргийлэх тухай” 1987 оны Европын Конвенци, “Эрүү шүүлтээс урьдчилан сэргийлэх, устгах тухай” 1985 оны Америкийн улсуудын Конвенци зэргийг дурьдаж болно. Дээр дурьдсан бүх баримт бичгүүд нийлээд эрүү шүүлтэй тэмцэх, түүнээс урьдчилан сэргийлэх олон улсын эрх зүйн системийг бүрдүүлж байна.

Эрүүдэн шүүх гэж юу вэ? Эрүүдэн шүүхийн эсрэг Конвенцид зааснаар “эрүүдэн шүүх” гэдгийг “Хэн нэг хүн буюу гурав дахь этгээдээс мэдээ сэлт, мэдүүлэг авах, тухайн хүн буюу гурав дахь этгээдийн үйлдсэн буюу сэрдэгдсэн хэрэгт шийтгэх, айлган сүрдүүлэх, шахалт үзүүлэх, аливаа байдлаар алагчлах зорилгоор төрийн албан тушаалтан, албан үүрэг гүйцэтгэж буй бусад хүний өдөөн хатгалт, ил, далд зөвшөөрлөөр тухайн хүн буюу гуравдахь этгээдийн бие махбодь, сэтгэл санааг хүчтэй шаналган зовоох аливаа санаатай үйлдлийг хэлнэ”¹ гэжээ.

ХЭҮК, Эмнести Интернейшнл байгууллагын Монгол дахь салбараас орчуулан хэвлүүлсэн “Эрүү шүүлтэй тэмцэх нь” гэсэн номонд “эрүүдэн шүүх” гэж – “төрийн албан тушаалтан, албан үүрэг гүйцэтгэж буй этгээд өөрөө эсхүл түүний өдөөн хатгаснаар буюу ил, далд зөвшөөрснөөр хэн нэг этгээдийг өөрөөс нь буюу гуравдахь этгээдээс мэдээлэл авах, хэрэг хүлээлгэх, үйлдсэн буюу үйлдсэн гэж сэжиглэгдэж буй хэрэгт нь шийтгэх, айлган сүрдүүлэх аливаа үндэслэлээр ялгаварлаж гадуурхах шалтгаанаар бие махбодь, сэтгэл санааны хувьд санаатайгаар хүчтэй өвтгөх, шаналгах аливаа үйлдлийг ойлгоно”² гэж тодорхойлжээ.

Энэхүү тодорхойлолтыг задлан авч үзвэл:

1 дүгээрт: Эрүү шүүлтийг хэн үйлдэж болох

2 дугаарт: Ямар зорилгоор үйлдэж болох

3 дугаарт: Ямар үйлдлийг эрүү шүүлт гэж үзэх вэ

4 дүгээрт : Хэн эрүү шүүлтэд өртөж болох вэ гэсэн 4 багц асуудал гарч ирнэ.

Эдгээр хоёр тодорхойлолтод зааснаар эрүү шүүлтийг төрийн албан тушаалтан буюу албан үүрэг гүйцэтгэж буй этгээд, эсвэл түүний зөвшөөрөл, шахалтаар төрийн албан тушаалтан бус этгээд үйлдэж болохоор ойлгогдож байна.

Төрийн албан тушаалтан гэдэгт манай улсын хууль тогтоомжид зааснаар хэрэг бүртгэх, мөрдөн байцаах, нэг ёсондоо бусдаас /гэмт хэрэгт холбогдогч, гэрч, хохирогч/ мэдүүлэг авах эрх бүхий албан тушаалтан хамаарна. Үүнд:

Цагдаагийн байгууллагын хэрэг бүртгэгч, мөрдөн байцаагч, эрүүгийн төлөөлөгч, ТЕГ-ын тусгай албаны ажилтан, хэрэг бүртгэгч, мөрдөн байцаагч хамаарна. Эдгээр албан тушаалтан эрүүдэн шүүх үйл ажиллагааг өөрөө гардан гүйцэтгэсэн эсвэл бусдад даалгавар, зөвшөөрөл өгч гүйцэтгүүлсэн аль ч тохиодолд эрүү шүүлтийг үйлдсэнд тооцно.

Төрийн албан тушаалтны даалгавраар эрүү шүүлтийг гүйцэтгэсэн энгийн хүмүүс тухайн үйл ажиллагаандаа холбогдох хуулиар хариуцлага хүлээнэ.

¹ Төрийн мэдээллийн тусгай дугаар I боть-109 хуудас

² “Эрүү шүүлтэй тэмцэх нь” гарын авлага

2002 онд Монгол Улсын Их Хурлын Хууль зүйн байнгын Хороо УЕП-ын газарт даалгавар өгч, шалгалт хийлгээд дүнг нь хэлэлцэн тогтоол гаргахдаа “Ганц худагт хоригдогсдыг өрөө дамжуулан хорьж, давтан гэмт хэрэг үйлдсэн, удаан хугацаагаар хоригдсон хүмүүсийн өрөөнд оруулж тэднээр зодуулах зэргээр дарамт шахалт үзүүлдэг нь зарим эрүүгийн төлөөлөгчийн хэрэг хүлээлгэх арга болсон байна” гэж дүгнэжээ. Энэ нь эрүүгийн төлөөлөгчид эрүү шүүлтийг давтан гэмт хэрэг үйлдэгчид, удаан хугацаагаар хоригдогсдоор дамжуулан зориуд гүйцэтгүүлснийг нотлох баримт мөн.

Эрүү шүүлтийг үйлдэгч нь төрийн өөр бусад албан тушаалтан байхыг үгүйсгэхгүй. Тухайлбал, цагдаагийн байгууллагын удирдлага, прокурор, шүүгч, хорих газрын албан тушаалтан, төрийн албан тушаалтан хуулиар олгогдсон эрх мэдлээ хэтрүүлэх, урвуулан ашиглах аль нэг хэлбэрээр энэ үйлдлийг үйлддэг. Эсвэл эрүүдэн шүүх даалгавар өгсөн өөр албан тушаалтан байхыг үгүйсгэхгүй.

Эрүүдэн шүүх үйл ажиллагааны хохирогч нь хэн байж болох вэ? Эрүүдэн шүүх ажиллагаанд хэрэгт холбогдогч буюу сэжигтэн, яллагдагч, шүүгдэгч, хорих ял эдэлж буй этгээд, гэрч, зарим тохиолдолд гэмт хэргийн хохирогч байж болно. Эрүү шүүлтийн хохирогч нь хэн байх нь зарчмын ач холбогдолгүй.

Эрүү шүүлтийн зорилго нь аливаа гэмт хэргийн талаар мэдээлэл, мэдүүлэг авах, хэрэг хүлээлгэх, улмаар тэр гэмт хэрэгт нь шийтгэхэд чиглэгддэг. Хэрвээ төрийн албан тушаалтан ийм зорилго агуулаагүй бол эрүү шүүлтийн тухай асуудал яригдахгүй.

Харин төрийн албан тушаалтан зорилгодоо хүрсэн эсэх нь өөрөөр хэлбэл авахыг хүссэн мэдээллээ авч чадсан эсэх, хэргээ хүлээсэн эсэх нь ач холбогдолтой биш.

Түүнчлэн эрүү шүүлтэд өртөгч үнэн хэрэгтээ үйлдсэн буюу үйлдээгүй хэрэгтээ эрүүдэн шүүгдсэн эсэх нь ч хамааралгүй бөгөөд энэ утгаараа хэрэгт холбогдогч өөрийнхөө эсрэг мэдүүлэг өгөхгүй байх эрхтэй байдаг.

Бие махбодь, сэтгэл санааг хүчтэй шаналган зовоох үйлдлийг дэлгэрүүлэн тайлбарласан аливаа хэмжүүр тогтоосон баримт бичиг одоогоор байхгүй байна.

Конвенци болон Монгол Улсын хууль тогтоомжийг судлан үзвэл эрүүдэн шүүх үйл ажиллагаанд хамаарч буй “бие махбодь, сэтгэл санааг хүчтэй шаналган зовоох” гэдэг ойлголтод нэг удаагийн буюу удаа дараа давтагдсан байнгын шинж чанартай үйлдлийн аль аль нь хамаарна.

Бие махбодийг хүчтэй шаналган зовоох гэдэгт бие эрхтэнд нь халдаж зодох, гэмтээх, тамлах зэргээр бие эрхтэнд нь өвдөлт, зовлон шаналгаа үүсгэх, хүчиндэх зэргийг ойлгодог байна. Харин сэтгэл санааг нь хүчтэй шаналган зовоох үйлдэлд биеийн хүчирхийллээр бус үг хэллэг, тодорхой үйлдлээр заналхийлэх, айлган сүрдүүлэх зэрэг үйлдлүүд орно.

Эрүү шүүлтээс хамгаалах арга хэрэгслүүд

Эрүүдэн шүүхийн эсрэг Конвенцид нэгдэн орсон улс орнууд эрүү шүүлтээс урьдчилан сэргийлэх шаардлагатай бүхий л арга хэмжээг авахыг даалгасан байдаг. Эдгээр арга хэмжээнүүдэд:

1. Нууцаар хорихгүй байх
2. Өмгөөлөгч авах эрх

3. Өөрийн хүссэн эмчээр эрүүл мэндийн үзлэг хийлгэх эрх
4. Хоригдсон тухайг нь ар гэрийхэнд нь мэдэгдэх
5. Гадаад орчинтой холбогдох боломж олгох, төрөл төрөгсөдтэйгээ уулзах, баривчлагдсан, цагдан хоригдсон этгээдийг хүлээн авах, шилжүүлэх, тээвэрлэх зохицуулалтыг боловсронгуй болгох зэрэг арга хэмжээнүүдийг хамааруулж болно.

Нууцаар хорихгүй байх: Эрүү шүүлтийг гаргахгүй байх нэг гол баталгаа бол нууцаар хорихгүй байх өөрөөр хэлбэл хуулиар зөвшөөрөгдөөгүй газар, ямарваа нэгэн хөндлөнгийн /прокурор, шүүхийн/ хяналтгүйгээр хорих явдлыг гаргахгүй байх явдал мөн. Монгол Улсын “Сэжигтэн, яллагдагчийг албадан саатуулах, цагдан хорих шийдвэрийг биелүүлэх журмын тухай хууль”-ийн 7-р зүйлд: “Цагдан хорих байр байгуулах, өөрчлөх, татан буулгах асуудлыг аймаг, нийслэлийн Засаг дарга, ШШБЕГ-ын саналыг үндэслэн хууль зүйн асуудал эрхэлсэн Засгийн газрын гишүүн Улсын ерөнхий прокурортой зөвшилцөн шийдвэрлэнэ” гэж заасан.

Энэ журмаар байгуулаагүй аливаа орон байранд хорихыг **хууль бус** газар гэж үзэх бөгөөд ийм газар хоригдох нь аливаа хяналтын гадуур байдаг тул ямагт эрүүдэн шүүх, хэрэг тулган хүлээлгэх хууль бус арга хэрэглэхэд тохиромжтой нөхцөл болдог.

Өмгөөлөгч авах эрх: Эрүүгийн аливаа хэрэгт сэжиглэгдсэн, баривчлагдсан хэн боловч өмгөөлөгч авах, эрх зүйн туслалцаа хүсэх эрхтэй байдаг. Энэ эрхийг нь хэдий чинээ сайн хангана тэр хэмжээгээр аливаа хууль бус үйл ажиллагаа, эрүү шүүлтээс сэргийлж болно гэж үздэг. Тухайлбал, сэжигтэн өмгөөлөгч авах, зөвхөн өмгөөлөгчтэй байцаалт өгөх хүсэлт гаргасан нөхцөлд түүний хүсэлтийг заавал хангах ёстой.

Манай өнөөгийн ЭБШ хуулийн 59-р зүйлд сэжигтнийг баривчилсан тохиолдолд түүнд тогтоолыг танилцуулах ба өмгөөлөгчийн хамт мэдүүлэг өгөх эрхтэй болохыг тайлбарлаж, энэ тухай тэмдэглэлд тусгана гэж заасан. Энэ нь зарчмын ач холбогдолтой чухал заалт хэдий ч ямар хэмжээнд хэрэгжиж байгаа нь анхаарал татна.

ЭБШ хуулинд өмгөөлөгчийг хэдий үеэс оролцуулах тухай нарийвчлан зохицуулсан заалт байхгүй байна. Хуулийн 40-р зүйлд өмгөөлөгч заавал оролцуулах 5 тохиолдлыг заасан ба зөвхөн цаазаар авах ял оногдуулж болох хэрэгт заавал өмгөөлөгч оролцуулна гэж заажээ. Бусад 4 заалт нь хэрэгт холбогдогчийн хувийн байдалтай холбоотой байна.

Гэхдээ энэ заалтаас чухам хэдий үеэс өмгөөлөгчийг заавал оролцуулах нь тодорхой биш байна. Иймээс сэжигтэн, яллагдагчийн өмгөөлөгч авах эрх нилээд хожуу хэрэгждэг нь ажиглагдана.

ХЭҮК-ын 2002 оны илтгэлд “Ганц худагт хоригдсон 619 хүний 80 орчим хувь нь огт өмгөөлөгч аваагүй байв” гэж тэмдэглэгджээ. Энэ үзүүлэлт нь өмгөөлөгч авах эрх зүйн хамгаалалт ямар байгааг харуулж байна.

Өмгөөлөгч заавал оролцуулах болон хэдий үеэс оролцуулахыг нарийн зохицуулах шаардлагатай байна.

Өөрийн хүссэн эмчээр эрүүл мэндийн үзлэг хийлгэх боломжоор хангах нь эрүү шүүлтээс сэргийлэх, эрүү шүүлт явагдсан тохиолдолд түүний ул мөрийг

бэхжүүлэх гол нөхцөл болдог.

Сэжигтэн яллагдагчийг албадан саатуулах, цагдан хорих шийдвэрийг биелүүлэх журмын тухай хуулийн 25-р зүйлд: "... хоригдсон этгээд, түүний өмгөөлөгчийн хүсэлтээр эмнэлгийн үзлэгийг ердийн байгууллагаар хийлгэж болно" гэж заасан.

Энэ нь хоригдсон этгээд аливаа хууль бус үйлдлийн улмаас бие эрхтэндээ авсан гэмтэл, шарх, сорви, ул мөрийг шударгаар тогтоох боломжийг бүрдүүлсэн заалт мөн. Гэвч ийм хүсэлт гаргах тохиолдол ховорхон байдаг ба үзлэгийг ихэвчлэн хорих байрны эмнэлгийн ажилтнууд хийдэг. Хоригдогсод энэ эрхийг тайлбарлах, тийм хүсэлт гаргасныг нь цаг тухайд нь бүртгэх, биелүүлэх зэрэг асуудлыг нарийн зохицуулж хяналт тавих нь чухал юм.

Хоригдогсод өөрийн хүссэн эмчээр буюу ердийн эмнэлгийн ажилтнаар үзлэг хийлгэх хүсэлт гаргах эрх нь хорих газрын эмч нарыг үгүйсгэж буй хэрэг огт биш юм. Хорих газрын эмч нарын шударга ажиллах, элдэв дарамт шахалтаас ангид байх баталгаа бүрдсэн, тэдэнд итгэх итгэл баттай болсон, тэд шударга ажиллаж чадаж байсан нөхцөлд ийм хүсэлт бага гарна.

Эмч нь үзлэг хийх явцад тухайн этгээдэд бие махбодид нь хүчирхийлэл үйлдсэн шинж, ул мөр илэрсэн тохиолдолд хойшлуулшгүй шуурхай арга хэмжээ авах, холбогдох албан тушаалтанд мэдээлэх, шалгуулах мэдлэг, чадварыг эзэмшсэн байх ёстой.

Эмчийн үзлэг нь эрүүдэн шүүсэн үйл ажиллагааг мөрдөн шалгах, гэм буруутанд хариуцлага хүлээлгэхэд чухал нотлох баримт болдог.

Хоригдогсод нь гадаад орчинтой холбогдох, гэр бүлийн гишүүн, төрөл төрөгсөдтэйгээ уулзах боломжоор хангагдах нь эрүү шүүлтээс сэргийлэх бас нэг хамгаалалт болдог. Өөрөөр хэлбэл түүний гэр бүлийн гишүүн, төрөл төрөгсөд нь тухайн хүнтэй уулзах боломжтой байх нь түүнийг мөрдөн шалгаж буй үйл ажиллагаа хууль ёсны дагуу явагдаж байгаа эсэхэд хяналт тавих боломж олгодог гэж үздэг. Хоригдож буй этгээдэд өөрийнх нь эсрэг хийж буй аливаа үйлдлийг ил гаргаж тавих, санал гомдлоо гаргах, шалгуулах эрхээ хэрэгжүүлэхэд уулзалт, эргэлтийг тогтмол байлгах нь ач холбогдолой гэж үздэг.

Сэжигтэн, Яллагдагчийг Цагдан хорих шийдвэрийг биелүүлэх журмын тухай хуулийн 19-р зүйлд: "Хоригдсон этгээдийг хорих шийдвэр гаргасан албан тушаалтан буюу түүний удирдах дээд албан тушаалтны бичгээр олгосон зөвшөөрлөөр төрөл төрөгсөд болон бусад хүмүүстэй уулзуулж болно" гэж тусгасан. Энэ заалтыг одоогийн мөрдөж буй хуулийн заалтаар авч үзвэл шүүгч байж болохоор байна.

Гэвч мөрдөж буй журам, практикаас үзвэл зөвшөөрлийг зөвхөн хэргийг мөрдөж байгаа мөрдөн байцаагч, хэрэг бүртгэгч өгч байгаад дүгнэлт хийх ёстой. Зөвшөөрлийг хэрэг мөрдөж буй эрүү шүүлт, зүй бус харьцаа үйлдэж болзошгүй этгээд өгч байгаа нь эргэлзээ төрүүлнэ.

Эрүүдэн шүүх болон зүй бус харьцаа гаргасан албан тушаалтан энэ үйлдлээ аль болох нуух, бусдад мэдэгдэхээс болгоомжлох, түүнийг аль болох төрөл төрөгсөдтэй нь уулзуулахгүй байхыг эрмэлзэнэ. Ялангуяа эрүү шүүлтийн ул мөр арилтал хэнтэй ч харьцуулахгүй байхыг хичээнэ.

ЭБШ хуулийн сэжигтэн, яллагдагчийн эрхэд ч төрөл төрөгсөдтэйгээ уулзах талаар тусгаагүй байна.

МУ-ын Ерөнхий прокурор, Хууль зүй дотоод хэргийн сайдын 2005 оны 1-р сарын 28-ны 14 тоот тушаалаар батлагдсан “Цагдан хорих байрны дотоод журам”-аар 7 хоногт 2 удаа 10-17 цагийн хооронд эргэлт, уулзалт оруулахыг зөвшөөрсөн байна. Эдгээр бүх заалт нь эргэлт, уулзалтыг аль болох хязгаарлахад чиглэсэн зохицуулалт болсон байна.

Цаашид эргэлт, уулзалт авах нь тухайн хүний эрхэд хамаарах эсэх, эрх биш гэж үзвэл уулзалтын зөвшөөрлийг хэн өгөх нь зохимжтой болох, зөвшөөрөл байх эсэх, 7 хоногт зөвхөн 2 удаа гэсэн нь зөв эсэхийг ч дүгнэж үзэх шаардлагатай.

Мөрдөн байцаагч уулзахыг зөвшөөрөхгүй, хувцсыг нь солиулахгүй байна хэмээн гомдоллох тохиолдол цөөнгүй байдаг нь ч дээр дурьдсан зохицуулалттай холбоотой.

Хоригдогсдыг хүлээн авах, шилжүүлэх, байцаалт болон шүүхэд хүргэх, тээвэрлэх үед хийгдэх зохицуулалт нь эрүү шүүлтээс сэргийлэх бас нэг нөхцөл болдог байна.

Ялангуяа баривчлагдсан, цагдан хоригдсон этгээдийг анх хүлээн авахдаа эрүүл мэндийн үзлэгт сайтар хамруулах, биед нь гэмтэл, согог, шарх сорви байгаа эсэхийг нэг бүрчлэн үзэж баталгаажуулах, байцаалт болон шүүхэд очсоны дараа нь эмчийн үзлэгт оруулах, тэмдэглэл хөтлөх нь чухал ач холбогдолтой.

Одоо мөрдөж буй Цагдан хорих байрны дотоод журамд хоригдогсдыг анх хүлээн авахдаа эмчийн үзлэгт хамруулах, биед нь буй гэмтэл, шарх, сорвийг тогтоохоор тусгагдсан байна.

Харин байцаалт болон шүүхэд очихоор хорих байрнаас гарах, буцаж ирэх үед бие болон хувцас, эд зүйлд нь заавал үзлэг хийнэ гэж заасан байна. Энэ нь зөвхөн аюулгүй байдал талаас нь анхаарсан байна. Үүний нөгөө тал нь байцаалтанд очих, буцаж ирэх, байцаалтанд орох үедээ эрүү шүүлтэд өртөж гэмтэл, шарх сорви авсан байхаас сэргийлэх асуудал мөн. Энэ чиглэлээр журмыг тодруулах шаардлагатай.

Эрүү шүүлттэй тэмцэх, хариуцлага тооцох нь чухал

Эрүүдэн шүүх болон хүнлэг бус хэрцгий харьцаа гарсан тохиолдол бүрийг шалгаж, гэм буруутай этгээдэд хариуцлага тооцох, эрүү шүүлтэд өртөгсдийн эрхийг сэргээх нь тухайн улсын үүрэг мөн.

Монгол Улсын Эрүүгийн хуулийн 251-р зүйлд “Хэрэг бүртгэгч, мөрдөн байцаагч хүч хэрэглэх буюу хүч хэрэглэхээр заналхийлэх, тарчлаан зовоох, тохуурхан даажигнах, хуурч мэхлэх зэрэг хууль бус арга хэрэглэж мэдүүлэг өгөхийг албадсан бол гэмт хэрэгт тооцож эрүүгийн хариуцлага хүлээлгэхээр” тогтоожээ.

Энэхүү заалт нь эрүүдэн шүүх болон хүнлэг бус, хэрцгий харьцааны ихэнхи хэлбэрийг нэрлэн заажээ.

Түүнчлэн “...зэрэг хууль бус арга хэрэглэж” гэж заасан нь энд нэрлэн заагаагүй хууль бус өөр аргуудыг ч энд хамруулж болох боломжийг олгосон гэж үзэж болно.

Харин энэ зүйлд “хэрэг бүртгэгч, мөрдөн байцаагч” хэмээн зөвхөн 2 албан тушаалыг шууд нэрлэж заасан нь эрүүдэн шүүх, хүнлэг бус, хэрцгий харьцаа

гаргаж болох субъектүүдийг энэ гэмт хэрэгт бүрэн хамруулах боломжийг алдагдуулж байна.

Ингэснээр эрүү шүүлтийг үйлдэж болох бусад албан тушаалтныг энэ зүйлээр ял шийтгэх, хуулийн өмнө адил тэгш байх зарчмыг зөрчиж байна.

Эрүү шүүлтийг цагдаагийн байгууллагын эрүүгийн төлөөлөгчид бусад ажилтнууд, тагнуулын байгууллагын гүйцэтгэх ажилтнууд, хэрэг бүртгэгч, мөрдөн байцаагчид, эрүү шүүлт явуулах, хууль бус аргаар мэдүүлэг авахуулах үүрэг даалгавар өгсөн албан тушаалтнууд ч энэ зүйлээр хариуцлага хүлээх ёстой.

Иймээс мөрдөн байцаагч хэрэг бүртгэгч гэхээсээ төрийн албан тушаалтан гэж субьектийг нь ерөнхий байдлаар тодорхойлох, мэдүүлэг гэснийг мэдээ сэлт, мэдүүлэг өгөхийг албадах гэж томъёолбол илүү нийштэй мэт санагдана.

Энэ зүйлд заасан гэмт хэргийг УЕП-ын дэргэдэх Мөрдөн байцаах алба мөрдөхөөр хуульчилсан нь өмнөхөөс илүү дэвшилттэй болсон.

Гэвч зарим талаар эргэж харах зүйл байгаа нь ажиглагдаж байна. Тухайлбал, ТЕГ-ын ажилтнууд, гүйцэтгэх ажилтны хууль бус үйл ажиллагаатай холбоотой гэмт хэргийн шинжтэй мэдээллийг шалгах эрхийг ТЕГ-ын мөрдөн байцаагчид өгсөн байна.

Байгууллагын доторх нэг бүтэц нөгөө бүтцийнхээ үйл ажиллагааг шалгах, мөрдөн байцаалт явуулах нь хир зохистой вэ?

ТЕГ-ын ажилтнууд Франц улсаас баривчлагдаж ирсэн Д.Энхбатыг нууцаар хорьж, эрүүдэн шүүх ажиллагаа явуулсан тухай гомдол гарч зарим газрууд /Прокурорын мөрдөн байцаах алба, ХЭҮК/ шалгасан боловч эрх хэмжээ нь хүрээгүй. Эцэст нь гомдол гаргасан Д.Энхбат, болон өмгөөлөгч Л.Санжаасүрэн нарын эсрэг энэ хууль бус үйлдэлд холбогдсон байгууллага өөрөө мөрдөн байцаалт явуулж, тэднийг гэмт хэрэгтэн болгож шийтгүүлсэн нь үүний тод жишээ.

Энэ тохиолдол нь ТЕГ-ын эсрэг өргөдөл гомдол гаргавал яаж төгсөхийг сануулсан сүрдүүлэг мэт санагдана.

Гүйцэтгэх ажлын тухай хуулийн 7-р зүйлд “Гүйцэтгэх ажил явуулж буй байгууллагын үйл ажиллагааны улмаас эрх, эрх чөлөө нь зөрчигдсөн гэж үзэж буй хувь хүн зохих дээд шатны байгууллага, албан тушаалтан, прокурорт гомдлоо гаргах эрхтэй” гэж заасан ч прокурорын байгууллага ТЕГ-ын үйл ажиллагааг шалгаж чадахгүй байгаа.

Эрүү шүүлт хэрэглэсэн, хууль бус мэдүүлэг гаргуулсан, хэрэг тулган хүлээлгэсэн баримт нэг бус гардаг ч Эрүүгийн хуулийн 251-р зүйлээр нэг ч хүн ял шийтгүүлээгүй нь анхаарах асуудал.

УЕП-ын дэргэдэх Мөрдөн байцаах албаны ажилтнуудын энэ хэргийг илрүүлэх, мөрдөн шалгах арга барилыг сайжруулах, мэдлэг боловсролыг нь дээшлүүлэх, суралцуулах, туршлага судлуулах шаардлага илүү чухал байна.

Хэрэг бүртгэх, мөрдөн шалгах арга барилыг сайтар эзэмшсэн тусгай албан тушаалтны эсрэг эрүүгийн хэрэг үүсгэж шалгах нь мөрдөн байцаагчдаас илүү их мэдлэг, ур чадвар, дадлага туршлага шаардана. Энэ хэргийг мөрдөх, шалгах ажлын үр дүн нь дээр дурьдсан эрүү шүүлтээс хамгаалах аргуудыг хэрхэн баталгаажуулж, биелүүлснээс ч бас шалтгаална. Иймээс эрүү шүүлтээс хамгаалах, урьдчилан сэргийлэх, мөрдөн шалгах ажлууд хоорондоо нягт холбоотой.

ЗОХИСТОЙ АЮУЛГҮЙ ХООЛ ХҮНСЭЭР ЖИГД, ХҮРТЭЭМЖТЭЙ ХАНГАГДАХ ЭРХИЙН ТУХАЙД

**Г.Далайжамц, ХЭҮК-ийн гишүүн
Д.Чимэддулам, ЭМШУИС-ын НЭМС-ийн багш**

Хүн бүр эсэн мэнд амьдарч, хөдөлмөрлөх, эрүүл бие, саруул оюун ухаантай байхын тулд зохистой, аюулгүй, хүрэлцээтэй хоол хүнсээр жигд хүртээмжтэй хангагдах ёстой бөгөөд үүнийг хүний ХҮНСНИЙ ЭРХ хэмээх ойлголтод хамааруулж байна. Харин хүрэлцээтэй, шимт бодисын зохистой харьцаатай, аюулгүй хоол хүнсийг авбал зохих хамгийн бага хэм хэмжээг зайлшгүй тогтоож өгөх ёстой бөгөөд хүн хоол хүнсээ түүнээс багагүй хэмжээгээр олж авч байж сая хүнсний эрхээ эдэлж байна гэж үзэх үндэстэй юм. Энэ утгаараа уг хэм хэмжээ нь хүний эрхтэй салшгүй холбоотой ойлголт юм.

Италийн ром хотноо 1992 онд болсон Олон улсын хоол тэжээлийн бага хурлаас гаргасан тунхаглалд “Хүнсний зохих нөөц хүрэлцээтэй байгаа манай гаригт өлсгөлөн, өлөн зэлмүүн байдал гарах учиргүй бөгөөд тэжээллэг, чанар, аюулгүй хүнс хэрэглэх явдал хүн бүрийн эдлэх эрх мөн” гэж тодохойлсон бол 1996 оны Дэлхийн Хүнсний дээд хэмжээний уулзалт дээр 185 орны төлөөлөгчид болоод Европын холбооны төрийн эрх баригчид Дэлхийн Хүнсний аюулгүй байдлын (Food Security) Ромын тунхаглалд: “Зохистой хоол хүнсээр хангагдах эрхэд нийцүүлэн хүн бүр аюулгүй, шим тэжээллэг хүнсээр хангагдах эрх болон хүн бүр өлсгөлөнгөөс ангид байх үндсэн эрх”-ийг дахин баталгаажуулсан юм. Тэд мөн 2015 он гэхэд дэлхийн өлсгөлөн хүмүүсийн тоог хагаслан бууруулахаа амласан юм.

Өнөөдөр дэлхий дээр 840 гаруй сая хүмүүс өлсгөлөнд нэрвэгдэж, сая сая хүмүүс байгалийн гамшиг, иргэний дайнд өртөж өлсгөлөн, өлөн зэлмүүн байдлын улмаас зовж тарчилж байна. Гэвч өлсгөлөн болон өлөн зэлмүүн байдлын үндэс нь дэлхийн хүн амын ихэнхийнх нь хувьд хоол хүнсний хомсдолтой холбоотой бус харин ядуу зүдүү байдлаасаа болж хэрэгцээт хоол хүнсээ авч чадахгүй байгаагаас шалтгаалж байна.¹

Монгол улсад 1990-ээд оноос эхэлсэн эдийн засгийн уналтаас болж хүнсний үйлдвэрийн нийт бүтээгдэхүүний үйлдвэрлэлт 1995 онд 1990 оныхоос 2 дахин, 2000 онд 1995 оныхоос 1.5 дахин буурчээ. Ийнхүү дотоодын үйлдвэрлэл буурснаас үүдэн гарсан дээрх хүнсний хомсдлыг арилгах зорилгоор манай улс махнаас бусад гол нэрийн бүтээгдэхүүний 70-100%-ийг импортоор хангаж, зах зээлд нийлүүлж байгаа нийт бүтээгдэхүүний 60-70%-ийг импортын хүнсний зүйл эзэлж, улмаар өргөн хэрэглээний хүнсний бараа, бүтээгдэхүүний хувьд манай орон гадаад орноос үлэмж хамааралтай болжээ.

Олон нэрийн хүнсний бараа, бүтээгдэхүүнийг импортолж байгаа нь өнөөгийн нөхцөлд химийн хорт болон цацраг идэвхит бодис, хүнд металлын агууламж

¹ Ерөнхий зөвлөмж 12-ын 11 дүгээр зүйлийн 5, ЭЗНСЭХ, (Е/С.12/1999/5)

Зохистой аюулгүй хоол хүнсээр жигд, хүртээмжтэй хангагдах эрхийн тухайд

өндөртэй, хадгалах, тээвэрлэх явцад эрүүл ахуйн горим алдагдсанаас элдэв нян, хөгц мөөгөнцрөөр бохирлогдсон хүнс хилээр орж ирэх эрсдэл өндөр байна.

Мөн тэрчлэн сүүлийн жилүүдэд тус оронд тохиолдсон ган, зуд зэрэг байгалийн гамшгийн улмаас хүн амын хүнсний хангамж, баталгаа алдагдаж, ган, зуданд нэрвэгдсэн бус нутагт 6-59 сартай хүүхдүүдийн 36.1% нь хоол тэжээлийн дутагдал (ХТД)-ын архаг хэлбэр болох өсөлт хоцорсон нь бусад бүс нутагтай харьцуулахад 11.2%-аар илүү байна.

Манай улсын нийт хүн амын 35.6%-ийг ядуу, нэн ядуу хүн ам эзэлж байна.² Хүн амын амьжиргааны түвшин доройтон, бодит орлого буурч, ядуучуудын тоо жилээс жилд нэмэгдэж байгаа нь эмзэг бүлгийнхний, ялангуяа, бага насны хүүхдийн хоол тэжээл, бичил тэжээлийн хангамжинд сөргөөр нөлөөлж байна. Гэтэл хүнсний хангамж, аюулгүй байдлын дээрх нөхцөлд хүн амын хоол тэжээл, эрүүл мэндийн байдалд судалгаа, дүн шинжилгээ хийсэн олон эх сурвалж, мэдээлэл байгаа ч тэдгээрийг нэгтгэж хүний эрхтэй холбон судалж, үнэлгээ дүгнэлт өгсөн судалгаа одоогоор байхгүй байна.

Иймд хүн амын зохистой хоол хүнсээр хангагдах эрхийн төлөв байдал ямар түвшинд байгааг улс орны хоол хүнсний хангамж, аюулгүй байдлын өнөөгийн нөхцөл болон тэдний амьжиргааны түвшинтэй уялдуулан судалж, дүн шинжилгээ хийж, шаардлагатай санал, зөвлөмжийг боловсруулах шаардлагатай байгаа юм.

Энэхүү асуудалтай холбогдолтой олон улсын баримт бичиг болон дотоодын хууль тогтоомж, ба бодит байдлыг авч үзье.

1. Хүнсний эрхийн олон улсын эрх зүйн зохицуулалт

Хүнсний эрхийг баталгаажуулах нь Олон улсын хууль эрх зүйн нэг чухал асуудал бөгөөд өнөөдөр манай улс нэгдэн орсон буюу соёрхон баталсан хүний эрхийн хэд хэдэн баримт бичгүүдэд уг эрх тусгагдаад байна.

Хүний эрхийн түгээмэл Тунхаглалд (1948) “хүн бүр хоол хүнс ... оролцуулаад өөрийн болон ам бүлийнхээ эрүүл мэнд, аж амьдралыг тэтгэхэд хүрэлцэхүйц амьжиргаатай байх эрхтэй” гэж заасан байдаг. Үүнээс хойш бараг 20 жилийн дараа Эдийн Засаг, Нийгэм Соёлын Эрхийн тухай Олон Улсын Пактад (1966) эдгээр асуудлыг илүү боловсронгуй тусгаж “хүн бүр ... зохистой хоол хүнстэй байх эрх”-ийг цохон тэмдэглээд, нэн тэргүүнд “өлсгөлөн, тэжээлийн доройтлоос ангид байх үндсэн эрх”-ийг онцлон заасан.

Дээрх заалтуудаас харахад хүний хүнсний эрх нь өлсгөлөнгөөс ангид байх эрх болон зохистой хоол хүнсээр хангагдах эрх гэсэн хоёр үндсэн эрхүүдийг багтааж байна.

◆ Өлсгөлөнгөөс ангид байх эрх болон зохистой хоол хүнсээр хангагдах эрхийн хооронд ямар ялгаа байна вэ?

ӨЛСГӨЛӨНГӨӨС АНГИД БАЙХ ЭРХ бол хүмүүсийг өлсгөхгүй байх хамгийн доод хязгаарыг баталгаажуулах үүрэг хариуцлагыг хүлээх гэсэн утгатай хүний үндсэн эрх юм. Хүмүүсийн идэж ууж буй хоол хүнс нь цаг хугацаа, орон зайн

² Амьжиргааны түвшний түүвэр судалгаа, УСГ, 1998 он

хувьд хүрэлцээтэй байхын дээр аюулгүй, шимт бодисын зохистой агууламжтай байх шаардлагатай. Нэг талаар Засгийн газар хүн амыг зохистой хоол хүнсээр хангагдах боломжийг бүрдүүлэх ёстой авч нөгөөтэйгүүр хүмүүс зохистой хоол хүнсээр өөрсдийгөө ямар ч үед хангах бие бялдар, эдийн засгийн чадавхитай байх ёстой бөгөөд үүнийг хангахын тулд нийгэм, эдийн засгийн бусад эрхээ эдлэх аргагүй өндөр үнэ төлөх ёсгүй юм.

Тэгэхээр **ЗОХИСТОЙ ХООЛ ХҮНСЭЭР ХАНГАГДАХ ЭРХ** гэдэг нь хүн бүр бүхий л амьдралынхаа туршид хүрэлцэхүйц хоол хүнсээ олж авах буюу түүнд нийцсэн бие бялдар болон эдийн засгийн чадвартай байхыг хэлнэ. Зохистой хоол хүнсээр хангагдах эрх нь Олон улсын хэд хэдэн баримт бичгүүдэд тусгагдан, 1996, 2002 онуудад болсон Дэлхийн хүнсний дээд хэмжээний уулзалтуудын дүнд гарсан баримт бичгээр дахин баталгаажигдсан байдаг.

ЭЗНСЭОУ-ын Пактад энэхүү эрхийн талаар бусад баримт бичигт зааснаас илүү тодорхой заасан байдаг. Зохистой хоол хүнсээр хангагдах эрх нь бусад эрхээ эдлэхэд чухал ач холбогдолтой. ЭЗНСЭХ-ны Ерөнхий зөвлөмж (1999) 12-т зохистой хоол хүнсээр хангагдах эрхийг маш дэлгэрэнгүй тайлбарласан байдаг.

◆ **Хүнсний аюулгүй байдал (Food safety)**

Хүнсний чанар, аюулгүй байдал бол хүнсний эрхийн чухал хэсэг мөн. ХҮНСНИЙ АЮУЛГҮЙ БАЙДАЛ гэдэг нь хоол хүнс нь бохирдуулагч нян, хортой бодис зэрэг эрүүл мэндийг хохироох бусад бодисуудыг агуулаагүй байх буюу тэдгээр нь хоол хүнсэнд аюул учруулахааргүй түвшинд байхыг хэлнэ.

Хүнсний хууль эрх зүйн хороо (Codex Alimentarius Commission) нь хүнсний стандарт болон хүнсний чанар, аюулгүй байдлыг хамгаалах бусад зөвлөмжүүдийг бэлтгэдэг. Codex Alimentarius буюу Хүнсний хууль, эрх зүй нь хэрэглэгч, хүнсний үйлдвэрлэгч болон боловсруулагчид, үндэсний хүнсний хяналтын агентлаг болон олон улсын худалдааны байгууллагын дэлхий дахин дахь лавлах мөн. Энэ нь Засгийн газарт үндэсний хүнсний хяналтын хууль тогтоомж боловсруулах болон хүнс нь аюулгүй байх бөгөөд зах зээлд шударгаар худалдаалагдах хэрэглэгчдийн эрхийг хамгаалах тогтолцоог бүрдүүлэх үндэс болдог байна.

◆ **Хүнсний эрхийн зөрчил (Violations of the Right to Food)**

Зохистой хоол хүнсээр хангана гэдэг нь өлсгөлөн, тэжээлийн доройтол, өлөн зэлмүүн байдлыг арилгана гэсэн үг юм. Гэтэл уг эрх зөрчигдөж буй нэг илрэл бол хоол хүнсний хүрэлцээ, хангамж алдагдаж, хоол хүнсний шимт чанар буурах явдал юм. Түүний уршгаар өлсгөлөн, өлөн зэлмүүн байдал болон түүнтэй холбоотой хоол тэжээлийн дутлын шалтгаант өвчин эмгэг үүсч дэлхий нийтийн тулгамдсан асуудал болоод байна.

Өлсгөлөн гэдэг нь хүн хүрэлцэхүйц хоол хүнс олж авах аргагүй байх нөхцөл байдал юм. Өлсгөлөн нь хүмүүсийн оюун ухааныг доройтуулж, хөдөлмөрийн бүтээмжийг бууруулснаар тэдний нөөц боломжоо ашиглахаас эхлээд нийгмийг бүхэлд нь хөгжихөд саад болдог байна. Өлсгөлөнтэй холбоотой өвчин эмгэг нь хөгжиж буй орны ядуу өрхүүдэд өрхийн зарлагыг эрс нэмэгдүүлж, байнгын амь зуулгын төлөө тэмцэж буй өрхийн гишүүдийн эрүүл мэндэд үзүүлэх тусламжийн хэрэгцээг улам бүр ихэсгэдэг байна. Ингэснээр өлсгөлөнгийн шалтгаан болдог

Зохистой аюулгүй хоол хүнсээр жигд, хүртээмжтэй хангагдах эрхийн тухайд

ядуурал нь өөрөө түүний үр дагавраар үүсдэг байна.

◆ Өлсгөлөн болон хоол тэжээлийн дуталд хэн хамгийн их өртөх эрсдэлтэй вэ?

Таваас доош насны хүүхдүүд хоол тэжээлийн дуталд хамгийн их өртдөг байна. ДЭМБ жил бүр ойролцоогоор 10 сая хүүхдийн тэн хагас нь хоол тэжээлийн дутлын улмаас нас барж байгааг онцлон заасан байдаг. Бага насны хүүхдүүд хоол тэжээлийн дутлаас үүдсэн өвчин эмгэгт илүү их өртөмтгий байдаг ба тэд мөн амьдралынхаа туршид бие бялдар болон оюун ухааны нөхөн төлшгүй хохиролд өртөж байдаг.

Хүүхдийн эрхийн Конвенци (1989) нь зохистой хоол хүнсний хэрэгцээ шаардлагад анхаарлаа хандуулсан байдгийн зэрэгцээ хүүхдийн эрүүл мэнд, хоол тэжээлийн сайн сайхан байдлын асуудалд ундны цэвэр усыг оруулахын чухлыг шууд заасан байдаг.

2. Хүнсний асуудлаарх олон улсын стандартыг үндэсний хууль тогтоомжид тусгасан байдал

Монгол улсын Үндсэн хуульд “өлсгөлөнгөөс ангид байх эрх” болон “зохистой хоол хүнсээр хангагдах эрх” шууд утгаараа тусгагдаагүй боловч мөн хуулийн 16 дугаар зүйлийн 2-т заасан “Эрүүл, аюулгүй орчинд амьдрах, орчны бохирдол, байгалийн тэнцэл алдагдахаас хамгаалуулах эрхтэй”, мөн энэ зүйлийн 6-д заасан “эрүүл мэндээ хамгаалуулах . . . эрхтэй” гэсэн заалтуудаар үндсэндээ зохицуулагдаж байгаа юм.

Хүний эрхийн олон улсын дээрх стандартуудыг үндэсний хууль, тогтоомжуудад, тухайлбал Хүнсний тухай, Эрүүл мэндийн тухай, Ариун цэврийн тухай, Хэрэглэгчдийн эрх ашгийг хамгаалах тухай, Стандартчлал, Тохирлын үнэлгээний тухай зэрэг 10 шахам хууль, тогтоомжид ямар нэг байдлаар тусгасан. Хүний зохистой хоол хүнсээр хангагдах эрхийг баталгаажуулсан гол хууль болох одоогийн дагаж мөрдөж байгаа Хүнсний тухай (1999 оны) хуулийг өмнөх Хүнсний тухай (1995 оны) хуультай харьцуулан үзэж, хүний эрхийн олон улсын стандарт, олон улсын байгууллагуудаас гаргасан зөвлөмж, чиглэлүүдийг хэрхэн тусгасныг нарийвчлан судалж, дараахь дүгнэлтийг хийж байна.

Хүнсний тухай (1995 оны) хууль хүний эрхийн олон улсын стандарт, олон улсын байгууллагуудаас гаргасан зөвлөмж, чиглэлийн заалтыг нэлээд дэлгэрэнгүй томъёолж, хүний зохистой хоол хүнсээр хангагдах эрхийг баталгаатай болгож хэрэгжүүлэхэд төрийн гүйцэтгэх үүрэг, хариуцлагыг маш тодорхой тусгасан байдаг.

Гэтэл 4 жилийн дараа энэхүү хуулийг шинэчлэн найруулж, одоогийн дагаж мөрдөж байгаа Хүнсний тухай (1999 оны) хуулийг батлан гаргахдаа хүний зохистой хоол хүнсээр хангагдах эрхийг баталгаажуулж, хэрэгжүүлэхтэй холбоотой олон чухал заалт, төрийн бодлого, зохицуулалтын шинж чанартай зорилт, чиг үүрэг, хүн амд эерэгээр хандсан гол гол асуудлыг хассан нь зүй ёсоор анхаарал татаж байна.

Хүн амын хүнсний хангамжийг хэвийн байлгах, өлсгөлөн, өлөн зэлмүүн байдал үүсэхээс сэргийлэх, нялхас, хүүхэд, эхчүүд, хөгшдийг хоол хүнсээр хангах, хувь

хүн, айл өрх хүнсний хангамжаа хэвийн байлгахад дэмжлэг үзүүлэх зэрэг төр, засгийн бодлогын гол асуудлыг хүнсний анхны хуульд тусгагдсан байсныг шинэчилсэн найруулга хийхдээ хассан. Хүнсний баталгаа, хангамж, хүрэлцээний аюулгүй байдлыг шийдвэрлэх гол бодлого нь хөдөө аж ахуй, боловсруулах үйлдвэрлэлийг хөгжүүлэх асуудал боловч энэ талаар анхны хуульд байсан заалтыг мөн хассан байна.

Ийнхүү хүнсний хангамж, хүрэлцээ, баталгааны тухай хуулинд тодорхой заалт байхгүй болсноор хуулинд “хүнсний аюулгүй байдал”-ын үндсэн асуудлын нэг нь орхигдож, төрийн бодлогын гадна хоцорсон.

Дээрх хуулийн өөрчлөлтийн хандлага нь хүний зохистой хоол, хүнсээр хангагдах эрхийг хэрэгжүүлэх талаар Хүнсний тухай (1995 оны) хуульд Засгийн газрын (ямд оролцоод) зүгээс нилээд идэвхтэй үйл ажиллагаа явуулах, өргөн эрх хэмжээ, үүрэг, хариуцлага хүлээсэн байсныг шинэчлэн найруулсан одоогийн хуулиар хязгаарлаж, идэвхгүй үйл ажиллагаа явуулж, байдлыг танилцуулах, мэдээлэх, уламжлах, батлах, журам тогтоох зэрэг хэлбэрийн төдий чиг үүрэгтэй болгож хуульчилсан байх юм. Энэ нь Монгол Улсын үндсэн хуулийн 19-р зүйлийн 1-д “Төрөөс хүний эрх, эрх чөлөөг хангахуйц эдийн засаг, нийгэм, хууль зүйн болон бусад баталгааг бүрдүүлэх, хүний эрх, эрх чөлөөг зөрчихтэй тэмцэх, хөндөгдсөн эрхийг сэргээн эдлүүлэх үүргийг иргэнийхээ өмнө хариуцна” гэсэн зарчмын заалтыг биелүүлээгүйтэй холбоотой юм.

НҮБ-ын Эдийн засаг, нийгэм, соёлын эрхийн хорооны 1999 оны ХХ чуулганаас гаргасан 12-р ерөнхий зөвлөмжид *“Оролцогч талын гол үүрэг нь хүмүүсийг хүрэлцээтэй хоол хүнс хэрэглэх эрхээ дэвшилттэйгээр бүрэн эдлэхэд туслах арга хэмжээг авах явдал юм. Энэ зорилгодоо хүрэхийн тулд аль болох түргэн ажиллахыг үүрэг болгож байна. Оролцогч улс бүр иргэдээ шим тэжээл сайтай, найдвартай хүнс хэрэглэж байгаа эсэх, өлсөхгүй байгаа эсэхийг хянах үүрэгтэй”*³ гэсэн заалт болон зөвлөмжийн 15-р зүйлд заасан улс орны үүргүүдийг хайхарч үзээгүй байна.

Хүн амыг, түүний дотор нийгмийн эмзэг бүлэгт хамрагдаж буй хүмүүсийг зохистой хоол хүнсээр хангахад дэмжлэг үзүүлэх нь төрийн нэн чухал үүрэг бөгөөд энэ асуудлыг төр, засгийн бодлогын түвшинд авч үзэж хүнсний тухай хуульд тусган хэрэгжүүлэх ёстой. Гэтэл одоогийн мөрдөж буй Хүнсний тухай хуульд тусгаагүйгээр барахгүй өмнөх (1995 оны) хуулийн 7-р зүйлийн Засгийн газрын бүрэн эрх гэсэн хэсэгт: *“... шаардагдах хүнсний зүйлийн хангамж, бүтцийн зохистой хэмжээг тогтоож, ... амжиргааны баталгаажих түвшингээс бага орлоготой, нэн ядуугаас болж өлсгөлөн, өлмөн зэлмүүн байдалд хүрсэн иргэдийн судалгаа гаргаж, өөрийгөө хүнсний зүйлээр хангахад нь тусламж дэмжлэг үзүүлэх, ... амжиргааны баталгаажих түвшингээс бага орлоготой өрхийн 4 нас хүрээгүй хүүхэд, жирэмсэн эмэгтэй болон хөхүүл хүүхэдтэй эх, хөдөлмөрийн чадваргүй, тахир дутуу иргэд өндөр настай хүмүүсийг хүнсний хувьд эмзэг хэсэгт тооцож, тэдэнд дэмжлэг үзүүлэх арга хэмжээг жил бүр улсын төсөвт тусгаж хэрэгжүүлэх...”* гэсэн эмзэг бүлгийн эрхийг хангах нэн чухал заалтуудыг одоогийн хуулиас хасч орхигдуулсан нь Эдийн Засаг, Нийгэм, Соёлын Эрхийн Тухай Олон Улсын Пактаар хүлээсэн үүрэг, олон улсын байгууллагын чиглэл, зөвлөмжөөс няцаж, ухарахад хүрсэн идэвхгүй үйл ажиллагаа гэж хэлэхэд хилсдэхгүй бизээ.

³ Хүний эрхийн конвенцуудын хорооноос батлан гаргасан Ерөнхий санал, зөвлөмжүүдийн эмхтгэл 55-р талд

Зохистой аюулгүй хоол хүнсээр жигд, хүртээмжтэй хангагдах эрхийн тухайд

Нийгмийн эмзэг бүлэгт хамрагдаж буй ихэнх иргэд ядуу зүдүүгийн улмаас гол хэрэгцээт хоол хүнсээ олж авахын тулд чанарыг үл хайхран аль болох хямдхан төсөр хүнсний зүйлийг худалдан авч хүнснийхээ хэрэгцээг хангаж байна.

Тиймээс ч хүн амын хоол хүнсний хэрэгцээ, шаардлагыг дотооддоо хангаж чадахгүй байгаа одоогийн хүндрэл бэрхшээлтэй байдлыг далимдуулж зарим бизнесийнхэн чанар муутай, хугацаа дууссан, стандартын бус хямд хүнсний зүйл импортоор оруулж ирэн худалдаж хэрэглэгчдийн эрх ашгийг хохироож байна.

Олон улсын эрх зүйн дээрх баримт бичгийн заалт, чиглэлийг үндэсний хууль, тогтоомжид тусгаж баталгаажуулах нь манай улсын төрөөс олон улсын гэрээ конвенцээр хүлээсэн нэн чухал үүрэг юм.

3. Хүнсний хангамж, баталгаа (Food security)

Хүн амын хүнсний хангамж, баталгаа нь нийгмийн тогтвортой байдлыг хангах, улс төр, эдийн засгийн тусгаар тогтнолыг хамгаалахад чухал баталгаа болдог учир төрийн бодлогоор зайлшгүй зохицуулагдах асуудлуудын нэг юм.

Засгийн газар хүнсний хангамж, баталгааг бий болгох хөтөлбөрүүдийг хэрэгжүүлж хүнсний эрхээ эдэлж чадахгүй байгаа хүмүүст хоол хүнсээр өөрсдийгөө хангах боломжийг бүрдүүлэх ёстой. Ингэснээр ард иргэдээ өлсгөлөнгөөс ангид байх, зохистой хоол хүнсээр хангагдах эрхийг баталгаажуулж байгаа юм. Үүний тулд улс орнуудын зорилт, бодлогын зохицуулалт болон тохирох жишгийг тодорхойлж, хүний эрхийн зарчимд үндэслэсэн хүн амын хүнс болон хоол тэжээлийн хангамж, баталгааг хангах стратегийг батлахыг шаарддаг.⁴

ДХХААБ-ын тодорхойлсноор ХҮНСНИЙ ХАНГАМЖ, БАТАЛГАА гэж хүн бүр амьдралынхаа туршид эрүүл саруул, үр бүтээлтэй амьдрахын тулд хоногийн хоолны хэрэгцээг хангахуйц шим тэжээллэг, аюулгүй, хүрэлцэхүйц хэмжээний хоол хүнсийг олж авах (хүртэх) бие бялдрын болон эдийн засгийн чадвартай байхыг хэлнэ. Мөн байгууллага хүнсний хангамж, баталгааг хангах 4 үндсэн нөхцөлийг тодорхойлжээ.

- o Хоол хүнсний хангамж, хүрэлцээ (Availability) - үржил шимт газар болон байгалийн нөөцөөс буюу эсвэл шаардлага хангасан үйлдвэрлэлээс гарсан хүрэлцэхүйц хэмжээний хоол хүнсийг зөв хуваарилалт, түгээлтээр дамжуулан шууд авч хэрэглэх боломж.
- o Хангамжийн тогтвортой байдал (Stability or Sustainability of supply) - хүнсний хангамж нь улирал хооронд буюу жилээс жилд ямар ч хэлбэлзэл, хомсдолгүйгээр тогтвортой байх.
- o Хүртээмж буюу хүрэх боломж (Accessibility or Affordability) - хувь хүн болон өрх гэр хоногийн хоолны хэрэгцээгээ хангахын тулд зохистой хоол хүнсийг олж авах болон худалдан авах зохих орлого буюу эх үүсвэртэй байх
- o Хүнсний чанар, аюулгүй байдал (Quality and Safety of food) - хоол хүнсийг зориулалтын дагуу бэлтгэж хэрэглэхэд хүний эрүүл мэндэд хор хөнөөл учруулахгүй байх баталгаа.

Аливаа улс гүрэн хүнсний гол нэрийн бүтээгдэхүүнээр хүн амынхаа хэрэгцээг өөрийн үйлдвэрлэлээс хангах боломжтой эсэх нь тухайн орны нөөцөөс ихээхэн

⁴ ЭЗНСЭХ-ны Ерөнхий зөвлөмж 12, Хорьдугаар чуулган, 1999 он, 15, 21-р заалтаас

шалтгаалдаг. Хэрэв хүн амынхаа хэрэгцээг хангаж хүрэхүйц нөөцтэй бол хүнсний хангамжийн **чадавхитай** орон гэж үздэг. Харин хүнсний нөөцийг хэр зэрэг ашиглаж байгаагаар нь хүнсний хангамжийн **баталгаатай** гэж үздэг байна.

Хүнсний хангамжийн эх үүсвэр нь эх орны үйлдвэрлэлийн болон импортын бүтээгдэхүүн байх учраас тухайн улс орны хүнсний баталгааны бас нэг чухал үзүүлэлт нь дотоодын үйлдвэрлэл, импортын харьцаа байдаг. Олон улсын хэмжээнд тогтсон жишгээр хүнсний хэрэгцээний 30-аас дээш хувийг импортоор авдаг орныг хүнсний хангамжийн баталгаагүй гэж үзэх бөгөөд нэг төрлийн бүтээгдэхүүний хэрэгцээний 20-оос илүү хувийг зөвхөн ганц орноос импортолдог бол уг улсыг тухайн гүрнээс хүнсний хангамжийн хувьд хараат байдалтай гэж үнэлдэг. Үүнээс үзвэл хүнсний хангамж, баталгаа гэдэг нь зөвхөн хүн амыг хүнсний зүйлээр хангах асуудал төдийгүй улс орны тусгаар тогтнол, улс төр, эдийн засгийн хувьд бие даасан байдлыг илтгэх үндэсний аюулгүй байдлын чухал үзүүлэлт болдог байна.

Хүнсний хангамж баталгааг хангах талаар төрөөс авч буй арга хэмжээ

Хөдөө аж ахуйн салбарын эрх зүйн орчныг боловсронгуй болгох чиглэлээр гаргасан хууль, эрхийн актууд нь бүхэлдээ хүнсний хангамж, баталгааг сайжруулах зорилттой холбоотой юм.

УИХ-аас 1999 онд баталсан “Хүнсний тухай”, 2001 оны “Малын удмын сан, эрүүл мэндийг хамгаалах тухай”, 2004 оны “Тариалангийн тухай”, 2004 оны “Амьтан, ургамал, тэдгээрийн гаралтай түүхий эд, бүтээгдэхүүнийг улсын хилээр нэвтрүүлэх үеийн хорио цээрийн хяналт шалгалтын тухай” зэрэг хуулиудыг хүнс, хөдөө аж ахуйн чиглэлээр хүнсний хангамж, баталгааг хангахад баримталж байна.

Хүнсний тухай хуулийн зорилт нь “хүн амын хүнсний хэрэгцээ ...-г хангах”-ад оршиж байгаа нь хүн амын хэрэгцээтэй хүнсний нийлүүлэлт, хангалтыг хариуцна гэсэн утгатай байна. Гэвч хүнсний хэрэгцээ гэдгийг хуулийн нэр томъёоны тайлбартаа тайлбарлаагүй болохоор үүнийг шууд утгаар ингэж ойлгох нь бас учир дутагдалтай.

Засгийн газар хуульд зааснаар хүнсний бодит хэрэглээ, нэр төрөл, найрлага, шим тэжээлийн талаар судалгаа, дүгнэлт хийж, УИХ-д жил тутам мэдээлж байхаар хуулинд заагдсан боловч олон нийт энэ талаар бодитой мэдээлэл, нэгдсэн ойлголтгүй хэвээр байна.

Уг хуулинд хүн амыг хоол хүнсээр өөрсдийгөө хангах боломжийг хэрхэн олгох талаар огт тусгаагүй байгаа нь **нэгдүгээрт**, хоол хүнсний үнэ ямар нэг зохицуулалтгүй болж, үнийн хөөрөгдөл бий болох, **хоёрдугаарт**, гуравдагч этгээд хүн амын хүнсний хангамжийг зориудаар гачигдуулах боломжийг олгож байна. Мөн түүнчлэн, хүн амын ядуу, эмзэг хэсэгт болон ажилгүйдэл, ган гачиг тохиолдсон үед төрөөс тухайн эмзэг бүлгийн хүн амыг нэн тэргүүнд хоол хүнсээр хангах эрхийн талаар энэ хуульд ямар нэг заалт тусгаагдаагүй байгааг дээр дурьдсан билээ.

УИХ-ын 2003 оны 29 дүгээр тогтоолоор “Төрөөс хүнс, хөдөө аж ахуйн талаар баримтлах бодлого” гэсэн баримт бичгийг батлан гаргасан юм. Энэхүү бодлогын зорилго нь эдийн засаг, бизнесийн таатай орчинг бүрдүүлэх, үйлдвэрлэлийн бүтээмж, чадавхийг нэмэгдүүлэх, мал аж ахуй, газар тариалан, хүнсний салбарын

Зохистой аюулгүй хоол хүнсээр жигд, хүртээмжтэй хангагдах эрхийн тухайд

тогтвортой хөгжлийг хангах, экологийн цэвэр, аюулгүй хүнсний бүтээгдэхүүн үйлдвэрлэх чанар, хүртээмжийг сайжруулахад чиглэжээ. Төрөөс баримтлах энэхүү бодлогын зорилт нь хүнс, хөдөө аж ахуйн гол нэрийн бүтээгдэхүүний үйлдвэрлэлийг нэмэгдүүлэн мах, сүү, гурил, төмс, хүнсний ногооны хэрэгцээг дотоодын үйлдвэрлэлээр хангаж, импортыг бууруулж, экспортыг нэмэгдүүлэхэд оршиж байна.

Засгийн газраас 2001 онд 242-р тогтоолоор “Хүнсний хангамж, аюулгүй байдал, хоол тэжээл” Үндэсний хөтөлбөрийг батлан гаргасан нь хүнсний хангамж, хэрэглээ, эрүүл ахуйн аюулгүй байдлын асуудлуудыг цогц байдлаар шийдвэрлэх зорилтыг агуулсан чухал алхам болсон байна. Үүнээс гадна сүүлийн 10 жилд “Малын эрүүл мэнд”, “Мал сүргийг ган, зудаас хамгаалахад туслах”, “Эрчимжсэн мал аж ахуйн хөгжлийг дэмжих”, “Ногоон хувьсгал”, “Цагаан хувьсгал” хөтөлбөр болон бусад холбогдох олон чухал, хөтөлбөр, төслүүдийг батлан хэрэгжүүлж байна. Эдгээр зарим хөтөлбөр нь “Хүнсний хангамж, аюулгүй байдал, хоол тэжээл” Үндэсний хөтөлбөрийн нэг хэсэг болж хэрэгжиж байгаа аж. Гэвч уг хөтөлбөрийг хэрэгжүүлэхээр хүнсний олон салбар нэгдэж үйл ажиллагаагаа уялдуулахаар Хүнсний салбар дундын зохицуулах хороо байгуулан, салбар тус бүр ажлын хэсгийн багуудад хуваагдан үйл ажиллагаагаа явуулахаар төлөвлөгөө, дүрэмдээ тусгасан боловч ажлын хэсгүүдийн үйл ажиллагаа тодорхойгүй, нэгтгэн дүгнэх тогтолцоо бүрдэж чадаагүй, нэгдсэн үнэлгээ байхгүйгээс хөтөлбөрийн хэрэгжилт бодитой үр дүнд хараахан хүрч чадаагүй байна.

Хүнсний хангамжийн өнөөгийн байдал

Монгол улс хүнсний нөөцийн хувьд өнөө ба ойрын ирээдүйд, тэр ч байтугай нилээд алс хэтдээ хүнснийхээ гол хэрэгцээг дотоодын үйлдвэрлэлээр хангах бүрэн чадавхитай орон юм. Ийм боломжийг манай орны өргөн уудам нутаг дэвсгэр, мал сүрэг, хүнсэнд ашиглах байгалийн баялаг маань олгож байгаа билээ.

Монгол улс 1990-ээд оноос өмнө хөдөө аж ахуйн үйлдвэрлэлээр хүн амын хүнсний хэрэгцээгээ бүрэн хангаад, улмаар тодорхой хэсгийг гадаадад экспортлогч орон байсан. 1990-ээд оноос эхлэн Монгол улсын эдийн засаг, нийгмийн тогтолцоо шинэчлэгдэж, дотоод, гадаад нөхцөл байдал өөрчлөгдөн, зах зээлийн харилцаанд шилжиж эхэлснээс улс, ардын аж ахуйн бүх салбарт учирсан эдийн засгийн хямрал үйлдвэрт нилээд хүнд тусаж, үйлдвэрлэлийн техник, технологи хуучирч, түүхий эд, материал, сэлбэг хэрэгсэл тасалдаж, түлш, эрчим хүч, шатахууны хангамж доголдон, үйлдвэрлэлийн жигд ажиллагаа алдагдаж эхэлсэн. Үүнээс шалтгаалан уг салбарын нийт бүтээгдэхүүний үйлдвэрлэлт 1995 онд 1991 оныхоос 3 дахин, 2003 онд 1995 оныхоос 1.5 дахин буурсан байна.

Хүнсний хангамжийн бодит байдлыг үнэлэх шалгуур нь хүний бие махбодид шаардлагатай хоол тэжээлийн бодисуудын зөвлөмж хэмжээ болно. Монгол хүний хоол тэжээлийн бодисуудын зөвлөмж хэмжээг судалгааны үндсэн дээр анх 1981 онд тогтоож, 1997 онд шинэчилж, Эрүүл мэндийн сайд баталж байжээ.

Өнөөгийн байдлаар монгол хүний физиологийн хэрэгцээ зөвхөн мах, махан бүтээгдэхүүнээр бүрэн хангагдаж байна. Сүүний нөөцийн 50-60 хувийг л ашиглаж, энэ нь хүн амынхаа хэрэгцээг үйлдвэрлэлтээр бараг хангаж байгаа мэт боловч зохистой хэрэглээний бүтцээр бодвол сүү, цагаан идээний хэрэглээний жишиг бодит байдлаас доогуур тогтоогдсон байх магадлалтай. Учир нь 1980 оны

Монголын хүн амын хоол хүнсний физиологийн нормд сүү, сүүн бүтээгдэхүүний жишсэн нэг хүний дундаж хэрэгцээг 740 мл байхаар тооцож байсан бол 1997 онд шинэчилсэн нормоор энэ хэмжээг 380 мл хүртэл бараг 2 дахин бууруулсан байгаа нь жилийн хэрэгцээг хангахад нөлөөлсөн. Тэгвэл сүү, цагаан идээ хүний бие махбодид зайлшгүй шаардлагатай шимт болон биологийн өндөр идэвхит бодисыг хамгийн зохистой хэмжээгээр агуулсан, маш сайн шингэж боловсордог байгалийн бүтээгдэхүүн юм. Харин бусад бүтээгдэхүүн хүн амын хүнсний хэрэгцээний, ялангуяа аминдэм, аминхүчил, эрдэс бодисын гол эх үүсвэр болох төмснийх 49.3%, хүнсний ногооных 16.4%, цөцгийн тосных 24.4%, өндөгнийх 9.8%, жимс, жимсгэнийх дөнгөж 3.1%, ургамлын тосных 26.3%-ийг тус тус хангаж байгаа бөгөөд загасаар бараг хангагдахгүй байна. Хүнсний нөөц ашиглалтын байдлаас үзвэл үр тариа, ялангуяа буудай, төмс, хүнсний ногооны үйлдвэрлэлт ихээхэн анхаарал татаж байна (Л.Дамдинсүрэн).

Газар тариалан бол хүн амын хүнсний хэрэгцээг хангах гол эх үүсвэрийн нэг ях аргагүй мөн билээ.

Манай орны эдийн засаг зах зээлийн тогтолцоонд шилжиж төсвийн татаас, хөнгөлөлттэй зээл, тусламж зогссоноор газар тариалангийн үйлдвэрлэл сүүлийн 7 жил дараалан унаж, нийт эргэлтийн талбайн 50 орчим хувь ашиглагдахгүй болж, хүн амын хэрэгцээт гурил, төмс, хүнсний ногоо-ны 50 хүртэл хувийг хангах төдийд хүрсэн. Манай улс 1996 онд үр тариа 225.0 мянган тонн, төмс 47.0 мянган тонн, хүнсний ногоо 22.6 мянган тонныг тус тус хураан авсан нь 1985-1990 оны жилийн дундажтай харьцуулахад үйлдвэрлэсэн үр тариа 3.4 дахин, төмс 2.7 дахин, хүнсний ногоо 2.0 дахин буурчээ.

Энэ нь Монгол орны нөхцөлд газар тариалангийн үйлдвэрлэлийн технологийн бодлогын шинэтгэл хийх шаардлагатайг харуулж байна.

Талх, нарийн боов, чихэр, жигнэмэгийн үйлдвэрлэлт 1991 оноос буурч, 2003 оны байдлаар талхны үйлдвэрлэлт 1990 оныхоос 3.1 дахин, нарийн боов, чихэр жигнэмэгийнх 5.2 дахин багасчээ.

◆ **Газар хувьчлал хүнсний хараат бус байдалд нөлөөлөх нь** Хортон шавьж устгах хорны Ази-Номхон далайн сүлжээ “Хүнсний хараат бус байдлын төлөөх Хүмүүсийн цуваа-2004”-аас гаргасан “Бидний газар болон хүнсний эрхийг баталгаажуулах нь” тулгуур бичигтээ: “Газар бол хүнсний үйлдвэрлэлийн гол хүчин зүйлийн нэг юм. Нийгмийн хамгийн гадуурхагдсан бүлгийн хүмүүсийн өлсгөлөн ядуурлын үргэлжилсэн цикл нь жинхэнэ хүмүүсийн төлөө гэсэн газрын шинэчлэл дутагдсанаас үүдэж байна. Газартай байх боломжоос гадна, үр, ус зэрэг бусад эх сурвалжаас хүртэх эрх нь Хүнсний хараат бус байдалд амин чухал юм.” хэмээн хүнсний хараат бус байдал дахь газрын эрхийг баталгаажуулахын чухлыг заасан байдаг.

Манай оронд 1992 онд батлагдсан анхны ардчилсан үндсэн хуулиар газар хувийн өмчид байж болохыг баталгаажуулснаар газар өмчлөлийн асуудал яригдах болсон. Харин газар өмчлөл тодорхой шалтгааны улмаас хойшлогдсоор 2002 онд “Монгол улсын иргэнд газар өмчлүүлэх тухай” хуулийг батлан гаргасан нь манай улсын хувьд анхдагч, түүхэн ач холбогдолтойн дээр газрын шинэтгэлийн эрх зүйн орчныг бүрдүүлсэн алхам болсон.

Зохистой аюулгүй хоол хүнсээр жигд, хүртээмжтэй хангагдах эрхийн тухайд

Гэвч эрх баригчид газар өмчлөлийн хуулиудыг батлан гаргахдаа хуулийн төслийг ард түмэнд танилцуулж санал, хүсэлтийг нь шүүн тусгахын оронд газар тариалангийн үйлдвэрлэл эрхэлдэг аж ахуйн нэгжүүдийн удирдах цөөхөн хүмүүс, хот суурингийн төрийн захиргааны удирдах ажилтнуудаас санал аван яаравчлан гаргасан байна. Ийм байдлаар хууль батлагдан гарсны улмаас:

- o Монгол улсын үндсэн хуулийн шударга ёс, тэгш байдлын зарчмаас ухарсан,
- o иргэнээ оршин суугаа нутаг дэвсгэр, эрхэлж байсан ажил мэргэжил, гэрлэсэн хугацаагаар нь ялгаварласан төдийгүй, газар тариалангийн газрыг өмчлөх эрх хөрөнгөтэй хүмүүст нээлттэй болсон,
- o газар өмчлөлийн асуудлыг ганц засаг дарга үзэмжээрээ шийдэх эрхтэй болсон,
- o үндсэн хууль болон иргэний хуулиар баталгаажсан иргэний хувийн өмчид шүүхийн шийдвэргүйгээр халдах боломж үүсгэсэн,
- o төрийн албан хаагчид хахууль авах үүд нээсэн, газар өмчлөлийн асуудалд тухайн орон нутгийн иргэд, төрийн бус байгууллагууд хяналт тавих боломжийг орхигдуулснаараа гарсан цагаасаа иргэдийн нилээд хэсгийн хууль ёсны болон жам ёсны эрх ашгийг хөндөн тэдний бухимдлыг төрүүлсэн хууль болсныг олон нийт шүүмжлэн ярьж, байгааг анхаарах ёстой гэж үзэж байна.

Газар тариалангийн бүс нутаг болох Сэлэнгэ, Төв аймагт ядуу болон ядуувтар нэг ч иргэн хүнсний ногооны газар өмчилж аваагүй байна. Улсын хэмжээнд газар тариалан эрхэлж байгаа иргэд 76546 байгаа боловч үүнээс дөнгөж 31 иргэн хүнсний ногооны 12 га газар өмчилж авсан (Архангай) байна.

◆ **Хүнсний аж үйлдвэр** Монгол улсад 1991 оны эхнээс учирсан эдийн засгийн хямрал нь Хүнсний аж үйлдвэрт туйлийн хүнд тусаж, хэвийн ажиллагаа нь зогсонги байдалд орсноор хүнсний хангамж ноцтой алдагдсан билээ. Хүнсний гол нэрийн бүтээгдэхүүний үйлдвэрлэлт 1990 оны түвшингээс эрс буурсан боловч өнөөгийн хүнсний аж үйлдвэрийн ажиллагаанд хэд хэдэн дэвшилттэй эхлэл ажиглагдаж байна. Салбарын бүтэц сүүлийн 10 жилд эрс өөрчлөгдөж, 50 хүртэл ажиллагсадтай жижиг, дунд үйлдвэрүүд төв, хөдөөд олноор бий болж, нийт бүтээгдэхүүний 80 гаруй хувийг үйлдвэрлэх болов.

Хүнсний аж үйлдвэрийн нийт бүтээгдэхүүний үйлдвэрлэлт 1999 оноос эхлэн дээшлэх хандлага бий болж байна. Хүнсний гол нэрийн бүтээгдэхүүний үйлдвэрлэлийг дээрх хугацаагаар авч үзвэл 2003 онд үйлдвэрийн аргаар бэлтгэсэн мах, махан бүтээгдэхүүний үйлдвэрлэл 79.7%, нарийн боов, талх 4.5-22%, хиам 9.8%-аар тус тус өссөн байна. Гэвч архины үйлдвэрлэл 2001 онд 1999 оныхоос 56.5%, спирт 25.6%-аар тус тус нэмэгдсэн нь хүнсний бусад бүтээгдэхүүний өсөлтөөс давамгайлж байгаа нь талархан хүлээн авах үзүүлэлт биш юм.

Гэтэл түүхий эдийн хангамж, эдийн засгийн бэрхшээл, төрийн бодлого, зохицуулалт төгөлдөржөөгүй зэрэг олон шалтгааны улмаас нэгэнт суурилагдсан үйлдвэрлэлийн хүчин чадлын ашиглалт тун хангалтгүй байгаа юм. Үүний нэг жишээ бол үр тарианы дутагдалтайгаас хүч чадлынхаа өчүүхэн хэсгийг ашиглан, зарим нь зогсоход хүрсэн гурилын үйлдвэрүүд юм. Мөн хүнсний хэрэглээний чиг хандлага, эрүүл ахуйн шаардлага нь аль болох байгалийн унаган төрхт

бүтээгдэхүүнд чиглэгдэж байгаа өнөө үед хүнсний үйлдвэрлэлийн технологийн шинэчлэлд гол анхаарал төвлөрөх нь чухал байна (Л.Дамдинсүрэн, Л.Лхагваа нар).

◆ **Хүнс импортлолт** Манай улсад дотоодын үйлдвэрлэл буурахын хирээр нийт хүнсний бүтээгдэхүүний хэрэгцээний дотор импортын бүтээгдэхүүний эзлэх хувийн жин шууд хамааралтайгаар өсөж байна. Манай улс нэгэнтээ хүнсний түүхий эд, бүтээгдэхүүний жилийн хэрэгцээг дотоодын үйлдвэрлэлээрээ бүрэн хангаж чадахгүйгээс хүнсний хомсдол жил бүр гардаг тул уг хомсдлыг импортоор арилжааны болон тусламжийн шугамаар нөхөж байна.

УИХ, Засгийн газраас үндэсний үйлдвэрлэлийг сайжруулах талаар эрх зүйн олон баримт бичиг баталж, арга хэмжээ авч байгаа боловч үнэн хэрэгтээ хүнсний хангамжийн хараат байдал бодитой оршиж байна. Монгол улс зах зээлд нийлүүлж байгаа махнаас бусад хүнсний гол нэрийн тухайлбал, үр тариа, төмс, хүнсний ногоо, цөцгийн ба ургамлын тос зэрэг бүтээгдэхүүний 70-100%-ийг импортоор оруулж хэрэгцээгээ хангаж байна. Бүрэн бус мэдээгээр 1996-2003 онд жил бүр 17.3-46.5 мян. тн улаанбуудай импортолсон байна. ҮСГ-ын мэдээгээр 2003 онд 55.1 тн цөцгийн тос импортолж, хүн амын хүнсний хэрэгцээнд нийлүүлж буй гурилын 60%, төмсний 33.8%, согтууруулах ундааны 55.1%, шар айрагны 83.9%-ийг тус тус импортоор хангадаг болжээ. Ялангуяа буудай, гурилын хувьд ОХУ, БНХАУ, Казакстанаас манай орон шууд хараат байдалд орсон байна. Ялангуяа нийт импортлогдож буй таваарын улаан буудайн 80%-ийг Казакстан улсаас оруулж байна. Монгол оронд үйлдвэрлэдэггүй элсэн чихэр, ургамлын тос, цагаан, шар будааны хэрэгцээ бүхэлдээ, жимс, жимсгэний зонхилох хэсэг импортоор хангагдаж байна.

Монголд үйлдвэрлэх боломжгүй, зайлшгүй шаардлагатай бүтээгдэхүүнийг импортлохоос өөр арга үгүй боловч 1999 онд л гэхэд хүнсний 31 нэрийн бүтээгдэхүүн импортлогдсоны дотор сүү, цөцгийн тос, төмс, хүнсний ногоо, гурил, талх, талхан бүтээгдэхүүн, рашаан, ус, архи, согтууруулах ундаа, иоджуулсан давс зэрэг дотоодын үйлдвэрлэлээр бүрэн хангаж болох бүтээгдэхүүнүүд байна.

Мөн хэрэглээний 25 нэрийн барааны 18 төрөл нь гаднаас бүрэн хамааралтай, 3 бүтээгдэхүүний хувьд хагас хамааралтай, зөвхөн хоёрхон бүтээгдэхүүнээр бага хамааралтай гэсэн судалгаа ч байдаг.

Импортоор эдгээр бүтээгдэхүүнийг оруулж ирж байгаа наймаачдыг буруутгах аргагүй ч ийм хэмжээний бүтээгдэхүүнийг дотооддоо үйлдвэрлэж, борлуулах боломжийг алдсан нь үйлдвэрлэгчдийн хувьд дүгнэлт, судалгаа хийвэл зохих асуудлын нэг юм. Энэ бол үнээхээр анхаарал татсан нэн даруй шийдвэрлэх ёстой асуудал юм.

ОУ-ын тусламжийн байгууллагууд болон бусад улс орны Засгийн газраас үзүүлж буй тусламж нь ихэвчлэн хүн амд хүнсний зүйл, түүний түүхий эдийг шууд бэлнээр хангахад зориулагдаж, харин хүнсний үйлдвэрлэл, газар тариалангийн үйл ажиллагаанд техник, технологийн тусламж үзүүлэхгүй байгаагийн учир шалтгаан нь ОУ-ын хамтын ажиллагааны гэрээгээр ОУ-ын тусламжинд техник, технологийн огт оруулахгүй байхаар тохиролцсон байдаг тухай энэ чиглэлийн ажил хариуцсан ажилтнууд ярьж байна.

4. Хүнсний эрүүл ахуй, аюулгүй байдал (Food Safety and Hygiene)

ХҮНСНИЙ ЭРҮҮЛ АХУЙ гэдэг нь хүнсний сүлжээний бүх үе шатанд хүнсний аюулгүй, тохиромжтой байдлыг хангахад шаардлагатай бүхий л нөхцөл, арга хэмжээ юм.

ХҮНСНИЙ АЮУЛГҮЙ БАЙДАЛ гэдэг нь хоол, хүнсийг зориулалтын дагуу бэлтгэж, хэрэглэхэд хүний эрүүл мэндэд хор хөнөөл учрахгүй байх баталгааг хэлнэ.

Хүнсний аюулгүй байдалтай холбоотой үүсдэг өвчин эмгэгийг ерөнхийд нь хоол хүнсээр дамжих өвчин эмгэг гэж нэрлэдэг бөгөөд ДХХААБ, Хүнсний хууль эрх зүйн хороо (САС)-ын тодорхойлсноор хүн амын хүнсний аюулгүй байдалд гарах эрсдлүүдэд халдвар, хордлого, бие махбодийн хямрал, харшил, ямар нэг эрхтнийг барьж өвчлүүлэх зэрэг болно. Хүмүүс хэрэглэж буй хүнсээ аюулгүй, хэрэглэхэд зохимжтой байхыг хүсэн хүлээх бүрэн эрхтэй. Хоол хүнсээр дамжих өвчин эмгэг нь хүнийг наанадаж тааламжгүй байдал, цаашилбал үхэлд ч хүргэдэг.

Эрүүл ахуйн үр дүнтэй хяналт нь хүнс гэмтэж муудах, хоолноос хордох, улмаар хоол хүнсээр дамжих өвчин эмгэгийн хүний эрүүл мэнд, эдийн засагт учруулах муу үр дагавраас урьдчилан сэргийлэхэд чухал шаардлагатай юм. Мал аж ахуй эрхлэгчээс тариаланч, үйлдвэрлэгч, боловсруулагч, хүнс бэлтгэгч, хэрэглэгч хүртэл хүн бүр хүнсний аюулгүй бөгөөд хэрэглэхэд тохиромжтой байдлыг хангахад хариуцлага хүлээнэ.

Үүнээс үзэхэд хүнсний эрүүл ахуйг хангаснаар хэрэглэхэд тохиромжтой, аюулгүй хүнсийг үйлдвэрлэн түгээж, улмаар хүн амд хэрэглэх боломж бүрдэнэ гэж ойлгож байна.

Хүнсний эрүүл ахуй, аюулгүй байдлын талаар төрөөс авч буй арга хэмжээ

1999 оны Хүнсний тухай хуулийн зорилго нь хүн амыг аюулгүй хүнсээр хангах явдал юм. Уг хууль нь хүнсний үйлдвэрлэл, үйлчилгээ, импортлолын явцад хүнсний эрүүл ахуй, аюулгүй байдлыг хангахад голлон анхаарчээ. Хуулийн агуулга үндсэндээ хүнсний аюулгүй байдлыг хангуулахад хуулийн этгээдүүдийн эрх, үүрэг, үндсэн шаардлагуудыг тодорхойлж, түүнд тавих төрийн хяналт болон түүний бүтэц, ажлын зааг, уялдааг тодорхой зааж, төрийн хяналтанд хөндлөнгөөс оролцох бусад хяналтын оролцоог тусгасан нь хүн амын хүнсний аюулгүй байдлыг хангахтай холбогдон гарах бүх талын харилцааг хуулиар зохицуулах боломжийг бүрдүүлсэн юм.

Гэвч Засгийн газраас бүрэн эрхийнхээ хүрээнд хэрэгжүүлэх 5.1.3-т заасан “хүнсний аюулгүй байдлын үзүүлэлтийг тодорхойлох, хүнсийг улсын хилээр нэвтрүүлэхэд хяналт тавих журам тогтоох” гэсэн заалт болон 5.1.9-д заасан “хүнсний аюулгүй байдалд тавих хяналтын дүрэм батлах” гэсэн заалтууд одоог хүртэл хэрэгжээгүй байна. Харин хүнсний бүтээгдэхүүний аюулгүй байдалд ЭАХС-ын Хяналтын Улсын Ерөнхий байцаагчийн 1995 оны 09 тоот тушаалаар баталсан “Хүнсний бүтээгдэхүүний аюулгүйн үзүүлэлт”-ийг үндэслэдэг боловч тэр нь бүрэн бус, хэрэглэхэд учир дутагдалтай байдаг тул гол төлөв ОХУ-д мөрдөж буй үзүүлэлтүүдийг үндэслэн үнэлгээ өгдөг байна.

Мөн хүнсний аюулгүй байдал (ХАБ)-ын эрх зүйн зохицуулалт 1998 оны “Эрүүл

мэндийн тухай” хууль, мөн онд гарсан “Ариун цэврийн тухай” хуулиар зохицуулагдаж байна.

Дээрх хуулиудыг хэрэгжүүлэх үйл ажиллагааны хүрээнд төрөөс баримтлах хэд хэдэн бодлого стратегид хүнсний чанар, аюулгүй байдалтай холбоотой заалтуудыг тусгасан байна. Тухайлбал: 2001 оны “Нийгмийн эрүүл мэндийн талаар төрөөс баримтлах бодлого” эрүүл мэндийн анхны тусламжийн хүрээнд монгол хүн амьдрал-ынхаа туршид тэжээллэг чанар бүхий аюулгүй экологийн цэвэр хоол хүнсээр хангагдах, зөв хэрэглэх нөхцөлийг бүрдүүлэх арга хэмжээг заасан байдаг.

Харин УИХ бүрэн эрхийнхээ хүрээнд “Хүнсний тухай” (1999 оны) хуулийн 4.1.1-д заасан хүн амын ... хүнсний аюулгүй байдлын талаар төрөөс баримтлах бодлогыг тодорхойлохоор заасан боловч одоогоор ийм бодлого манайд байхгүй байна.

2004 оны “Монгол улсын төрөөс хүн амын хөгжлийн талаар баримтлах бодлого”-ын 3.6.3-т “Хүн амын хүнсний аюулгүй байдалд тавих эрүүл ахуй, халдвар судлалын хяналтыг тогтмолжуулах” асуудал багтжээ.

Филиппин улсын Манил хотноо 2000 оны 11 дүгээр сард болсон ДЭМБ-ын Номхон далайн баруун бүсийн “Хүнсний аюулгүй байдлын стратеги боловсруулах” хурлаас бүсийн хүнсний аюулгүй байдлын өнөөгийн байдлыг тодорхойлж, бүсээс энэ талаар баримтлах тэргүүлэх асуудлуудыг тодорхойлсон бөгөөд 2001 онд бүсийн хорооны удаах хурлаар уг стратегийг баталж, гишүүн орнуудын үүрэг, бүсийн төвөөс хийх ажлыг тодорхойлсон билээ.

- Бүсийн хүнсний аюулгүй байдлын талаар баримтлах тэргүүлэх асуудлуудад:
- o Салбар дундын бодлого, засгийн газар үйлдвэрийн хамтын ажиллагааг өргөжүүлж,
 - o Хүнсний аюулгүй байдал, хоол тэжээлийн асуудлыг хүнсний хангамж, ядуурлыг бууруулах асуудалтай уялдуулах,
 - o Эрсдэлд тулгуурласан хууль, дүрэм зааврыг боловсруулж мөрдөх,
 - o Хууль эрхийн хорооны стандартуудыг батлуулж мөрдөх,
 - o Хоол хүнснээс гаралтай өвчний хяналт, тандалтыг хангах,
 - o Үндэсний лабораторийн хүчин чадлыг нэмэгдүүлэх
 - o Түүхий эдээс хэрэглээ хүртэл үр дүнтэй хяналт тавих,
 - o НАССР-ыг өргөнөөр нэвтрүүлэх зэрэг асуудлуудыг дэвшүүлэн тавьсан билээ.

◆ **Хүнсний аюулгүй байдлын хяналтын бүтэц, зохион байгуулалт**

УМХГ-ын Эрүүл мэндийн хяналтын хэлтэс (ЭМХХ), Үйлдвэр, худалдааны хяналтын хэлтэс, Боловсролын хяналтын хэлтэс, ХАБ, хөдөө аж ахуйн хяналтын хэлтэс хамтран хүнсний аюулгүй байдлын хяналт тавих үүрэгтэй.

Хүнсний аюулгүй байдалд тавьж буй эрүүл мэндийн хяналтын гол зорилго нь хоол, хүнсний бүтээгдэхүүн хүний эрүүл мэндэд сөрөг нөлөө үзүүлэхээс сэргийлэх, хоолны хордлого, халдвар гарсан тохиолдолд шалтгааныг судлан тогтоох, эрүүл мэндийн тусламж үйлчилгээг нэгэн зэрэг үзүүлэх цогцолбор арга хэмжээ юм.

Хүнсний аюулгүй байдлын хяналтыг Монгол улсын Ариун цэврийн тухай, Хүнсний тухай, Хэрэглэгчдийн эрх ашгийг хамгаалах тухай, Стандартчилал, тохирлын үнэлгээний тухай, Хилийн тухай, Усны тухай зэрэг хууль, УИХ, засгийн газрын тогтоол, үндэсний хөтөлбөр, үндэсний стандартууд зэрэг хууль эрхийн

актуудын хүрээнд гүйцэтгэж байна.

Хүнсний тухай хуулийн 13.1-д “Хүнсний аюулгүй байдалд тавих хяналтыг хүнсний үйлдвэрлэлийн техник, технологи, эрүүл ахуй, үр, ургамал, хорио цээр, мал эмнэлэг, ариун цэврийн мэргэшсэн улсын байцаагч хийнэ” хэмээн зааж, тэдний бүрэн эрхийг хэрэгжүүлэх чиглэлийг мэргэжил тус бүрээр ялган зааглаж өгсөн байдаг. Хөдөө аж ахуйн хяналтын хэлтэс (ХАБХААХХ)-ийн Мал эмнэлэг, үржлийн хяналтын алба (МЭҮХА)-ны мал, амьтан, тэдгээрийн гаралтай бүтээгдэхүүн, түүхий эдийг экспортлох, импортлоход олон улсын гэрээ, хэлэлцээр, үндэсний стандартын шаардлага хангаж байгаа эсэхэд хяналт тавих үүрэг нь Хилийн мэргэжлийн хяналтын алба (ХМХА)-ны үйл ажиллагааны үндсэн чиглэлтэй давхцаж болох талтай байгаа бөгөөд уг албаны мал, амьтны гаралтай түүхий эд, бүтээгдэхүүнийг дотооддоо хянах, судалж, дүгнэх асуудлыг үйл ажиллагааны чиглэлдээ оруулалгүй орхигдуулсан дутагдал ажиглагдаж байна. Энэ нь Хүнсний тухай хуулийн 13 дугаар зүйлийн 1.2-р заалтын нэг талаар, “зах зээлд борлогдож байгаа мал, амьтны гаралтай хүнсийг хянах”, нөгөө талаар, “мал, амьтны гаралтай хүнсний түүхий эдийг зөвхөн хянах” гэсэн 2 ухагдахуунтай мал эмнэлгийн хяналтын үйл ажиллагааны чиглэл зөрчилдөж байна.

ЭМХХ-ийн Эрүүл ахуй, халдвар судлалын хяналтын алба (ЭАХСХА) нь хүнсний үйлдвэрлэл, үйлчилгээний байгууллагын эрүүл ахуй, халдвар хамгааллын дэглэм, хүнсээр дамжиж үүсгэгдсэн хордлогуудын шалтгаан, нийгмийн эрүүл мэндийн тусламж, үйлчилгээ, согтууруулах ундааны чанар, эрүүл ахуйн үзүүлэлтэнд дүгнэлт гаргах үйл ажиллагааг үндсэндээ явуулж байгаа нь согтууруулах ундаанаас бусад хүнсний бүтээгдэхүүний аюулгүй байдлыг хянах тухай Хүнсний тухай хуулийн 13 дугаар зүйлийн 1.1-д заасан “эрүүл ахуй, халдвар судлалын улсын байцаагч нь ... хэрэглэхэд бэлэн болсон хүнсний ариун цэвэр, эрүүл ахуйн аюулгүй байдлыг хянах” гэсэн заалттай зөрчилдөж байна. Энэ нь хүнсний бүтээгдэхүүний аюулгүй байдлын үзүүлэлтүүдийг хянаж, хүнсний бүтээгдэхүүний бохирдлоос хүн амын эрүүл мэндийг хохироохоос урьдчилан сэргийлж, хамгаалах үйл ажиллагаа явуулах бус, харин нэгэнт эрүүл мэндээр хохирсон хойно нь шалтгааныг нь нэхэн судлах хуучин тогтолцоо руу ухарч буй хандлага ажиглагдаж байна.

◆ Хүнсний ЭАХС-ын хяналтанд тулгарч буй бэрхшээл, дутагдал

1990-ээд оны үед хүнсний үйлдвэрлэл, үйлчилгээ эрхэлдэг төрийн өмчийн томоохон цөөн тооны объектууд байдаг байсан бол зах зээлд шилжсэнээс хойш хувийн хэвшлийн жижиг, дунд үйлдвэр, худалдааны байгууллагууд олширсоор 1996 онд хяналтын 9006 объект байсан бол 2004 онд 14709 болж 1.6 дахин нэмэгдсэн боловч тэдгээрт хяналт тавьдаг хүнсний эрүүл ахуйчдын тоо нэмэгдээгүй байна. Хүнсний ЭАХС-ын хяналтыг улс, нийслэл, аймаг, хотын хэмжээнд 47 хүнсний эрүүл ахуйн улсын байцаагч тавьж, 1 байцаагчид дунджаар 313 объект ногдож байна.

УМХГ, түүний харьяа аймгийн мэргэжлийн хяналтын газраас маш олон тооны хяналт, шинжилгээ хийгддэг боловч шинжилгээний дүнг орон нутаг болон холбогдох яам, тусгай газарт эргэн мэдээлдэггүйгээс хүн амын өвчлөлтэй холбон үнэлгээ, дүгнэлт өгөх, хэрэглэгчдийн хүнсний аюулгүй байдлын мэдлэг, боловсролыг дээшлүүлэх улмаар ХАБ-ын үндэсний мэдээллийн сан үүсгэх талаар ДЭМБ-ын зөвлөхүүдийн өгсөн зөвлөмжүүдийг хэрэгжүүлж чадахгүй байна

(Б.Энхтунгалаг, Ш.Энхцэцэг ба бус., “Монгол дахь хүнсний аюулгүй байдал ба хэтийн төлөв” судалгааны тайлангаас).

Хүнсний хяналтын болон судалгаа шинжилгээний лабораторийн хүчин чадал сул, лабораторийн мэргэжилтэй боловсон хүчин дутагдалтай, ялангуяа түргэвчилсэн аргаар шинжилгээ хийж дүгнэлт гаргах боломжгүй байна. Аль ч лабораториудын бүтээгдэхүүнд тодорхойлж буй үзүүлэлтүүдийн тоо олон улсын жишигт хүрэхгүй байна. Тухайлбал, хүнсний нэмэлт, биологийн өндөр идэвхит бодисууд, листери, кампилобактер, стафилококкын хор, вирус, афлотоксин, моноцитоз, органик бодисын үлдэгдэл, амьтны гаралтай бүтээгдэхүүнд антибиотекийн үлдэгдэл тодорхойлох, хуурамч архийг төгс шинжлэх лаборатори байхгүй байна. Хүнсний сав баглаа боодолд агуулагдах химийн хортой бодисуудыг шинжлэх лаборатори хөгжөөгүй байна.

Манай улс өнөөдөр хүнсний бүтээгдэхүүнийхээ 80%-ийг импортолж, 22 боомтоор хүнсний бүтээгдэхүүн нэвтрүүлж байна. Хүнсний тухай хуулийн 12 дугаар зүйлийн 4-т *“Байнгын ажиллагаатай хилийн боомтод хүнсний аюулгүйн үзүүлэлт, бусад боомтод хүнсний аюулгүйн анхан шатны үзүүлэлтийг тодорхойлох лаборатори бүхий хяналтын алба ажиллуулна”* хэмээн заасан байдаг. Гэтэл байнгын (13) болон улирлын ажиллагаатай 22 хилийн боомт дээр Хилийн эрүүл ахуй, халдвар судлалын 14 товчоо, салбар ажиллаж байгаа боловч Замын-Үүдийн боомтод зөвхөн хүнсний аюулгүйн анхан шатны үзүүлэлт тодорхойлох шинжилгээ, бусад боомтуудад мэдрэхүйн (харах, үнэртэх, хүрэх, амтлах зэрэг) үзүүлэлтэд үндэслэн үзлэг шалгалт хийгдэж, нарийвчилсан шинжилгээг Улаанбаатар хотод УМХГ (гүний хяналт) хийж байна. Ийнхүү иж бүрэн хяналт тавьж чадахгүй байгаагаас дээрх 22 боомтоор эрүүл ахуй, аюулгүй байдлын шаардлагад тохирохгүй ямар их бүтээгдэхүүн оруулж, хоол хүнсээр дамжиж, хичнээн хүнийг өвчлүүлж буйг тооцохын аргагүй юм. Энэ бол үнэхээр “аймшигтай” зүйлийн нэг юм.

(үргэлжлэл дараагийн дугаарт)

СЭЖИГТЭН ЯЛЛАГДАГЧИЙН ЭРХИЙГ БАТАЛГААТАЙ ХАНГАХ ЗАРИМ АСУУДАЛ

П.Оюунчимэг,
ХЭҮК-ын ахлах референт, магистр

Эрүүгийн байцаан шийтгэх ажиллагаа бол хүний эрхийн талаасаа их анхаарал татдаг, эрсдэл ихтэй учраас энэхүү ажиллагаанд оролцогчдын эрхийг хамгаалах нь хүний эрхийн чухал асуудал юм.

Байцаан шийтгэх ажиллагаа нь хэдийгээр хуулиар тогтоосон журмаар хэрэгждэг боловч энэхүү журам горимыг санаатай буюу санамсаргүйгээр өчүүхэн төдий л гажуудуулбал тэртэй тэргүй эрх нь хөндөгдөөд байгаа оролцогчдын эрхийг зөрчих магадлал эрсдэлийг цаг ямагт дагуулж байдаг. Ялангуяа сэжигтэн, яллагдагчийн хувьд энэ нь илүү хурцаар хөндөгдөнө.

Монгол улсын Эрүүгийн байцаан шийтгэх хуулинд зааснаар хэргийн сэжигтэн, яллагдагч нар энэ ажилла-гааны гол оролцогч байдаг.

Сэжигтэн, яллагдагч нарын эрхийн хамгаалалтын асуудлыг ЭБШХ болон олон улсын баримт бичгийн хүрээнд сонирхвол олон улсын гэрээ, конвенциор эдгээр оролцогч нарын эрхийг хамгаалах зохицуулалт хийсэн заалтууд цөөнгүй байдаг боловч харамсалтай нь үүнийг ЭБШ ажиллагааг хэрэгжүүлэгчид огтхон ч авч үздэггүй байна.

Эрүүгийн байцаан шийтгэх хуульд олон улсын гэрээний талаар тусгайлан заалт байхгүй гэж маргаж болох боловч ЭБШ хуулийн 2 дугаар зүйлийн 2.1-д: “Монгол Улсын нутаг дэвсгэр дээр эрүүгийн байцаан шийтгэх ажиллагаа явуулахад Үндсэн хуулийг **удирдлага болгож**, энэ хуулийг баримтална” гэж заасан.

Үндсэн хуулийн заалтаас /Аравдугаар зүйл/ үзэхэд Монгол улс нь олон улсын гэрээг шударгаар сахиж биелүүлэх үүрэгтэй бөгөөд соёрхон баталсан олон улсын гэрээ нь дотоодын хууль тогтоомжийн нэгэн адил хүчинтэй байна. ЭБШ хуулийн 2 дугаар зүйлийн 2.1-ээр эрүүгийн байцаан шийтгэх ажиллагааг явуулахдаа олон улсын баримт бичгийг удирдлага болгох, тэдгээрт нийцүүлэх шаардлага Үндсэн хуулиас зүй ёсоор урган гарч байгааг анхаарах ёстой.

- Монгол улсын нэгдэн орсон олон улсын гэрээ, конвенци дотоодын хууль тогтоомжийн нэгэн адил үйлчлэх учраас олон улсын гэрээ конвенци болон дотоодын хууль тогтоомжуудын заалтыг сэжигтэн, яллагдагч нарын эдлэх эрхтэй холбогдуулан харьцуулсан байдлаар гаргахыг оролдоё.

Сэжигтэн, яллагдагч нь ЭБШХ-д зааснаар эрүүгийн байцаан шийтгэх ажиллагаанд тодорхой эрх эдэлдэг.

Сэжигтэн нь:

- ямар хэрэгт сэрдэгдэж байгаагаа мэдэх,
- өөртэй нь холбогдуулж эрүүгийн хэрэг үүсгэсэн, баривчилсан буюу таслан сэргийлэх арга хэмжээ авсан тогтоолтой танилцах,
- баримт сэлт гаргаж өгөх, нотлох баримт шалгуулах хүсэлт гаргах,
- мэдүүлэг өгөх, мэдүүлэг өгөхөөс татгалзах,
- эх хэлээрээ болон мэддэг хэлээрээ мэдүүлэг өгөх, орчуулагч, хэлмэрч авах
- хэрэг бүртгэгч, мөрдөн байцаагч, прокурор, орчуулагч, хэлмэрч, шинжээчийг татгалзан гаргах тухай хүсэлт гаргах,
- өөрийгөө өмгөөлөх, өмгөөлөгч авах,
- өмгөөлөгчтэйгээ ганцаарчлан уулзах,
- хэрэг бүртгэгч, мөрдөн байцаагчийн зөвшөөрснөөр байцаан шийтгэх ажиллагаанд оролцох,
- хэрэг бүртгэгч, мөрдөн байцаагч, прокурорын үйл ажиллагаа, шийдвэрт гомдол гаргах,
- хэрэг бүртгэгч, мөрдөн байцаагч, прокурорын хууль зөрчсөн үйл ажиллагааны улмаас учирсан хохирлоо нөхөн төлүүлэх эрхтэй байна.

Яллагдагч нь эрүүгийн байцаан шийтгэх ажиллагаанд оролцоходоо сэжигтэнтэй холбоотой дээрхи эрхүүдээс гадна:

- яллагдагчаар татсан болон таслан сэргийлэх арга хэмжээ авсан тогтоолтой танилцах,
- өөрийгөө өмгөөлөх буюу өмгөөлөгч авах,
- сонгосон ялын талаар амаар болон бичгээр тайлбар өгөх,
- баримт сэлт гаргаж өгөх, нотлох баримт шалгуулах хүсэлт гаргах,
- өөрт холбогдсон хэргийн материалтай танилцах,
- шүүх хуралдаанд оролцох,
- хэрэг бүртгэгч, мөрдөн байцаагч, прокурор, орчуулагч, шинжээч, шүүгч, иргэдийн төлөөлөгч, шүүх хуралдааны нарийн бичгийн даргыг татгалзан гаргах тухай хүсэлт гаргах,
- шинжээч томилсон тогтоол болон шинжээчийн дүгнэлттэй танилцах,
- шүүх хуралдаанд эцсийн үг хэлэх,
- шүүхийн шийдвэрт гомдол гаргах

Эдгээрээс үзэхэд байцаан шийтгэх ажиллагааны онцлогтой холбогдоод сэжигтэн, яллагдагчийн зарим тодорхой эрхийг ЭБШХ-нд тусгайлан нэрлэсэн байгаа боловч мэдээж энэ нь тэдний бусад хуулиар эдлэх эрхүүдийг хязгаарлахгүй нь ойлгомжтой. Тиймээс сэжигтэн/яллагдагч/-ийн эрхийн асуудлыг зөвхөн ЭБШХ-иар хязгаарлах нь учир дутагдалтай. Сэжигтэн, яллагдагч нь эрүү шүүлтээс ангид байх, ойр дотныхоо хүний эсрэг мэдүүлэг өгөхгүй байх, хуулийн шаардлага хангасан байранд хоригдох гэх мэт эрхүүдийг бусад хуулийн дагуу эдлэх ёстой.

Сэжигтнээр тооцогдсон хүнд юуны өмнө баривчлагдах /хоригдох/ улмаар гэмт хэрэг тулгагдаж, шийтгүүлэх аюул/эрсдэл/ шууд тулгардаг учраас юуны өмнө баривчлах үндэслэл, хязгаарлалт, хорих байрны нөхцөл, байцаалтын зөв аргыг хэрхэн ашиглахыг олон улсын баримт бичгүүдэд тусган энэ тал дээр онцгой анхаарал хандуулдаг.

- Монгол улсын 1974 онд нэгдэн орсон “Иргэний болон улс төрийн эрхийн тухай олон улсын пакт”-ийн 9 дүгээр зүйлийн 9.3-д зааснаар... шүүхийн өмнөх шатанд байгаа хүнийг заавал цагдан хорьж байх нийтлэг журам байх албагүй гэж заасан.

Манай ЭБШХ-ийн Наймдугаар бүлэгт сэжигтнийг баривчлах асуудлыг тусгайлан тусгасан нь шинэ хуулийн өмнөх хуулиасаа ялгагдах нэг онцлог юм.

Хууль тогтоогч баривчлахыг эрүүгийн байцаан шийтгэх ажиллагааны явцад авдаг таслан сэргийлэх арга хэмжээнээс /үүнийг ЭБШХ-ийн 9-р бүлгээр зохицуулсан/ тусад нь зөвхөн “сэжигтэн” гэсэн эрх зүйн байдлыг нь онцгойлон авч үзсэн бололтой. Сэжигтнийг гурван тохиолдолд, нэгдүгээрт, сэжигтэн оргон зугатахыг завдсан, хоёрдугаарт, хүнд гэмт хэрэгт, гуравдугаарт, онц хүнд гэмт хэрэгт сэрдэгдэж буй бол баривчлахаар /хуулийн 58 дугаар заалт/ заасан. Үүнийг оргон зугатахыг завдсан сэжигтнийг болон онц хүнд гэмт хэрэгт сэрдэгдэгсдийг баривчлахыг зүй ёсны гэж ойлгож үзэж болох боловч хүнд гэмт хэрэгт холбогдогсдыг заавал баривчилж байхаар хуульчилсны үндэслэлийг зөвтгөхөд төвөгтэй юм.

Эрүүгийн хуулиас харахад нийтдээ 352 үйлдлийг гэмт хэрэгт тооцсон байх бөгөөд үүнээс 65 үйлдлийг хөнгөн, 185 үйлдлийг хүндэвтэр, 68 үйлдлийг хүнд, 34 үйлдлийг онц хүнд гэмт хэрэгт тооцжээ. ЭБШХ-ийн дээрхи заалтаас харахад нийтдээ хүнд, онц хүнд 102 үйлдэлд хардагдаж сэрдэгдсэн хүнийг зөвхөн зүйл ангийг нь хараад шууд баривчлах үндэслэл нээлттэй байна.¹

ЭБШХ-ийн 58.1-д заасан заалт нь императив шинжтэй норм. Учир нь зөвхөн баривчилна гэж таслан сэргийлэх арга хэмжээг сонгох хувилбаргүйгээр тогтоожээ. Шууд баривчлах “хүнд” гэмт хэрэгт татварын хэрэг, гологдол буюу чанар муутай бүтээгдэхүүн худалдах, газрын хэвлийг ашиглах, хамгаалах журам зөрчих, тээврийн хэрэгслэлийн аюулгүй байдлын болон ашиглалтын журам зөрчих /болгоомжгүй хэрэг/, гэх мэтийн мөрдөн байцаалтын явцад шүүхэд хэрэг нь шилжих эсэх нь шийдвэрлэгддэг үйлдлүүд зонхилж байна. Тэгэхээр ийм хэргүүдэд сэрдэгдсэн хүмүүсийг эхнээс нь шууд л баривчилж хорихоор хуульчилсан нь хүний халдашгүй эрхийг ноцтойгоор зөрчихөд хүргэж буй заалт юм.

Харин өмнөх ЭБШХ-д сэжигтнийг тодорхой үндэслэл бүхий үед албадан саатуулах “эрхийг” хэрэг бүртгэгч, мөрдөн байцаагч, прокурорт олгосон /137-р зүйл/ байсан нь шинэ хуулийн баривчилна гэсэн императив заалтаас өөр, сонголт хийхийг зөвшөөрсөн утга агуулгатай байсан нь илт байна.

- Эрүүгийн байцаан шийтгэх хуульд сэжигтнээр тооцох журмыг тогтоосон атлаа /35.1/ ямар хугацаанд сэжигтнээр тооцогдох, өөрөөр хэлбэл хэзээ дуусгавар болгохыг тусгаагүй учраас хэргийг илэртэл, эсхүл хэргийг шийдвэрлэгдтэл сэжигтэн хэвээр байж эрх нь байнга хөндөгдөх нөхцөлд байна гэсэн үг.

¹ “Хүний эрх, эрх чөлөөний тухай Монгол улсын илтгэл” 2003 он, 50-р талд

Нэгэнт сэжигтэн гэж тооцогдсон учраас таслан сэргийлэх арга хэмжээ нь хүчингүй болдоггүй, тодорхойгүй хугацаагаар хэрэглэдэгээс шалтгаалан дараагийн шатанд тухайн хүний эдлэх ёстой эрхүүд нь хязгаарлагдмал байдалд хэрэгжих шалтаг болж өгдөг. Жишээлбэл: чөлөөтэй зорчих эрхийн асуудал дээр гэхэд л гадаад дотоодод зорчиход мөрдөн байцаагчаас байнгын хараат байдалд зөвшөөрөл авах, дуудсан цагт ирэх үүргийг хүлээдэг учраас тухайн хүн хөдөлмөрлөх эрхээ бүрэн хэмжээгээр хэрэгжүүлэхэд саад учрах гэх мэт дагавар байнга дагалдан хүлээж байхаар байна.

- Эрүүгийн байцаан шийтгэх хуульд зааснаар гэмт хэрэгт сэжиглэж бусдыг баривчилж хорьж болох үндэслэлийг тодорхой заасан хирнээ буцаагаад суллах, хорих, цагдах таслан сэргийлэх арга хэмжээг өөрчлөх болзол журам, заалтыг орхигдуулснаас практик ажилтнуудын дунд хоригдогсдыг шүүхэд шилжихээс өмнө нь гаргасан ч эс гаргасан ч дурын хэрэг мэтээр хандах, хэрэг бүртгэгч, мөрдөн байцаагч нар нь саналаа прокурорт өгөхгүй байх, үндэслэлгүйгээр ёс юм шиг удаан хугацаагаар хорих нь ихээхэн түгээмэл байна.

Тэгээд ч хоригдсон хүмүүсийн ар гэрээс таслан сэргийлэх арга хэмжээг өөрчлөх тухай хүсэлтийг гаргахад ч хүндрэл гарч байгааг хэлэх хэрэгтэй. Мөрдөн байцаагч, прокурор, шүүгчийн хэн нь энэ таслан сэргийлэх арга хэмжээг өөрчлүүлэх тухай гомдол санал хүсэлтийг шийдвэрлэх нь тодорхойгүй байгаа нь олон хоног сараар хоригдож байгаа ар гэрийнхэнд нь хүртэл төвөгтэй байдлыг үүсгэж байгаа нь нууц биш юм.

Зүй нь хэрэг нь нэгэнт тогтоогдсон, тодорхой хаягтай, эд хөрөнгөтэй, эсхүл ихээхэн маргаантай ээдрээ төвөгтэй хэрэгт сэжиглэгдэгсэд, хүүхэд эмэгтэйчүүдийг нэн даруй суллах болзол журмыг хуульчилж хэрэг бүртгэгч, мөрдөн байцаагч нарт тодорхой нөхцөл болзол бий болсон үед цагдан хорих таслан сэргийлэх арга хэмжээг нэн даруй өөрчилж байх үүргийг ноогдуулж өгөх нь энэ хуулийг хүнлэг энэрэнгүй болгох нэг чухал алхам болохын зэрэгцээ энэ нь заалтыг хуульчлан хэрэгжүүлэх, олон улсын өмнө хүлээсэн үүргээ биелүүлэхэд тус дөхөм үзүүлнэ гэсэн үг.

- Яллагдагчид цагдан хорих таслан сэргийлэх арга хэмжээ авахад шүүгч зөвшөөрөл өгөхтэй холбоотой шинэ хуулийн зохицуулалт нь 9 дүгээр зүйлийн 9.3-д зааснаар ... баривчлагдсан буюу эрүүгийн хэрэгт буруутгагдсан аль ч хүнийг шүүгч буюу шүүн таслах эрх хэмжээ олгогдсон албан тушаалтан зөвшөөрөл олгохоор заасантай тохирсон байх бөгөөд ингэснээр эрүүгийн байцаан шийтгэх ажиллагаанд хүний эрхийг баталгаажуулахад чиглэсэн чухал алхам болсон.

Бусдын халдашгүй эрхэнд халдах зөвшөөрлийг гэмт хэргийг илрүүлэх, эрүүгийн байцаан шийтгэх ажиллагаанд эхнээс нь дуустал хяналт тавих эрх бүхий субъект болох прокурор захиргааны журмаар бус харин шүүх яллагч болон өмгөөлөгчийн байр суурь, хэргийн материалд авагдсан нотлох баримтыг шинжлэн дүгнэж мэтгэлцэх зарчмын үндсэн дээр гаргаж байгаа нь хүний эрхэд эерэг нөлөө

үзүүлэх нь гарцаагүй.

Хэдийгээр баривчлагдсан, цагдан хоригдсон хүний тоо буурч байгаа боловч, үндэслэлгүйгээр хорих явдал их хэмжээгээр байсаар байна. Зарим шүүх баривчлах, цагдан хорих тухай саналыг баталгаажуулагч болж байгааг шүүмжилж байна.

Шүүхэд зөвшөөрлийн эрх шилжсэний гол агуулга бол гэмт хэргийн илрүүлэлт, мөрдөн байцаалтын ажиллагаанд ямар нэг сонирхолгүй, хөндлөнгийн байгууллагаас /шүүхээс/ хорих сонирхлыг илэрхийлэгч цагдаа, прокурорын болон сэжигтэн, яллагдагч тэдгээрийн өмгөөлөгчийн байр суурь, тайлбарыг сонсож байж /мэтгэлцэх зарчмын үндсэн дээр/ шийдвэр гаргахад оршино.

2003 оны эхний улиралд хоригдсон хүний тоог өмнөх оны мөн үеийнхтэй харьцуулахад албадан саатуулагдаж байсан хүн 81.2 хувиар, сэжигтнээр хоригдогсад 27.4 хувиар, яллагдагчаар цагдан хоригдогсад 26.3 хувиар тус тус цөөрсөн тухай Шүүх эрх мэдлийн болон хууль сахиулах төв орон нутгийн байгууллагуудын нэгдсэн зөвлөлгөөний илтгэлд дурджээ.²

- Эрүүгийн гэмт хэрэгт ялагдан саатуулагдсан этгээд хэргээ боломжтой богино хугацаанд шүүхээр хэлэлцүүлэх, тэрчлэн шүүхийн хэлэлцүүлэг болохоос өмнө суллагдах эрхтэй. Тодорхой хэргийг мөрдөн шалгах хийгээд, нийгэм хохирогчийг хамгаалах зорилгоор шүүхийн өмнөх шатанд хорьж саатуулах явдлыг ЭБШ ажиллагааны онцгой арга хэмжээ болгож хэрэглэх ёстой³ гэж олон улсын баримт бичигт заасан.

Эрүүгийн байцаан шийтгэх хуулийн 69.4-д зааснаар онц хүнд гэмт хэргийн хувьд 30 сар, хүнд, хүндэвтэр гэмт хэргийн хувьд 24 сараар тогтоосон нь Иргэний болон улс төрийн эрхийн тухай олон улсын пактын шүүхийн өмнөх шатанд аль болох ахар богино хугацаанд хорих тухай шаардлагад огт нийцэхгүй байгаад цаашид дүгнэлт хийх ёстой гэж үзэж байна.

Хуучин хуульд хүндэвтэр гэмт хэрэгт холбогдогсдыг 2 сараас дээш хугацаагаар хорихыг зөвшөөрдөггүй байсан бол /хуулийн 95-р зүйл/ шинэ хуулиар энэ хугацаа 24 сар болж даруй 12 дахин өссөн бөгөөд үүнийг аль ч шалгуураар зөв гэж үзэх боломжгүй юм.

Хуульд насанд хүрээгүй хүмүүсийг 18 сараар /хуулийн 366.4/ хорьж мөрдөн байцаалт явуулахаар заасан нь Хүүхдийн эрхийн тухай конвенци болон бусад олон улсын гэрээнд тогтоосон насанд хүрээгүй хүмүүсийг шүүхээс өмнөх шатанд “аль болох ахар богино хугацаанд” хорих тухай шаардлагад огтхон ч нийцэхгүй урт удаан хугацаа болсон байна.

Өмнөх хуулиасаа хүний эрхийн хувьд дордуулсан өөр нэг асуудал бол хорьж мөрдөх хугацааг сунгах журам. Хуучин хуулиар 2 сараас дээшхи хугацааг сар тутамд тогтоол үйлдэж сунгуулах шаардлагатай байсан бол одоо шинэ хуулиар заавал сар тутамд биш, хэдэн сараар ч нэгтгэн сунгуулах боломжийг /хуулийн 69.5/ мөрдөн байцаагч, прокурорт олгосон нь сэжигтэн, яллагдагчийн эрхийн байдлыг ноцтойгоор хүндрүүлж буй болно.

² “Өнөөдөр” сонин 2003.03.06 № 052

³ Хорихоос өөр төрлийн арга хэмжээнд холбогдох наад захын жишиг дүрэм /6.1/

- Баривчлагдсан сэжигтэн болон цагдан хорихоор таслан сэргийлэх арга хэмжээ авагдсан этгээд нь наад зах нь эрүүдэн шүүхээс ангид байж, хүн гэдэг эрхэм нэрээ доромжлуулах ёсгүй.

Монгол улсын Үндсэн хуулийн 16 дугаар зүйлийн 16.13-д зааснаар “хэнд ч болов эрүү шүүлт тулган, хүнлэг бус хэрцгий, нэр төрийг нь доромжилж болохгүй...” гэсэн заалт, манай улсын 2000 онд нэгдэн орсон “Эрүүдэн шүүх болон бусад хэлбэрээр хэрцгий, хүнлэг бусаар хүний нэр төрийг доромжлон харьцаж шийтгэхийн эсрэг” Конвенцийн заалтыг эрүүгийн байцаан шийтгэх ажиллагааны явцад хангаж ажиллах нь хуулийн байгууллагын албан хаагчдын үүрэг юм. Гэтэл мөрдөн байцаах ажиллагааны практикт эрүүдэн шүүж хилсээр хэрэг хүлээлгэх, улмаар ял шийтгэх ноцтой асуудал гарсаар байна.

Үүнд олон хүчин зүйл нөлөөлж буй боловч юуны өмнө хуулиар олгогдсон эрх мэдлээ хэтрүүлсэн албан тушаалтнуудтай хариуцлага тооцох, хохирогчдын эрхийг хамгаалах явдал туйлын хангалтгүй байгааг дурдаж байна. Түүнчлэн ЭБШХ-нд энэ талаар тодорхой заалтууд, тухайлбал эрүүдэн шүүх журмаар гаргуулсан мэдүүлгийг нотлох баримтанд тооцохыг хориглосон заалтыг оруулж өгөх шаардлагатай байгаа юм.

- Баривчлах урьдчилан хорих байрны нөхцөл, стандарт нь сэжигтэн, яллагдагчийн эрхийг эрүүгийн байцаан шийтгэх ажиллагаанд хангахад маш чухал нөлөөтэй байдаг.

Манай улсад 1999 онд анх удаа сэжигтэн, яллагдагчийг албадан саатуулах, цагдан хорих шийдвэрийг биелүүлэх тухай хуулийг батлан гаргажээ. Энэ хуулиар тогтоосон стандарт нөхцлийг олон улсын баримт бичиг дахь стандартуудтай харьцуулахад мэдээж хангалтгүй байгаа боловч сэжигтэн, яллагдагчийн эрхийг баталгаатай болгох, хорих байрны нөхцлийг сайжруулахад чухал түлхэц болсон нь дамжиггүй. Гэвч уг хууль гарснаас хойш 7 жилийн хугацаа өнгөрч байхад түүний холбогдох заалтуудыг ялангуяа хорих өрөөнд тавигдах стандартыг хэрэгжүүлэхэд анхаарал тавиагүй байна гэж хүний эрхийн байгууллагууд шүүмжилдэг.⁴

Олон улсын баримт бичигт шүүлт хийж үзэхэд хорих өрөөний нөхцөл байдалд тавьдаг ерөнхий шаардлагаас гадна /цонхтой байх, цонх нь салхивчтай байх, байгалийн гэрэл тусах гэх мэт/ тэнд хоригдож буй хүний бие организмд ямар нэг сөрөг нөлөө үзүүлэхгүй байх шалгуурыг их чухалчлах болсон байна. Тухайлбал “Хэрцгий, хүнлэг бус, хүний нэр төрийг доромжлон харьцах, шийтгэх” гэдэг нэр томъёог биеийн болон сэтгэл зүйн хүчирхийллээс гадна хоригдож буй байрны нөхцөл нь хүний харах, сонсох болон орон зайг ба цаг хугацааг баримжаалах төрөлхийн аливаа мэдрэхүйгээс түр буюу бүрмөсөн хагацахаар байх ёсгүй гэсэн өргөн утгаар ойлгоно⁵ гэж тодорхойлсон байдаг.

Гэтэл манайд үйл ажиллагаа явуулж буй хорих байрнууд нь хоригдогсдын амь нас, эрүүл мэндэд шууд хохирол учруулах нөхцөл байдалтай байна.

⁴ Монгол улс дахь хүний эрх, эрх чөлөөний байдлын тухай илтгэл 2004 он, 94-р тал

⁵ Аливаа хэлбэрээр саатуулагдсан болон хоригдсон хүмүүсийг хамгаалах зарчмуудын Цогц. 1988

Сэжигтэн яллагдагчийн эрхийг баталгаатай хангах зарим асуудал

Улсын хэмжээнд 8 аймгийн цагдан хорих байр газрын доор буюу байшингийн подвальд, 3 аймгийн цагдан хорих байр нь хагас подваль байрлалтай, 11 аймгийн байр 1-р давхарт байна. Улсын хэмжээнд байгаа урьдчилан хорих байрууд нь бүгд 431 өрөөтэй бөгөөд тэдгээрийн дөнгөж 41 нь /10%/ цонхтой байдаг.

Нийслэлийн цагдан хорих төв нь голдоо байрлалтай 2 талдаа коридортой баригдсанаас ихэвчлэн өрөөний 3 хана нь битүүмжлэгдсэн нэг үгээр хэлэх юм бол байшин доторхи цонхгүй байшин дотор хүмүүсийг хорьж байгаа⁶ нь агаарын солилцоо явагдах дээр нь хүний харах, сонсох орон цаг зайг баримжаалах төрөлхийн мэдрэхүйгээс нь хүчээр хууль бусаар салгаж байна гэж ойлгож болохоор байна.

- ЭБШХ-ийн 142 дугаар зүйл “Байцаалт явуулах газар, цаг хугацаа”-ны талаар заахдаа: ...байцаалтыг хэрэг бүртгэлт, мөрдөн байцаалт явагдаж байгаа газарт явуулах ба шаардлагатай бол байцаагдаж байгаа этгээдийн байгаа газарт явуулж болно...мөн ЭБШХ-ийн 180 дугаар зүйлд мөрдөн байцаалтыг уг гэмт хэрэг гарсан газарт явуулна.. гэж тус тус заасан байхад сэжигтэн, яллагдагчид авсан таслан сэргийлэх арга хэмжээг мөрдөн байцаалт явуулж байгаа газрын харьяаны цагдан хорих төвд хэрэгжүүлэх ёстой. Гэтэл өнөөдрийн байдлаар сэжигтэн, яллагдагчийг орон нутгаас нь хол аваачиж хорих нь хууль ёсны эрх ашигт сөрөгөөр нөлөөлж сэтгэл зүйн хувьд дарамт учруулж байгаагаараа эрүү шүүлтийн нэг илрэл болно. Цагдан хорихоор таслан сэргийлэх арга хэмжээ авагдаж байгаа этгээдийн талаарх байршлын тухай НҮБ-с батлан гаргасан “Аливаа хэлбэрээр саатуулагдсан болон хоригдсон хүмүүсийг хамгаалах зарчмуудын цогц /1988 он/-д “...Хэрэв саатуулагдсан буюу хоригдсон этгээд хүссэн хийгээд боломжтой бол түүний байнга оршин суудаг газарт нь ойр дөт орших саатуулах буюу хорих газарт байлгана⁷ гэж заасан .

Цаашдаа эрүүгийн байцаан шийтгэх хуулийг өөрчлөх, боловсронгуй болгоход олон улсын гэрээ, конвенцийн тодорхой заалт, жишгийг зайлшгүй харгалзан үзэж, энэ хуулийг энэрэнгүй хүмүүнлэг болгох талаар их зүйл хийх шаардлагатай байгаагаас зөвхөн заримыг цухас дурдахад ийм байна.

⁶ “Монгол улс дахь хүний эрх, эрх чөлөөний тухай илтгэл” 2004

⁷ “Аливаа хэлбэрээр саатуулагдсан болон хоригдсон хүмүүсийг хамгаалах зарчмуудын Цогц” 20-р зарчим 1988 он

ҮНДЭСТНИЙ ЦӨӨНХИЙН ЭРХ (Цаатан иргэдийн жишээн дээр)

*Б.Хишигсайхан,
ХЭҮК-ын Ажлын албаны дарга*

Улс орнуудад арьсны өнгө, хэл, шашин шүтлэг, үндэс угсаа, яс үндэс, бэлгийн чиг баримжаагаараа ялгаран нийгэмдээ дийлэнх болдоггүй бүлэг хүмүүсийг цөөнх хэмээн ерөнхийд нь тодорхойлдог. НҮБ-ын ивээл доор олон улсын хамтын нийгэмлэг цөөнхийг хамгаалах зорилгоор цөөнхийн эрхийн стандартыг томъёолж эхлээд байна.

Аль ч улсын хувьд олонх цөөнхүүд хоорондоо зохицон амьдрах явдлыг чухалчлан үздэг. Ийнхүү зохицон амьдрах үндэс нь хүн бүр эрх, эрх чөлөөгөө аливаа төрлийн ялгаварлал, тэгш бус байдалгүйгээр эдлэх нөхцөлд бүрдэх нь ойлгомжтой. Энэ үзэл санаа нь Хүний эрхийн Түгээмэл Тунхаглалын оршилд “Хүн төрөлхтөний гэр бүлийн бүх гишүүнд угаас заяасан нэр төр болон тэдний тэгш, салшгүй эрхийг хүлээн зөвшөөрөх нь эрх чөлөө, шударга ёс, бүх нийтийн энх тайвны үндэс мөнгийг иш болгон,” хэмээн томъёологдсон байдаг билээ. Тиймээс цөөнхийн тухай асуудлыг онцгойлон авч үзэж байгаа нь ардчиллын нэг чухал хэмжүүр болох нь дамжиггүй. Энэ талаар ардчиллын өлгий нутаг хэмээн үздэг АНУ-ын ерөнхийлөгч Ж. Буш хэлэхдээ: “Ардчиллын замаар яваа аль ч оронд байх ерөнхий зүйл бол: Хууль сахиулах зарчим, **цөөнхийн хамгаалал**, эрх чөлөөт хэвлэл мэдээлэл, үнэлэхүйц улс төрийн сөрөг хүчин байдаг” хэмээн хэлжээ.

Цөөнхийн хувьд олон төрлийн томъёолол байж болох авч энэ дундаас үндэстний цөөнхийн тухай асуудлыг авч үзэж судлах нь хүний эрхийн салбарт чухал ач холбогдолтой юм. Эндээс үндэстний цөөнх гэж хэн бэ, үндэстний цөөнхийн эрхийг олон улсын эрх зүйд болон дотоодын эрх зүйд хэрхэн авч үзэж, хангаж, хамгаалсан, энэ чиглэлээр ямар механизмууд байдаг вэ зэрэг олон асуудал урган гарч ирнэ. Хамгийн түрүүнд “Үндэстний цөөнх гэж хэн бэ?” хэмээх асуултад хариулт өгөх шаардлагатай болов уу. Энэхүү асуултад яв цав, тодорхой хариулт өнөөг хүртэл өгөгдөөгүй хэвээр байна. Үндэстний цөөнхийг тодорхойлоход олон бэрхшээлүүд тулгардаг. Жишээ нь зарим үндэстний цөөнх нь бие даасан автономи эрхтэй байхад зарим нь амьдарлын хэв маяг, хэл, соёлоо хадгалан аж төрсөөр байдаг, түүнчлэн зарим бүлгийнхний хувьд улс орны тодорхой газар нутагт оршин тогтнож байдаг бол зарим цөөнхийн хувьд тархай бутархай амьдарч байх, зарим нь түүх, соёлоо хадгалан, хамгаалж цаасан дээр буулган авч үлдсэн байхад, нөгөө хэсэг нь амнаас ам дамжсан домог хэлбэрээр хадгалж үлдсэн байх, мөн түүнчлэн түүхийн урт хугацааны явцад тухайн улсын хүн амын дийлэнх бүлэгт ууссан зэрэг бэрхшээлүүдийг дурьдаж болно.

Нилээд түгээмэл нэгэн тодорхойлолтыг дурьдвал: **Үндэстний цөөнх гэдэг нь тухайн улсын хүн амын дийлэнхтэй харьцуулахад тооны хувьд цөөнх болох хэл, арьсны өнгө, соёл иргэншлийнхээ хувьд ялгарах, өөрсдийн өвөрмөц байдлыг**

хадгалах хүсэл эрмэлзлэл бүхий тодорхой бүлэг хүмүүсийг хэлнэ¹ гэжээ.

Одоогоор НҮБ болон Европын зөвлөлөөс гаргасан 2 ойлголт давамгайлж байна.

Нэг дэх ойлголт: Цөөнх гэдэг нь тухайн улсын харьяалалтай бөгөөд улс нь тэднийг харьяат бус бүлэг хүмүүсээс ялгаатай авч үздэг. Энэ тодорхойлолтын дагуу төр нь зөвхөн өөрийн харьяат цөөнхийн эрхийг хүндэтгэн авч үздэг.

Хоёр дахь ойлголт: Өөрийн улсад оршин суугаа харьяат бус бүлэг хүмүүсийг цөөнхөд хамруулан авч үздэг. Жишээлбэл: Цагаач ажилчид, дүрвэгсэд, харьяалалгүй хүн г.м тухайн улсад гаднаас шилжин ирж суурьшигсад юм.

Тэгвэл манай улсын хувьд үндэстний цөөнхүүд байдаг уу, байдаг бол ямар бүлгийг үндэстний цөөнхөд тооцдог вэ гэсэн асуулт гарч ирнэ. Монгол улс 1969 онд нэгдэн орсон Арьс үндсээр алагчилах бүх хэлбэрийг устгах тухай Конвенцийн хэрэгжилтийн талаар НҮБ-ын Арьс Үндсээр Алагчилах Үзлийг Устгах Хороонд нийт 11 удаа тайлан тавьсан байх бөгөөд энэ бүх хугацаанд Монгол улсын үндэстний цөөнх бол ганцхан казак үндэстэн хэмээн үзэж иржээ. Дээрх илтгэлүүдэд Монгол улсад 25 хүртэлх үндэстний цөөнх, угсаатны цөөнх амьдарч байгаа хэмээсэн ч зөвхөн казак иргэдийг үндэстний цөөнх хэмээн тодорхойлсон бөгөөд үндэслэл нь өөрийн хэлтэй, бусад цөөнхүүд монгол хэлээр өөрсдийн нутгийн аялгуугаар ярьдаг хэмээн үзсэнтэй холбоотой ажээ. Харин 2004 онд хэвлэгдсэн Монгол Улсын түүх, соёл иргэншлийн атласт Монгол Улсын нутаг дэвсгэр дээр түрэг угсааны казак, тува, хотон, чантуу хэмээх үндэстний цөөнх болох бүлэг хүмүүс оршдог хэмээн үзжээ. Гэсэн хэдий ч одоог хүртэл Монгол улс хичнээн үндэстний цөөнхтэй вэ гэдэг асуулт тодорхой хариултгүй явж ирсэн. Ер нь үндэстний цөөнхийг угсаатны цөөнхөөс ялгавартай авч үзэх шаардлагатай юм. Энэ нь тухайн бүлгүүдэд тусгай зохицуулалт шаардлагатай байдагтай холбоотой. Энэ асуудлыг тодорхой болгох нь төрөөс үндэстний цөөнхийн эрхийг хангах, хамгаалах чиг үүргээ бүрэн төгс хэрэгжүүлж эхлэх анхны алхам билээ. Дээрх тодорхойгүй байдал нь зарим үндэстний цөөнхийн асуудлыг орхигдуулах, эрхийг нь зөрчигдөх байдалд хүргэж байна.

Үндэстний цөөнхийн эрхийн тухай асуудлыг тусгасан олонх гэрээ конвенцийг Монгол улс соёрхон баталсан. Тухайлбал Иргэний болон улс төрийн эрхийн тухай олон улсын Пакт (27), Эдийн засаг, нийгэм, соёлын эрхийн тухай олон улсын Пакт (13), Арьс, үндсээр алагчлах бүх хэлбэрийг устгах тухай Конвенц (2. 4), Хүүхдийн эрхийн тухай Конвенц (30), Боловсролын талаар алагчилахтай тэмцэх тухай Конвенц (5), Төрлөөр устгах гэмт хэргээс урьдчилан сэргийлэх, тийм хэрэг үйлдэгчдийг шийтгэн цээрлүүлэх тухай Конвенц (2) зэргийг дурьдаж болох юм. Монгол улс дээрх гэрээ конвенцийн гишүүн орны хувьд үндэстний цөөнхийн эрхийг хангах, хамгаалах талаар томоохон үүрэг, хариуцлага хүлээж байгаа юм. Түүнчлэн зарим гэрээ, конвенцийн хэрэгжилтийг хянах Хороонд үндэстний цөөнхийн эрхийн хэрэгжилтийн төлөв байдлын талаар тайлагнах үүргийг манай Засгийн газар хүлээсэн байдаг.

Үндэстний цөөнхийн эрхийн асуудлыг дотоодын хууль тогтоомжид ч мөн хуульчлан баталгаажуулсан юм. Монгол улсын Үндсэн хуулинд “Хүнийг үндэс, угсаа, хэл, арьсны өнгө, нас, хүйс, нийгмийн гарал, байдал, хөрөнгө чинээ,

¹ Хүний эрхийн олон улсын нэр томъёоны гарын авлага, Х.Виктор Кондэ, 102 дахь талд

эрхэлсэн ажил, албан тушаал, шашин шүтлэг, үзэл бодол, боловсролоор нь ялгаварлан гадуурхаж үл болно. Хүн бүр эрх зүйн этгээд байна.”² хэмээн заасан. УИХ-аас 2003 онд батлан гаргасан Монгол Улсын Хүний Эрхийг Хангах Үндэсний Хөтөлбөрт үндэстний цөөнхийн эх хэлээрээ сурч боловсрох, ёс заншил, түүх соёлын уламжлалыг өвлөн хөгжүүлэх боломжийг сайжруулах, эх хэлээрээ мэдээлэл авах, түгээх боломжийг хангах талаар тусгайлсан заалтууд байдаг.

Олон улсын гэрээ, конвенциудад үндэстний цөөнхийн эрхийг хангаж, хамгаалах, хөхиүлэн дэмжихэд ялгаварлан гадуурхахгүй байх, тэгш байх зарчмыг мөрдлөг болгохыг чухалчлан заасан байдаг. Ихэнх улс орнууд хууль тогтоомждоо ялгаварлан гадуурхахгүй байх зарчмыг тусгасан байдаг ч хуулийг хэрэгжүүлэх шатанд үндэстний цөөнхүүд ялгаварлагдах байдал элбэг байдаг. Аливаа улс үндэстний цөөнхийн эрхийг хэрхэн хангаж, хамгаалж байгаа нь хууль тогтоох, гүйцэтгэх, шүүх засаглалын хүрээнд үндэстний цөөнхийн эрхийн асуудлыг ямар түвшинд авч үзэж, асуудлыг нь хэрхэн шийдвэрлэж буй байдлаар тодорхойлогддог. Тиймээс үндэстний цөөнхийн эрхийг хангаж, баталгаажуулах нь зөвхөн хууль тогтоомжид зааж өгөх төдийгөөр хязгаарлагдах зүйл биш билээ.

Миний бие Монгол улсад үндэстний цөөнхийн эрхийн хэрэгжилт ямар байгаа талаар нэгдсэн дүгнэлт хийхийг зорьсонгүй. Харин нэгэн үндэстний цөөнхийн эрхийн хэрэгжилт ямар байгаа талаар Хүний эрхийн үндэсний Комиссоос 2003 онд НҮБ-ын Хүний Эрхийн Дээд Комиссарын Газрын санхүүжилтээр хийсэн судалгаанд тулгуурлан зарим асуудлыг гаргаж тавих оролдлого хийсэн болно. Энэхүү үндэстний цөөнхийг “тува”, “урианхай”, “духа”, “цаатан” гэх мэтээр төрөл бүрээр нэрлэн дууддаг боловч, энд “цаатан” хэмээх нийтэд түгсэн нэрийг нь авсан болно.

Цаатан иргэд үндэстний цөөнх мөн эсэх талаар зарим хүмүүсийн хувьд эргэлзэх байдал байдаг. Цаатан иргэд нь тува хэлээр ярьдаг, бөө мөргөлтэй, нүүдлийн соёл иргэншилтэй боловч монголчуудаас ялгаатай нь урцан гэрт амьдардаг, цаа буга малладаг зэрэг олон ялгаатай зүйл байгаа бөгөөд түүнчлэн тооны хувьд өнөөдөр Монгол улсын нийт хүн амын 0.02 хүрэхгүй хувийг эзэлж байна. Дээрх шинжүүдийг харгалзан үзэж цаатан иргэд бол үндэстний цөөнх мөн хэмээн авч үзэж буй болно.

Өнөөдөр цаатан иргэдийн тухай олон нийтийн мэдлэг хангалттай биш, мэдлэгтэй гэж үзэж байгаа хэсгийн хувьд тэднийг үл тоох хандлага илүүтэй давамгайлах болсон байна. Хүний эрхийг хангах үндэсний хөтөлбөр боловсруулах төслийн хүрээнд 2001 онд хийгдсэн Хүний эрхийн төлөв байдлын судалгаа³, Хүний эрх ба Хөгжил төвийн 2001 оны хүний эрхийн байдал тэмдэглэлд цаатан иргэдийн эрхийн талаар хураангуй мэдээ оруулсныг эс тооцвол сүүлийн жилүүдэд цаатан иргэдийн талаар анхаарч судалсан судалгааны ажил байхгүй байна. Харин Хүний Эрхийн Үндэсний Комиссоос 2003 онд томоохон хэмжээний судалгаа хийсэн. Цаатан иргэдийн үндэстний цөөнхийн эрхийн хэрэгжилтийн тухай ярихаас өмнө цаатан иргэд, тэдний өнөөгийн амьдарлын хэв шинж, дүр зургийн талаар товч мэдээлэл өгөх нь зүйтэй буйзаа.

² Монгол улсын Үндсэн хууль, 1992 он, 2-р бүлэг, 14-р зүйл

³ Монгол улс дахь хүний эрхийн төлөв байдал, 2001 он, 128 дахь талд

Цаатан гэж хэн бэ?

Манай улсын умар зүгийн ой тайгад цаа буга маллаж амьдардаг хэсэг хүмүүсийг, ардын хувьсгалаас хойш манай утга зохиол, ярианы хэлэнд “Цаатан” гэж нэрлэх болжээ. Хувьсгалаас өмнө нийтэд нь “Тагна урианхай” гэж нэрлэдэг байсан боловч тайгын иргэд, “Соёд урианхай” гэж ялгах явдал ч байжээ.⁴ Ийнхүү цаатан хэмээн нэрийдсэн нь тэдгээр бүлэг хүмүүсийг онцолж, ахуйн шинжээр нь тодотгосон байна. “Цаатан” гэдэг үг нь цаа бугатай хүн гэсэн утгыг илэрхийлнэ.

Хөвсгөл аймгийн Цагаан нуур сумын хоёрдугаар багийг бүрдүүлж байгаа цаа маллан тайгад амьдардаг уйгар угсааны тува (Духа) хүмүүс нь Монгол Улсын үндэстний хамгийн цөөнх болно. Эдгээр хүмүүс нь ОХУ-ын Тувагийн нутаг хуучин Тожийн хүшуу, Тоду, Соён Кыргыз, Ханачи, Маат, Балыкчи, Хуулар овгийн Тува яс угшлын хүмүүс юм. Монголд ойн иргэд цаа буга өсгөн маллаж, хонь малладаг малчидтай зөрчилдөж байдаг тухай Ираны түүхчид 1310 оны үед бичсэн байдаг.

Цаатан иргэд нь Улаанбаатар хотоос 1000 гаруй, Хөвсгөл аймгийн төвөөс 300 гаруй, Цагааннуур сумын төвөөс 50-70 км алслагдсан, өндөр ууланд амьдардаг. Тэдний амьдардаг газар нь дэлхийн бөмбөрцгийн хойт өргөргийн 52°-60°, уртрагийн 98°-102° хоорондох зайд орших Монгол улсын нутаг дэвсгэрийн хөвдөн бэлчээртэй, ян сарьдаг уулууд юм. Энд өвлийн улиралд цельсийн хасах 29-53 хэм хүртэл хүйтэрч, зуны улиралд цельсийн нэмэх 12-23 хэм хүртэл дулаарна. Жилийн дундаж хур тунадас нь 320 мм хүрдэг. Уул нуруунууд нь далайн түвшнээс 2500-3500 метр өндөрт өргөгддөг, эрс тэс уур амьсгалтай.

2002 онд хийсэн судалгаагаар Цагааннуур сумын 2 багт нийт 114 өрхийн 493 цаатан хүмүүс амьдарч байгаа бөгөөд хүйсийн хувьд 240 эрэгтэй, 255 эмэгтэй байна гэсэн дүн гарчээ. Тэдгээрийн 39.9%-ийг 0-16 насны хүүхдүүд, 19.8%-ийг 17-25 насны залуучууд, 20.2%-ийг 26-35 насны хүмүүс, 15.2%-ийг 36-60 насны хүмүүс, 4.6%-ийг 60-аас дээш насны ахмадууд эзэлж байна. 2002 оны байдлаар баруун зүүн тайгад амьдарч байгаа нийт 42 өрх айлд 563 цаа тоологдсон бөгөөд нэг хүнд дунджаар 2.7 цаа оногддог.

Өнөөдөр баруун, зүүн хоёр тайгад амьдарч байгаа цаатан иргэдийн дунд хуучин уламжлал, зан заншил, соёлоо нарийн мэдэх хүн бараг үлдсэнгүй. Шашин, зан заншлынх нь уламжлал, өвөрмөц хэв хэвшил ч дархадын⁵ соёлоос ялгарахаа больжээ. Манай хүн амын цөөнх болсон цаатан хүмүүсийн хэл, соёл, зан заншил, шашныг хуучин хэвээр нь хадгалан үлдээх бодит боломж нөхцөл ихээхэн хязгаарлагдмал байгаа бөгөөд даяарчлалын өнөө үед энэ нь улам ч хумигдаж байгаа билээ.

Дээр дурьдсанчлан үндэстний цөөнхийн эрхийг хангах, хамгаалах явцад ялгаварлан гадуурхахгүй байх, тэгш байх зарчмыг хэрхэн баримталж байгаад дүгнэлт хийх цаг нэгэнт болжээ. Олон улсын гэрээ конвенцид цөөнхийн эрхийг хангах зорилгоор тусгай хөтөлбөр, бодлогыг авч хэрэгжүүлэх нь ялгаварлан гадуурхалт биш хэмээн үзсэн байдаг. Гэвч социализмын үед авч хэрэгжүүлж байсан зарим бодлогыг эс тооцвол цаатан иргэдийн эрхийг хангах чиглэлээр төрөөс хэрэгжүүлж байгаа тодорхой бодлого байхгүй өнөөдрийг хүрсэн. Цаатан иргэдийн хувьд эрүүл мэндээ хамгаалуулах, сурч боловсрох, хөдөлмөрлөх, нийгмийн

⁴ С.Бадамхатан, Хөвсгөлийн цаатан угсаатан, 1960 он, 3 дахь талд

⁵ Монгол үндэстэн нь ястангуудаас бүрддэг бөгөөд дархад нь ястнууд юм.

хангамж хүртэх, сонгох, сонгогдох, мэдээлэл хүлээн авах зэрэг эрхийн хэрэгжилт хангалтгүй түвшинд байна.

Тэгш байх, ялгаварлан гадуурхахгүй байх зарчмууд бол тунхаглал биш. Энэ нь хүн амын ялгаатай байдлыг хүлээн зөвшөөрч, түүнд тохирсон бодлогыг төрөөс авч хэрэгжүүлнэ гэсэн үг. Тэгвэл цаатан иргэдийн хувьд эдгээр зарчмууд хэрхэн үйлчилж байна вэ? Нэгэн жишээ дурьдахад 1998 оны амьжиргааны түвшин тогтоох судалгаагаар манай улсын хүн амын 38.5 хувь нь ядуу⁶, нэн ядуу нөхцөлд амьдарч байгаа дүн гарсан бол цаатан иргэдийн 70 орчим хувь нь ийм нөхцөлд амьдарч байна. Цаатан иргэдийн амьжиргааны түвшинг Монгол улсын хүн амтай харьцуулахад ядуурлын түвшин даруй 2 дахин их байна. Тэгвэл төрөөс ядуурлыг бууруулах чиглэлээр авч хэрэгжүүлж байгаа бодлого, хөтөлбөрийн үр шимийг цаатан иргэд хүртэх тэгш боломжтой байгаа эсэх тухай асуудлыг эргэж харах шаардлагатай юм. Гэвч ядуурлыг бууруулах чиглэлээр хэрэгжүүлж буй хөтөлбөр, төслүүдэд цаатан иргэдийг хэрхэн ядуурлаас гаргах тухай тусгай зохицуулалт байдаггүй. Ядуурлаас гарах боломж тэгш бус байгаад дүгнэлт хийж үзвэл цаатан иргэд үл хайхрагдах байдалд байгаа буюу ялгаварлагдаж байна гэж үзэх боломжтой юм. Эндээс хүний эрхийн талаар илтгэл тайлан бичих болохоороо үндэстний цөөнхөө ялгаварладаггүй, тэгш ханддаг гэж бичээд сууж болох уу гэсэн асуулт урган гарч ирж байна. Ер нь ялгаварлан гадуурхахгүй байх гэдэг бол ялгаварлан гадуурхахгүй гэж хуульчлаад шийдэх асуудал биш бөгөөд ялгаатай байдлыг арилгах чиглэлээр юу хийж байна вэ гэдэг зүйлээр хэмжигдэх ёстой. Тиймээс цаатан иргэдэд чиглэсэн тусгай хөтөлбөр шаардлагатай байна.

Үндэстний цөөнхийн эрхийн хэрэгжилт

Цаатан иргэдийн үндэстний цөөнхийн эрхийн хэрэгжилтийн талаар Комиссын хийсэн судалгаанд тулгуурлан товч дүгнэлт хийе. Эндээс үндэстний цөөнхийн эрх гэж юу вэ? яагаад тусгайлсан эрхийн тухай асуудлыг хөндөж тавих болов гэсэн асуултууд урган гарч ирж байна. Олон улсын хүний эрхийн гэрээ, хэлэлцээрт оролцогч улсын зүгээс үндэстний цөөнхдөө эдлүүлбэл зохих эрхүүдийг тусгайлан заасан байдаг. Энэ нь тэдэнд давуу эрх олгож байгаа явдал биш бөгөөд энэхүү эрхээ эдлэх замаар үндэстний цөөнхийн онцлогоо хадгалан үлдэх, нийгмийн амьдралд тэгш оролцох боломжийг тэдэнд олгож байгаа явдал юм. Энэ эрхүүдэд:

- Төрөлх хэлээрээ ярих, суралцах, харилцах
- Өөрийн шашнаа шүтэх
- Өөрийн зан заншлаа хадгалан үлдэх, соёл иргэншлээ түгээн дэлгэрүүлэх зэрэг болно.

Цаатан иргэдийн төрөлх хэлээрээ ярих, суралцах, харилцах эрхийн хэрэгжилт

Монгол улсын Үндсэн хуулийн 9 дүгээр зүйлийн 2-д: "... хүн амын өөр хэл бүхий үндэстний цөөнх эх хэлээрээ суралцах, харилцах, соёл, урлаг, шинжлэх ухааны үйл ажиллагаа явуулах эрхийг үл хөндөнө." хэмээн заасан. ИУТЭОУП-ын

⁶ "Хүн амын амьжиргааны түвшин тогтоох судалгаа" Үндэстний статистикийн газар. 2004 он.

27-р зүйлд: “Угсаатан, шашны ба хэлний цөөнх оршдог орнуудад эдгээр цөөнхөд багтдаг хүмүүст тухайн цөөнхийн бусад гишүүний хамтаар өөрийн ...эх хэлээрээ ярих эрхийг хорьж болохгүй.” хэмээн заасан. Мөн түүнчлэн Хүүхдийн эрхийн тухай Конвенцийн 30-р зүйл, Боловсролын талаар алагчилахтай тэмцэх тухай Конвенц (5)-иудад төрөлх хэлээрээ ярих, суралцах боломжтой байх тухай заасан байдаг. Мөн 2003 онд УИХ-аас батлагдсан Монгол улсад Хүний эрхийг хангах үндэстний хөтөлбөрийн 2.4.3.5-д үндэстний цөөнхийг эх хэлээрээ суралцах боломжийг хангах тухай заасан.

Цаатан иргэдийн төрөлх хэл нь тува хэл юм. Социализмын үед тува хэлний багшийг тусгайлан бэлтгэж, Цагааннуур сумын дунд сургуульд тува хэлийг зааж байжээ. 1990 оноос хойш цаатан хүүхдүүдэд үндэстнийх нь хэл бичиг заах цөөн ч гэсэн мэргэжлийн багш байгаа ч орон нутгийнхны хайхрамжгүй байдал, сургуулийн захиргааны хөөцөлдлөг дутагдсанаас болоод хичээлийн хөтөлбөрөөс хасагдсан байна.

Цаатан иргэд өнөөгийн байдлаар тува хэлээ зөвхөн хоорондын харилцааны түвшинд л эзэмшсэн, ялангуяа хүүхдүүд тува хэлээр энгийн хэдэн үгээс цааш мэдэхгүй байгаа нь цаашид өөрийн төрөлх хэлээ бүр мөсөн мартахад хүргэж байна. Энэ нь цаатан иргэдийн төрөлх хэлээрээ ярих, суралцах, харилцах гэсэн эрхийг ноцтойгоор зөрчиж байгаа явдал юм.

Өөрийн шашныг шүтэх эрхийн хэрэгжилт

Үндэстний цөөнх өөрийн шашныг шүтэх эрхтэй хэмээн ИУТЭОУП-ын 27-р зүйл, Арьс, үндсээр алагчлах бүх хэлбэрийг устгах тухай Конвенц (5), Хүүхдийн эрхийн тухай Конвенц (30), Боловсролын талаар алагчилахтай тэмцэх тухай Конвенц (5), Монгол улсын Үндсэн хуулийн 9-р зүйл, Монгол Улсын Хүний Эрхийг Хангах Үндэстний Хөтөлбөрийн 2.1.7 зэрэгт баталгаажуулж өгсөн байдаг.

Цаатан иргэд нь бөө мөргөлийг эрт цагаас шүтэж ирсэн. Социализмын үед бөө буух, удган зайран тодруулах нь хязгаарлагдмал байсан хэдий ч тэд шашин соёлоо хадгалсаар ирсэн юм. “Цаатан бөө нь дархад бөөгийн мөргөлтэй агуулга хэлбэрээрээ бараг адил. Гэхдээ эртний шинж, агуулга ёс дэглэмийг нэлээд хадгалсан, буддын шашны нөлөөнд ороогүй өвөрмөц шинжтэй байна”⁷ гэж С.Бадамхатан тэмдэглэжээ. Гэвч цаатан бөө мөргөлийн талаар дорвитой судалгааны ажил хийгдээгүй хэмээн баруун тайгад амьдардаг Сууяан удган ярьж байлаа.

Өнөөдөр баруун, зүүн тайгад Сууяан удган, Госта зайран, Цэнд удган зэрэг хэдэн хүмүүс байдаг. Цаатан өрх бүр урц гэрийн хойморт эцэг дээдсийн нь сүнс сүлд шингэсэн онгод шүтээнээ залж, өөрийн шашнаа шүтэж байна. Нэг овог удмын цаатангууд өөр өөрийн тахиж шүтдэг онгон газартай байдаг бөгөөд жилд 1-2 удаа очиж тахиж шүтэх ёс байдаг ажээ. Зарим онгон шүтээн газар нь өөр сумын нутагт хил орчим байх тохиолдол байдаг бөгөөд энэ тохиолдолд хилийн зөвшөөрөл авах гэж тус сум орох, ...зөвшөөрөл өгөх хүмүүс нь тэр бүр байхгүй байх...зөвшөөрөлгүй очоод тахиж шүтэх гэхээр хил зөрчигч хэмээн сэрдэгдэх гэх мэт бага зэрэг бэрхшээл учирдаг тухайгаа ярьж байсан...” Өөр бусдаар бол өнөөдөр цаатан иргэдэд итгэл үнэмшилтэй байх, өөрийн шашныг шүтэх эрх нь зөрчигдөх, үүнээсээ үүдэж ялгаварлагдах явдал гардаггүй хэмээн дүгнэж болохоор байна.

Өөрийн зан заншлыг хадгалан үлдэх, соёл иргэншлээ түгээн дэлгэрүүлэх эрхийн хэрэгжилт

Үндэстний цөөнхийн зан заншлаа хадгалан үлдэх, соёл иргэншлээ түгээн дэлгэрүүлэх эрхийн тухай асуудлыг Иргэний болон улс төрийн эрхийн тухай олон улсын Пакт (27), Эдийн засаг, нийгэм, соёлын эрхийн тухай олон улсын Пакт (13), Арьс, үндсээр алагчлах бүх хэлбэрийг устгах тухай Конвенц (5), Хүүхдийн эрхийн тухай Конвенц (30), Боловсролын талаар алагчилахтай тэмцэх тухай Конвенц (5), Монгол Улсын Үндсэн хууль (7, 8,16.8), Хүний Эрхийг Хангах Үндэсний Хөтөлбөр (2.4.3.5) зэрэгт баталгаажуулж өгсөн байдаг.

Тэд өөрийн өвөрмөц зан заншил, соёлын арвин баялаг туршлагатай ард түмэн билээ. Цаатан ардуудын бусдаас онцгойрон харагддаг зан заншилийн гол зүйлс гэвэл:

- гэр бүл болох (хуримлах, бэр буулгах)
- нас барагсдаа оршуулах (хүүхэд оршуулах)
- цаа сэтэрлэх
- ан авд мордох (онцолбол баавгай агнах)
- урц гэрээ барих
- нүүж суух зэрэг төрөхөөс эхлээд жам ёсоор хорвоог орхих үе хүртэл

амьдралын хугацаанд давтах үйлүүд болно. Цаатан ардуудын амьдралын хэв хэвшил дотор эртний овгийн байгууллын үеийн улбаа өнөө хэр хадгалагдсаар ирснийг тэдний зан үйлийг судалдаг гадаад дотоодын эрдэмтэд ажиглан судалсан байна. Тухайлбал, 2002 онд зүүн тайгын 10 өрхөд хийсэн судалгаагаар тэд хүнсээ /махаа/ ав адилхан хуваан авч, яг нэг өдөр хүнсээ дуусгаж байгаа жишээ болно. Мөн нас барагсдаа оршуулах зан үйлэнд ч их эртний хэв шинж хадгалагдаж байгаа юм. Цаатан ардуудын эд өлөг, хувцас хэрэглэл, гоёл чимэглэл, эдийн соёлын бүхий л өв уламжлал нь өнөөдөр бараг бүрэн устан үгүй болж байна. Тэд орчин үеийн шаардлагаар арьсан ауе гутал, богцноосоо аажим салж байгаа шигээ хэл, соёл, зан заншлаа мөн бөхөөн орхиж байна.

Цаатан ардууд нь нүүдлийн соёл иргэншилтэй бөгөөд монгол гэрт биш урцанд амьдардаг. Тайгад цаагаа даган жилд 5-6 удаа нүүдэллэн амьдардаг цаатнуудад илүү тохиромжтой сууц бол яах аргагүй урц юм. Урцыг 3-4 метрийн урттай, том урц бол 28-32, жижиг урц бол 17-23 мод босгож, брезентээр бүрдэг. Өмнө нь ангийн болон цаа бугын арьс, модны холтосоор урцаа бүрдэг байсан бол 1970-аад оноос судалгаа явуулж байж, бүх урцыг брезентээр бүрэх болсон бөгөөд ийнхүү брезентээр бүрэх болсноор урцны хэмжээ томорч, илүү тохилог болжээ.

Цаатан иргэдийн зан заншил, соёл нь цаа бугатай салшгүй холбоотой. Сүүлийн жилүүдэд цаа буга эрс хорогдсон нь тайгад амьдарч байгаа цаатан иргэдэд хүндээр тусч байна. Социализмын үеийн цаатангуудыг төвлөрүүлж суурьшуулах гэсэн оролдлого нь цаатангуудын амьдралын хэв маяг, уламжлалтай зөрчилдөж, улмаар тайгыг эзгүйрүүлэхэд хүргэж байсан бол өнөө-дөр тэдэнд чиглэсэн ямар ч бодлого, зорилтгүй явж ирсэн нь энэ өвөрмөц амьдралын хэв шинжийг аяндаа мөхөж алга болох аюулд хүргэж байна. Тайгад амьдарч байгаа цаатан иргэд өлөн зөлмүүн байдалд, дутагдаж гачигдах нөхцөлд байгаа хэдий ч тэд өөрсдийн зан заншлаа хадгалан үлдэх хүсэл эрмэлзлэл дүүрэн амьдарч байгаа юм.

Цаатан иргэдийн зан заншил, соёл, уламжлалын холбогдолтой эрдэм шинжилгээ, судалгааны бүтээлүүд тун ховор байна. Эрдэмтэн С.Бадамхатаны 1960 онд бичсэн “Хөвсгөлийн цаатан угсаатан” хэмээх товхимол нь цаатан иргэдийн зан заншил, соёл, шашин шүтлэг зэргийг нилээд судалж бичсэн боловч үүнээс хойш судалгаа эрдэм, шинжилгээний бүтээл гарсангүй. Түүнчлэн цаатан иргэдийн хувьд зан заншил, соёлын өв уламжлалаа аман яриагаар өвлүүлж байгаа болохоос, бичмэл түүх байхгүй өнөөг хүрч ирсэн. Социализмын үед орон нутгийг судлах музей байгуулсан байсан нь цаатан ардуудын соёл, зан заншлыг олон нийтэд түгээн дэлгэрүүлэх, ирээдүй хойч үедээ энэ өвөрмөц амьдрал, зан заншлыг өвлүүлэн үлдээхэд чухал арга хэмжээ болсон хэдий ч одоо энэ музей хаагджээ. Энэ асуудалд орон нутгийн захиргааны зүгээс анхаарал тавьж, музейг сэргээх, үзмэрүүдийн хадгалалт, хамгаалалтыг сайжруулах талаар ажил зохион байгуулах нь цаатан иргэдийн соёл, зан заншлыг түгээн дэлгэрүүлэхэд оруулах үнэтэй хувь нэмэр болох нь дамжиггүй.

Энэ бүгдээс дүгнэж үзвэл цаатан иргэд өөрийн зан заншлаа хадгалан үлдэх, хойч үедээ уламжлуулах, нийгмийн амьдралд тэгш оролцох, хөгжил дэвшлийн үр шимээс хүртэх боломж ихээхэн хязгаарлагдмал байгаа нь харагдаж байна. Тиймээс цаатан иргэдийн зан заншил, уламжлал, соёлыг хадгалан үлдээх, хойч үед өвлүүлэх асуудалд төрөөс онцгой анхаарал тавих шаардлагатай юм.

ДҮГНЭЛТ

Цаатан иргэдийн амьдрал өнөөдөр хүнд байна. Тодорхой бодлого хөтөлбөр гаргаж хэрэгжүүлэхгүй, одоогийнх шиг байх аваас үндэстний цөөнхийн гол шинжээ алдаж, тайгад олон зуун жилийг туулсан нэн эртний нэгэн амьдралын өвөрмөц хэв шинж мөхөхөд хүрч байгаа нь үнэхээр эмгэнэлт явдал юм. Цаатангуудын хувьд өөрсдийн бичмэл түүх байхгүй, уламжлалт зан заншил нь баларчгүй болсон, хүүхэд залуучууд нь өөрийн төрөлх хэлээ муу мэддэг, эсхүл мэдэхгүй болж, ахуй амьдралын хувьд ядууралд автсан зэрэг нь үүний гол шалтгаан болно.

Үндэстний цөөнх болохын хувьд тэдний өөрсдийн соёл, амьдралын өвөрмөц хэв шинжээ хадгалан үлдэх гэсэн хүсэл эрмэлзлэлийг нь хөхүүлэн дэмжиж, энэ чиглэлээр тусламж, дэмжлэг үзүүлэх хөтөлбөр боловсруулж хэрэгжүүлэх шаардлагатай байна. Цагааннуур сум бол үндэстний цөөнх амьдарч байгаа онцлогтой сум гэдгийг Засгийн газар, Хөвсгөл аймгийн хурал, захиргааны байгууллага харгалзан үзэж, тэгш байх зарчмын үүднээс хөтөлбөр, бодлогыг боловсруулж, хэрэгжүүлэх цаг нэгэнт иржээ. Мөн түүнчлэн Цагааннуур сумын 8 жилийн сургуульд тува хэлийг заахгүй байгаа нь тэдний төрөлх хэлээ сурах эрхийг нь ноцтойгоор зөрчиж байгаа тул сургалтын хөтөлбөрт нь оруулж, цаатан хүүхдүүдэд эх хэлийг нь зааж эхлэх хэрэгтэй байна.

Цаатан иргэдийн амьдралын өвөрмөц хэв маягийн гол баталгаа болж байгаа цаа бугыг эрүүлжүүлэх, тоо толгойг өсгөх, үржил селекцийн ажлыг зохион байгуулахад төр, орон нутгийн байгууллагуудаас зориуд анхаарч, яаралтай арга хэмжээ авах цаг болсон. Түүнчлэн ядуурлыг бууруулах хөтөлбөр, төсөлд цаатан иргэдийг хамруулах боломжийг судалж, тэдэнд орлогоо нэмэгдүүлэх, амьжиргаагаа тогтвортойгоор дээшлүүлэх боломжийг олгох талаар анхаарах шаардлагатай байна.

ШҮҮН ТАСЛАХ АЖИЛЛАГААН ДАХЬ МЭТГЭЛЦЭХ ЗАРЧИМ БА ХҮНИЙ ЭРХ, ЭРХ ЧӨЛӨӨ

Ж.Бямбаа,

Хууль зүйн ухааны доктор, профессор

Шинэ Үндсэн хуулийн үзэл баримтлалын дагуу 1994 онд ЭБШ хуульд орсон томоохон агаад зарчмын шинжтэй өөрчлөлтөөр мэтгэлцэх зарчмыг анхан шатны шүүн таслах төдийгүй давж заалдах ажиллагаанд мөн адил тулгуурлахаар зохицуулалт хийсэн билээ. Мэтгэлцэх зарчмын мөн чанарыг тодорхойлох шинж нь ЭБШ ажиллагааны гурван үндсэн чиг үүргийг тус тусад нь өөр өөр субъектүүд хэрэгжүүлэх явдал юм. Өөрөөр хэлбэл /инквизицийн процесс шиг/ эрүүгийн мөрдөн мөшгилт явуулсан субъект шүүн таслах үйл ажиллагааг үргэлжлүүлэн хэрэгжүүлэх боломжгүй байдгаараа хүний эрхийг ханган хамгаалах нэгэн чухал хэлбэр болдог.

ЭБШ ажиллагааны бүхий л үе шатанд мэтгэлцэх зарчим үйлчилнэ гэж үзэх нь эрдэмтэн судлаачдын дунд нэлээд маргаантай хэвээр байна. Оросын эрдэмтэн Лукашевич В.В, Чичканов А.Б нар мэтгэлцэх зарчим нь зөвхөн анхан шатны шүүн таслах ажиллагааны үед бүрэн утгаараа үйлчилдэг. Бусад шатуудад тухайлбал, хэрэг бүртгэлт, мөрдөн байцаалтын шатанд зөвхөн түүний элементүүд л ирэлээ олдог хэмээн үзэж байна¹.

Энэхүү саналыг манай эрдэмтдийн ихэнх нь хүлээн зөвшөөрдөг². Учир нь мэтгэлцэгч талуудын энэ чацуу эрхтэй байх зарчим нь Монгол улсын Үндсэн хуулийн 14 дүгээр зүйлд заасан утгаар буюу аливаа этгээдүүд хуулийн төдийгүй шүүхийн өмнө эрх тэгш байна гэсэн заалтыг удирдлага болгоно. Шүүхийн өмнө эрх тэгш байна гэдэг нь эрх зүйн этгээдүүд, талууд болон шудрага, хөндлөнгийн, хараат бус шүүхийн өмнө хуульчлан бүрдүүлсэн нөхцөл боломжид тулгуурлан өөрийн эрх, ашиг сонирхолоо хамгаалах явдал юм.

Аливаа маргааныг шударга алагчлалгүй шийдвэрлэж талуудыг өөрийн эрх ашгаа шүүхийн өмнө хамгаалах бүхий л боломжоор хангах үүргийг шүүх л хүлээнэ.

Талуудын чиг үүргээс шүүх өөртөө өчүүхэн ч ногдуулж үл болно. Түүнчлэн өөрт нь хамаарахгүй чиг үүргийг талуудад хүлээлгэх бас боломжгүй. Мэтгэлцэх зарчмын хэрэгжилтийг хэт бүдүүвчлэн ойлгож туйлширсан хоёр тал мэтээр хязгаарлан ЭБШ ажиллагааны үндсэн зорилтоос гажих үндэсгүй нь ойлгомжтой. Тухайлбал, шүүгдэгч, яллагдагч өөрийн гэм буруутай болохоо хүлээн зөвшөөрч, нотлох баримтаа зааж өгөх, хохирогч нь шүүгдэгчид оноох ял зэмийг хөнгөлөх нөхцөл байдлыг тодруулахыг мэтгэлцэх зарчимд харш гэж үзэх үндэслэлгүй юм. Учир нь ЭБШ ажиллагааны гол зорилт, эцсийн үр дүн нь шударга ёсонд нийцэж

¹ Принцип состязательности и равноправия сторон в новом УПК Р.Ф. Правоведение. 2002 ² стр 192-195

² “ЭБШ ажиллагаанд мэтгэлцэх зарчим үйлчлэх нь” ОУ-ын Эрдэм шинжилгээний хурал дээр тавьсан илтгэлүүдээс үзнэ үү. 2004 оны 12 сар эмхтгэл материал

Шүүн таслах ажиллагаан дахь мэтгэлцэх зарчим ба хүний эрх, эрх чөлөө

байх ёстойгоос гадна, үйл явдлын хэлбэр болон агуулгыг нь ямагт тодорхойлодоггүйтэй уялдаатай.

Шударга ёсны шаардлага нь эрх зүйн агуулгын гол бүрэлдэхүүн хэсэг, хуулийг хэрэгжүүлж хэрэглэх үйл ажиллагааны үндсэн зарчмын нэг болдог билээ. Үнэн мөнхийг бүхнээс эрхэмлэн нийгмийн гишүүд, хүмүүсийн янз бүрийн бүлэг давхрага хуулийн өмнө тэгш эрх, үүрэгтэй байх, хэн нэгэн этгээд нийгэм, хүн ардад хор хохиролтой ямар нэг буруу зүйл хийвэл зохих шийтгэл зэмлэл заавал авах ёстой гэсэн зарчмуудыг эрдэмтэд шударга ёсны агуулга, шаардлагын гол чиглэл болгон авч үзсэн байдаг³.

Хэдийгээр шүүхийн /шийтгэх, цагаатгах/ тогтоолыг гаргахад тавигдах шаардлагаас шударга ёсны шалгуурыг ЭБШ шинэ хууль “орхигдуулсан” ч хэргийн байдлыг бодитой, бүрнээр тогтооно гэдэг нь шударга ёсыг эрхэмлэж байна гэсэн ойлголт гэдгийг тууштай баримталжээ.

Зарим эрдэмтэд шударга ёсны тухай ойлголт олон талтай өргөн ухагдахуун учраас зөвхөн хуулийн шинжлэх ухааны төдийгүй эдийн засаг, ёс суртахуун, гоо зүй, гүн ухааны судалгааны ухагдахуун мөн, тиймээс ч улс төрийн бодлоготой амин уялдаатай болсон дан ганц эрх зүйн ойлголт мэтээр үзэж болохгүй гэж тэмдэглэсэн байдаг⁴.

ЭБШ хуулийн 16 дугаар зүйлийн 16.1-д хэрэг бүртгэгч, мөрдөн байцаагч, прокурор, шүүх нь /ЭБШ ажиллагааг эрхлэн явуулагчид/ хэргийн байдлыг тал бүрээс нь бүрэн бодитой нотлохын тулд хуульд заасан бүх арга хэмжээг авч сэжигтэн, яллагдагч, шүүгдэгчийн яллах, цагаатгах, эрүүгийн хариуцлагыг хүндрүүлэх ба хөнгөрүүлэх нөхцөл байдлыг бүрэн тогтоох үүрэгтэй болохыг тодорхой зааж өгсөн юм.

Тиймээс ч прокурор эрүүгийн мөрдөн мөшгих ажиллагааг эрхлэн явуулахдаа үндэслэлгүй, аль эсхүл эргэлзээтэй нь тогтоогдох юм бол шүүхийн өмнөх үе шатанд хэргийг хэрэгсэхгүй болгохоос гадна шүүхэд шилжсэн хойно ч яллахаас татгалзах эрхтэй төдийгүй үүрэг хүлээх учиртайг хуулийн холбогдох заалтуудаас төвөггүй ойлгож болно. Энэ нь мэтгэлцэх зарчмыг хэрэгжүүлэхээс татгалзаж буй хэлбэр биш бодит үнэнийг тогтоох зарчмыг чанд баримталж байгаагийн илрэл мөн.

Мэтгэлцэх зарчмыг хангах гол үндэслэл нь процессын баталгаа байх ёстой. Тэр нь ЭБШ хуульд заан тодорхойлсон зүйл заалтуудыг Монгол Улсын шинэ Үндсэн хуулийн үзэл баримтлалыг удирдлага болгон чанд ханган биелүүлэх явдал юм. Талууд эрхээ хэрэгжүүлж үүргээ биелүүлэх боломжийг бүрдүүлэхэд шүүх тус дэм үзүүлэх учиртай. Тиймээс ч талуудын хүсэлтээр хэргийн бодит үнэнийг тогтоох ач холбогдол бүхий нэмэлт нотлох баримтыг шүүхийн өмнө гаргаж тавихад ямагт анхаарах нь чухал бөгөөд энэ нь ЭБШ ажиллагааны оролцогчдын эрх, үүргийн баталгааны нэг гол илрэл мөн.

Шүүхэд мэтгэлцэх зарчим хэрэгжих үндсэн нөхцлүүдийг ЭБШ ажиллагааны бусад зарчмуудаас ажиглаж болно. Үүнд: шүүх эрх мэдлийг гагцхүү шүүх хэрэгжүүлдэх зарчмыг юуны өмнө нэрлэх хэрэгтэй. Шүүх эрх мэдлийг хуулиар

³ Белявский А.С. “Право и совесть” М., 1989 г. стр 29., Мальцев Г.В. “Социальная справедливость и право” М., 1977 г. стр-126

⁴ Заславская Т.А “Человеческий фактор развития экономики и социальная справедливость” Экономика 1996 г. №13., стр 29

тогтоосон журмаар томилогдсон шүүгч нараар дамжуулан гагцхүү шүүх хэрэгжүүлнэ. Шүүх эрх мэдэл гэдэг нь хэрэг шийдвэрлэх ажиллагааны тогтоосон журмын дагуу тодорхой хэрэг, маргааныг хянан хэлэлцэж хууль ёсны бөгөөд үндэслэл бүхий шийдвэр гаргахад чиглэсэн шүүхийн үйл ажиллагаа⁵.

Шүүгч хараат бус байж гагцхүү хуульд захирагдах зарчим. Шүүгч хараат бус байх асуудал нь гагцхүү хуульд захирагдах агуулгыг өөртөө багтаасан байдаг. “Шүүх нь Үндсэн хуулиар баталгаажсан төр, түүний байгууллага, эрх мэдэлтэй хэнийг ч өөрийнхөө өмнө мэтгэцэгч нэг тал хэмээн үзэх хууль зүйн бүрэн үндэслэл бий”.

Ардчилсан нийгэмд шүүх нь хүний эрх, эрх чөлөөг юуны өмнө засаг төрийн байгууллага, эрх мэдэлтний хүч хэрэглэх гэсэн хийгээд өөр хэлбэрийн дураар аашилсан ажиллагаанаас хамгаалах зорилготой. Мэтгэлцээнийг бодитой хэрэгжүүлэх нэг чухал баталгаа нь шүүх хуралдааныг нээлттэй явуулах явдал юм. Энэ нь олон нийтэд шүүхийн үйл ажиллагааг хуулийн дагуу ил тод, нээлттэй, шударга явуулж буйг харуулах боломжийг олгодгоороо нэн чухал.

Гагцхүү хуульд заасан дараах үндэслэлээр хэргийн оролцогчдын хүсэлтээр шүүх хуралдааныг бүрэн буюу түүний зарим ажиллагааг хаалттай явуулж болно. Үүнд:

- Хэргийн нотлох баримт, үйл явдал, төрийн нууцад хамаарах бол
- Хэргийн нотлох баримт, үйл явдал, байгууллага, хувь хүний нэр төр, алдар хүнд, ажил хэргийн нэр хүндтэй холбоотой асуудлын хувьд талуудын хүсэлтээр шүүх хуралдааныг хаалттай явуулж болно.

Шинэ Үндсэн хуульд “шүүх бие даасан байх”, “шүүгч хараат бус байх”, “шүүх, шүүгч зөвхөн хуульд захирагдах” гэсэн харилцан хамааралтай зарчмуудыг бүрэн утгаар нь томъёолсоны дээр тэдгээрийг хангах зохион байгуулалт, эрх зүйн хийгээд улс төр эдийн засгийн баталгаа, механизмын үндсийг тогтоож өгсөн байна. Шүүгчийн хараат бус байдлыг туйлшруулан өргөжүүлж болохгүй хэдий ч бас “зөвхөн хэрэг шийдвэрлэх үедээ” хэмээн явцууруулах учиргүй хэмээн бид үзэж байна.

Шүүгчийн хараат бус байдлыг “албан ажил, мэргэжлийн хараат бус байдал, хувийн хараат бус байдал гэх буюу удирдлага зохион байгуулалтын, улс төрийн, эдийн засгийн хараат бус байдал гэж өргөн хүрээнд авч үзэхэд Үндсэн хууль, ЭБШ хуулийн үзэл баримтлалын учир утга оршино⁶.

Энэ нь улс болгонд янз бүрээр нарийвчлан зохицуулсан. Манайд Үндсэн хууль, Шүүхийн тухай хуульд заасан үндэслэл тогтоогдоогүй бол шүүгчийг огцруулж, зэрэг дэв бууруулж, цалинг хасах, танах үйл ажиллагаа явуулж болохгүйг баталгаажуулсан нь хувийн хараат бус байдлыг хангах механизм болно.

Одоо үйлчилж буй ЭБШ хуулийн 17 дугаар зүйлийн 17.1-д “**Шүүн таслах ажиллагааг талуудын эрх тэгш байдал, мэтгэлцээний үндсэн дээр явуулна**” гэж заасан.

Хэрэв энэхүү заалтын утга учрыг нэг мөр, зөв ойлгож чадвал манай ЭБШ ажиллагааны нэгэн ээдрээт асуудал онол практикийн үүднээс үндэслэлтэй зөв

⁵ “Эргэцүүлэл” сэтгүүл 2000 он. №9 №149 дэх тал

⁶ Б.Чимид “Шүүх эрх мэдлийн талаархи Үндсэн хуулийн үзэл баримтлалын тухайд”, “Шүүх эрх мэдэл-шинэ зуун” 2001 он. 53 дахь тал

Шүүн таслах ажиллагаан дахь мэтгэлцэх зарчим ба хүний эрх, эрх чөлөө

шийдвэрлэгдэх төдийгүй хүний эрх, эрх чөлөөг бодитой хангах нэг гол үндэслэл болно.

А. Юуны урьд ЭБШ хуулийн дээрх **заалт аль шатны шүүхийн шийдвэрлэх ажиллагаанд хамаарах вэ?** гэсэн хамгийн түрүүчийн асуулт тавигдана. Онолын үүднээс шүүх засаглалын бодит илэрхийлэл нь анхан шатны шүүн таслах ажиллагаа мөн гэж үзэх нь олонтой⁷.

1. Зөвхөн анхан шатны журмаар хэрэг маргаан шийдвэрлэхэд улсын болоод ард түмний нэрийн өмнөөс тогтоол гаргадаг⁸. /Энэ талаар “Шүүгчийн гарын авлага” номын Шүүхийн харьцаа Анхан шатны шүүн таслах ажиллагаа гэсэн бүлэгт тун тодорхой тусгагдсан. Энэ нь шүүх төрийн гэхээсээ “нийгмийн” шинж бүхий хариуцлага хүлээх үүрэгтэй, тиймээс ч шүүхийн өмнө төр, иргэн хоёр эн чацууран мэтгэлцэх ёстой гэсэн ардчилсан зарчмаас улбаатай/

2. Хэрэг дээрээ зөвхөн анхан шатаар шүүн шийдвэрлэх ажиллагааны үед бусад ямар ч үе шаттай харьцуулшгүй ЭБШ **ажиллагааны бүхий л ардчилсан зарчмууд үйлчилдэг.** /Хэргийн нөхцөл байдлыг ЭБШ хуулинд заасан цөөн тохиолдлоос бусад үед олны өмнө, нээлттэй, ил тод, амаар, шууд, биечлэн хэлэлцэх, мэтгэлцэж буй талууд шүүхийн өмнө тэгш эрх эдлэх, шүүгчийн хараат бус байдлыг, шүүгдэгчийг өмгөөлөх эрхээр хангах, хэрэг маргааныг шийдвэрлэхэд иргэдийн төлөөлөгчийг оролцуулах гэх мэт/.

3. Давж заалдах болон хяналтын шатны ажиллагаа талуудын Үндсэн хуулиар хамгаалагдсан **давж заалдах /энэ нь зөвхөн давж заалдах шатны шүүхэд хандах эрх биш гэдгийг онцлов/ эрхийг хангах нэгэн онцлог хэлбэр** мөн боловч заавал ч гүй байх ёстой шат биш. Энэ бол хэрэглэх, эс хэрэглэх нээлттэй эрхэд зүй ёсоор тооцогддог. Тухайлбал Ром-Германы эрх зүйн бүлд хамаарах Европын ихэнх орнуудад анхан шатны шийдвэрт гомдол гаргах **үндэслэл нь маш нарийн /эрх зүйн ухамсарын түвшин өндөр/ зохицуулалттай** учраас 100-д гурваас дөрвөн удаа л тохиолддог аж⁹. Анхан шатны шүүхийн шийдвэрийн хуулийн төдийгүй бодит үндэслэл, үнэмшилтэй ойлгомжтой байх ёстой гэсэн зүй ёсны шаардлага заавал давж заалдахгүй нь үндэслэл болно.

4. “Хэрэг маргааныг эцэслэн шийдвэрлэх” гэдгийг шүүх засаглалын тодорхойлох шинж болгон авч үзэхдээ шүүн таслах ажиллагааны **процессийн буюу “дотоодын” гэгдэх шаталсан хяналтыг** түүнд тусгайлан хамааруулдаггүйг профессор Дайнекер В., Шюнемен Б¹⁰ нар нэг биш удаа тэмдэглэн хэлжээ.

5. Манай ЭБШ хуулийн тусгай ангийн холбогдох заалтуудаас үзэхэд /ЭБШ хуулийн 246 дугаар зүйлийн 246.1-д анхан шатаар хэрэг хэлэлцэхийг **“шүүн таслах ажиллагаа”** гэж шууд нэрлэсэн. Гэтэл мөнхүү хуулийн 308, 348 дугаар зүйлүүдэд буюу давах болон хяналтын шатаар **“хэргийг хянан шийдвэрлэнэ”, “хянан”** хэмээн томъёологдсон./

⁷Германы эрдэмтэн Б.Шюнемен (“Монгол Улсын ЭБШ хууль, шинжлэх ухааны тайлбар” 1-30 дугаар тал), Оросын эрдэмтэн Лупинская.П.П (“Уголовно-процессуальное право Р.Ф” М., 2000 г. стр 17)., Монголын эрдэмтэн Б.Чимэд (“Үндсэн хуулийн үзэл баримтлал” Хоёрдугаар дэвтэр., УБ. 2001 он. 118-122 дахь тал) нарын бүтээлээс

⁸Германд-Холбооны Бүгд Найрамдах Герман Улсын, Оросод-Оросын Холбооны Улсын, Францад-Францын ард түмний, манайд Монгол Улсын нэрийн өмнөөс шүүхийн тогтоол, шийдвэрийг гаргадаг.

⁹1998 оны 10-р сард Улсын Дээд Шүүхийн Эрүүгийн тэнхим, МУИС-ийн ХЗС-ийн хамтарсан семинар дээр Мюнхены Их Сургуулийн профессор Дайнекер В-гийн тавьсан илтгэлээс Ханнс-Зайделийн сан. 1998 он. мат. №3

¹⁰Дайнекер В. “ЭБШ Эрх зүйн үндсэн ойлголтууд” 1998 он. УБ хотод болсон семинарын материал

Б. “Талуудын тэгш эрхийг хангах /1/, мэтгэлцэх” /2/ гэсэн хоёр ойлголт ЭБШ ажиллагааны зарчимд зүй ёсоор тооцогддог. Гавьяат хуульч, профессор Г.Совд нарын “Хууль зүйн тайлбар толь”-д “Хараат бус шүүхийн өмнө эрх зүйн харилцааны ямар ч субъект /талууд/ эн чашуу эрх эдлэх бөгөөд, энэ нь Монгол Улсын Үндсэн хуульд баталгаажсан нийтлэг шинжийг агуулдаг” гэжээ.

Харин **мэтгэлцэх нь** ЭБШ ажиллагааны тусгай зарчимд тооцогддог¹¹.

ЭБШ хуулийн дээр дурьдсан 17 дугаар зүйлийн заалтуудтай уялдан дараачийн багц асуулт тавигдана. Энэ нь:

Нэгдүгээрт: Мэтгэлцээн нь зөвхөн талууд эрх тэгш байх нөхцөлд бодитойгоор явагдах уу?

Хоёрдугаарт: Зөвхөн хөндлөнгийн, хараат бус шүүхийн өмнө яллах, өмгөөлөх чиг үүргийг хэрэгжүүлж буй хоёр тал мэтгэлцэх үү? Бусад үе шатанд, тухайлбал, **хэрэг бүртгэлт, мөрдөн байцаалтын үед мэтгэлцэх зарчим үйлчлэх үү?**

Гуравдугаарт: Яллах, өмгөөлөх, шүүн шийдвэрлэх чиг үүргийг ЭБШ эрх зүйн харилцааны нэг субъект хариуцан хэрэгжүүлж болох уу? Жишээлбэл, шүүх хэргийн байдлыг тал бүрээс нь бүрэн бодитой тогтооно гэсэн зарчим /ЭБШ хуулийн 16 дугаар зүйл/-ын утга агуулга яаж илрэх вэ?

Хэрэг бүртгэгч, мөрдөн байцаагч, прокурор дээр дурьдсан зарчмыг хэрэгжүүлснээр яллах, өмгөөлөх чиг үүргийг хамтатган биелүүлж байгаа хэрэг мөн үү? гэх мэт.

Манай ЭБШ хуулийн 5 дугаар зүйлийн 5.1.6-д “**талууд**”-ыг шүүх хуралдаанд тэгш эрхтэйгээр мэтгэлцээнд оролцож, яллах, өмгөөлөх чиг үүргийг хэрэгжүүлж байгаа этгээд хэмээснийг энд тодотгон тэмдэглэе.

В. Энэхүү сэдвийн хүрээнд **а/. талуудын тэгш эрхийг хангах; б/. мэтгэлцэх** гэсэн ЭБШ ажиллагааны **бие даасан хоёр зарчим** манай процесст дангаараа болон хамтдаа ямар үе шатанд үйлчилж байна вэ? гэдгийг тодруулах нь нэн чухал зорилтын нэг болох учиртай.

1. Бидний үзэж байгаагаар манай шинэ ЭБШ хуулинд “**оролцогчдын**” болоод “**бусад оролцогчдын**” /ЭБШ хуулийн 5,6 дугаар бүлэг/ **процессийн баталгааг** Монгол Улсын Үндсэн хуулийн үзэл баримтлал, орчин цагийн шаардлага, нийтлэг жишгийн /энд өнөө үеийн онол практикийн олон арван баримтуудыг нэрлэж болно/ дагуу эрс нэмэгдүүлсэн боловч **талуудын эрх тэгш байх болон мэтгэлцэх зарчмын жинхэнэ утгаар үйлчлэх цар хэмжээг анхан шатны шүүн таслах ажиллагааны хүрээнээс өргөжүүлэн авч үзэх онол, практикийн үндэслэл одоогоор бий болоогүй байна.**

2. Мэтгэлцэх болон тэгш эрхийн зарчим нь тус тусдаа **бие даасан шинжийг** илэрхийлэн ЭБШ ажиллагааны янз бүрийн шатуудад **дангаараа буюу цогц уялдаатайгаар** үйлчилж болно. Ялангуяа **хамтдаа** үйл ажиллагаагаа явуулсан тохиолдолд илүү хүчин чадал, үр нөлөө үзүүлнэ. /Тухайлбал, анхан шатны шүүн таслах ажиллагааны үед энэ нь тодорхой илэрдэг/

3. “Талууд” гэсэн нэр томъёо ямар үед хэрэглэгдэхийг манай ЭБШ хууль заан тодорхойлсон. /ЭБШ хуулийн 5 дугаар зүйлийн 5.1.6, 5.1.7, 5.1.8/ Мэтгэлцэх зарчим

¹¹ “Уголовно-процессуальное право Р.Ф” под. ред. Лупинской П.А. М., 2000 г., стр 150-152., Б.Бат-Эрдэнэ “ЭБШ эрх зүйн ерөнхий анги” 2001 номоос ЭБШ ажиллагааны зарчмууд гэсэн бүлгээс дэлгэрэнгүй үзнэ үү.

Шүүн таслах ажиллагаан дахь мэтгэлцэх зарчим ба хүний эрх, эрх чөлөө

нь “талууд” гэсэн ойлголтыг шаардаж таарна. Гэхдээ заавал эн чацуу этгээдүүдийн хооронд л мэтгэлцээн явагдах ёстой гэвэл учир дутагдалтай. ЭБШ ажиллагааны мэтгэлцэх зарчмыг эрх зүйн асуудлаар явагдах ердийн мэтгэлцээнтэй адилтгаж үл болно.

Ром-Германы эрх зүйн бүлд хамаарах ихэнх орнуудын практикаас үзсэн, Япон улсын Профессор Масанори Танабегийн¹² тавьсан илтгэлээс эргэцүүлсэн ч яллах талтай мэтгэлцээн өрнүүлэх боломж нөхцөл өмгөөлөх талд нэлээд хүндрэлтэй. Тухайлбал, мөрдөн байцаалтын шатанд оролцогчид /талууд/ хэрэг дээрээ тэгш эрх эдэлдэггүй, “ирээдүйн” өмгөөлөх талынхан нотлох баримтыг бие даан цуглуулдаггүй гэх мэт олон бэрхшээлийг дурьдаж болно.

1993 онд батлагдан хүчин төгөлдөр болсон шүүхийн тухай хуульд шүүн таслах ажиллагааг мэтгэлцэх зарчмаар явуулахыг хуульчлан тогтоосноос хойшхи хугацаанд мэтгэлцээний журмыг ЭБШ хууль болон ИХШХШТХ-д тусгасан бөгөөд тэдгээрийг хэрхэн ойлгож хэрэгжүүлэх талаар шат дараатай сургалтуудыг шүүгч, прокурор, өмгөөлөгч нарын дунд зохион байгуулж ирлээ.

Байцаан шүүдэг хуучин тогтолцооноос мэтгэлцэх зарчмаар шүүн таслах ажиллагааг явуулах шинэ тогтолцоонд шилжиж байгаа энэ үйл явц практикт ямар байдалтай байгаа, тэдгээрийн ололттой ба дутагдалтай талууд юунд байгааг олж тогтоон цаашид энэ талаар авах арга хэмжээний чиг хандлагыг тодорхойлох зорилгоор янз бүрийн судалгаанууд явагдсаар байна.

Тухайлбал ШЭМШ-ийн хөтөлбөр, Хууль Зүйн Үндэсний Төвөөс эрхлэн Сагдаагийн Академи, МУИС-ийн Хууль Зүйн Сургуулийг оролцуулан 2004 оны 4 сараас мөн оны 8 сарыг дуустал Нийс-лэлийн 7 дүүрэг, Дархан-Уул, Хөвсгөл, Орхон, Сэлэнгэ, Төв, Сүхбаатар аймгуудыг хамруулсан судалгааг нийт 48 шүүх хуралдааныг биечлэн ажиглаж, 350 хүнээс санал асуулга авч, мөн тэдгээрийн нилээдтэй нь ярилцлага хийх хэлбэрээр явуулжээ. Ингэхдээ үр дүнг бодитой болгох үүднээс хот, хөдөөгийн шүүх хуралдаан болон шүүн таслах ажиллагаанд оролцогчдын төлөөлөл тооны хувьд аль болох ойролцоо байлгах бодлогыг судалгаанд баримталжээ. Тухайлбал, ажиглалт хийсэн нийт шүүх хуралдааны 28 нь нийслэлийн, 20 нь аймгуудын байгаа санал асуулгын судалгаанд оролцогчдын талаас илүү хувь нь нийслэлийн, бусад нь аймгуудын хүмүүс байна. Мөн санал асуулгын судалгаанд 87 шүүгч, 82 прокурор, 83 өмгөөлөгч, 98 иргэдийн төлөөлөгч болон бусад хүмүүс оролцсон нь өнөөгийн бодит байдалд үнэлэлт өгөхөд боломжтой нь ажиглагдав.

Тус судалгаанд оролцогчдын 64 нь эрүүгийн, 23 нь иргэний шүүн таслах ажиллагааны төрлөөр асуулгад хариулсан бөгөөд судалгааны явцад ажиглалт хийсэн шүүх хуралдааны 40 нь эрүүгийн, 8 нь иргэний хэргийнх байсан аж.

Шүүн таслах ажиллагааны практик дахь мэтгэлцээний төлөвшилийг харуулсан судалгаа нь төв, орон нутгийн өнөөгийн нийтлэг дүр төрхийг үндсэндээ харуулж чадсан юм. Судалгаанд оролцогчдын 49 хувь нь шүүх хуралдаанд мэтгэлцээний хэлбэрийг ягштал баримтлах явдал хэвшил болон төлөвшиж чадсан, 37,4 хувь нь чадаагүй, 48,5 хувь нь мэтгэлцээний хэрэгжилт хангалтгүй байна гэж үзсэн наандаж ЭБШ ажиллагааны оролцогчдын цаашилбал, хүний эрх, эрх чөлөөг бодитойгоор хангах ажиллагаа мөн алаг цоогтой байгааг харуулж байна.

¹² “ЭБШ ажиллагаан дахь мэтгэлцээн” ОУ-ын ЭШ-ний хурал 2004 оны 12 дугаар сар. Материал нь Хууль зүйн үндэсний төвд хадгалагдаж буй.

ӨМЧИЙН ЭРХИЙН ХӨГЖЛИЙН ЭРХ ЗҮЙН ОРЧИН, ӨМЧИЙН ЭРХИЙН ЗАРИМ ЭГЗЭГТЭЙ АСУУДАЛ

О.Жамбалдорж,
Хууль зүйн ухааны доктор, профессор

Монгол улсад сүүлийн 80 гаруй жилийн хугацаанд өмчийн харилцаанд эрс тэс өөрчлөлт гарсан билээ. 1921 онд Ардын хувьсгал ялж социалист байгуулалт үргэлжилж хувийн өмчийг нийгэмчлэн устгаснаар социалист буюу улсын өмчийг шүтэж, улсын өмч дагнан ноёрхох болсон юм. 1990-ээд он гэхэд Монгол улсад улсын өмч, хоршооллын өмч гэсэн социалист өмчийн хоёр хэлбэр нэгэнт баттай тогтсон бөгөөд иргэдийн хувьд хувийн өмч устгагдаж гагцхүү амины өмчтэй байхыг хуулиар зөвшөөрч байлаа.

Энэ бүхэн нь Монгол улсад өмчийг иргэдийн амьжиргааны эх үүсвэр болгон ашиглах боломж, иргэний гүйлгээнд оруулж нийгмийн болон иргэдийн амьдралд гүйцэтгэх үүрэг, мөн чанарыг алдагдуулсан ноцтой алдаа байсан юм. Энэ нь дэлхийн ихэнх орны нийтлэг жишгээс хазайсан айхтар хор уршиг тарьсныг Монголын ард түмэн нуруундаа үүрсэн төдийгүй өнөөдөр ч түүний хор уршигийг даван туулж арилгахаар зүтгэж байна.

Харин 1990-ээд оноос манай орон зах зээлийн харилцаанд шилжиж дэлхийн эдийн засгийн хөгжлийн түгээмэл хандлагад нийцсэн олон хэвшил бүхий эдийн засагтай байх чиглэлээр хөгжих боллоо. Монгол улсын Үндсэн хуулийн 5-р зүйлд: Төр нь нийтийн болон хувийн өмчийн аливаа хэлбэрийг хүлээн зөвшөөрч, өмчлөгчийн эрхийг хуулиар хамгаална гэж заажээ. Ийнхүү монголын төр хувийн өмчийн аливаа хэлбэрийг хүлээн зөвшөөрч өмчийн бүх хэлбэрийг адил хамгаалах болсон билээ.

Үүнээс хойш харьцангуй түргэн хугацаанд хувийн өмчийн асуудал ихээхэн үр дүнтэй шийдвэрлэгдэж байгаа юм. Өмчийн олон хэлбэр, түүний дотор хувийн өмчийг бий болгох, баталгаажуулах талаар томоохон алхам хийсэн гэж баттай дүгнэж болно. Төрөөс хувийн өмчийн талаар авсан арга хэмжээ улс төр, эдийн засаг, эрх зүйн зэрэг нийгмийн амьдралын бүх салбарыг хамарсан билээ. 1991 онд Өмч хувьчлах тухай хууль батлагдаж монгол улсад төрийн өмч хувьчлал явагдаж төр иргэдийн өмчийг эргүүлэн олгож иргэдийг өмчтэй болгох талаар чухал арга хэмжээ авсан бөгөөд одоо ч төрийн өмчийн хувьчлал үргэлжилсээр байна.

Монгол улсын Иргэний хууль богино хугацаанд хоёр ч удаа (1994, 2002) шинэчлэгдлээ. 2002 оны Иргэний хуульд зааснаар Монгол улсад нийтийн болон хувийн өмч байна. Нийтийн өмч нь төрийн, орон нутгийн шашины, олон нийтийн гэсэн хэлбэртэй байна. Хувийн өмч нь иргэний болон дундын гэсэн хэлбэртэй байна. Нийтийн болон хувийн өмч нь холимог хэлбрээр байж болно.

Өмчийн эрхийн хувьд гарсан бас нэг томоохон шинэчлэлт бол Монгол улсын иргэнд газар өмчлүүлсэн явдал юм. 2002 онд Монгол улсын иргэнд газар

өмчлүүлэх тухай хууль батлагдаж хот, сууринд амьдарч буй монгол улсын иргэнд гэр бүлийн хэрэгцээний болон аж ахуйн зориулалтаар газар өмчлүүлэхээр боллоо. Энэ нь зах зээлийн нөхцөлд иргэдийг үл хөдлөх хөрөнгөтэй болгож газрыг иргэний гүйлгээнд оруулж байгаа улс төр, эдийн засгийн маш чухал арга хэмжээ мөн.

Монгол улсын иргэдийн хувийн аж ахуй эрхлэх эрхийн хэрэгжилтийн талаар тусгайлан хэдэн зүйлийг хэлэх ёстой. Манай иргэд хувийн аж ахуй эрхэлж үр дүнг нь өмчлөх болсон юм. Иргэд хувийн аж ахуйг эрхлэх эрх зүйн зохицуулалт удаан бэрхшээлтэй замыг туулж, одоо зарим зохицуулалт бий болж иргэдийн амьжиргаагаа залгуулах “хамгийн дөхөмтэй хэлбэр” болж байна.

Монгол улсын иргэд Монгол улсын Үндсэн хуулийн 16-р зүйлийн 4-т зааснаар “Хувийн аж ахуй эрхлэх эрхтэй”. Иргэд хувийн аж ахуй эрхлэх эрхээ хэрэгжүүлэхдээ өөрийн өмч хөрөнгийг ашиглаж төрөл бүрийн үйлдвэрлэл, үйлчилгээ эрхлэн явуулж ашиг олох бүрэн боломжтой. Энэ нь өмч эдийн засгийн категори гэсэн ойлголтод бүрнээ нийцэж байгаа юм.

Иргэд өмч хөрөнгөдөө тулгуурлан эрхлэх хувийн үйлдвэрлэл, ажил, үйлчилгээний төрлийг зах зээлийн харилцааны үйл явц, нийгмийн амьдарлын хэрэгцээ аяндаа тодорхойлсон билээ.

Өнөөдөр манайд хүн амын хэрэгцээний наад захынхаас эхлээд чухал чухал нэр төрлийн үйлдвэрлэл, ажил, үйлчилгээ олноор бий болж, нэр төрөл нь улам нэмэгдсээр байна.

Манай иргэд олон төрлийн үйлдвэрлэл, ажил, үйлчилгээг хуулийн этгээд байгуулахгүйгээр эрхлэн явуулж байгаа нь зах зээлийн нийгмийн хөгжлийн давуу тал, хүний эрхийг чөлөөтэй хэрэгжүүлж байгаагийн нотолгоо гэж хэлж болно. Иргэдийн эрхэлж буй аж ахуйн үйл ажиллагаа нь нилээд өргөн хүрээтэй бөгөөд эдгээр үйл ажиллагааны ихэнх хэсгийг хүн амын орлогын албан татварын хуулиар зөвшөөрсөн хүрээнд явуулж байна. Хүн амын орлогын албан татварын хуулийн¹ 5-р зүйлд зааснаар иргэд гэр бүлээрээ буюу хамтарч гэрээгээр ажил, үйлчилгээ эрхлэх, гахай, шувуу, түүлай, зөгийн аж ахуй, газар тариалангийн үйлдвэрлэл эрхлэх зэрэг үйлдвэрлэл, ажил, үйлчилгээ явуулж болно. Иргэд орлогыг нь тухай бүр тооцох боломжтой аж ахуй эрхэлж байгаа тохиолдолд аж ахуйн орлогоос баримтаар нотлогдож буй зардал, авто болон өөрөө явагч хэрэгслийн албан татвар, онцгой албан татвар, байгалийн нөөц ашигласны хураамж, төлбөрийг хассан зөрүүгээр албан татвар төлдөг. Мөн албан татварыг байгаль, цаг уур, зах зээлийн нөхцөл, ижил үйлдвэрлэгчтэй харьцуулсан жишгээр татварын алба тодорхойлж болно.

Иргэд “Орлогыг нь тухай бүр тодорхойлох боломжгүй ажил, үйлчилгээ хувиараа эрхлэгч иргэний орлогын албан татварын тухай хуульд² заасан олон төрлийн ажил, үйлчилгээ эрхлэн явуулж болно. Энэ хуулийн дагуу орлогыг нь тухай бүр тодорхойлох боломжгүй ажил, үйлчилгээ, аж ахуйн нэгж, байгууллага иргэдтэй байгуулсан гэрээ, хэлцлээр зохицуулагдаагүй бусад ажил, үйлчилгээ эрхлэн явуулахыг зөвшөөрч, сар тутам төлөх албан татварын хэмжээг заасан байна. Энэ хуулийн 5-р зүйлийн 1-д нэгтгэж төрөлжүүлэн 15 хэсэгт хуваасан ажил,

¹ Татвар, Эрх зүйн баримт бичгийн эмхтгэл, УБ. 2004 он. 265-273 хуудас.

² Татвар, Эрх зүйн баримт бичгийн эмхтгэл, УБ. 2004 он. 313-331 хуудас.

үйлчилгээнээс шууд хураах татварын хэмжээг тодорхойлж, 5-р зүйлийн 3 дахь хэсэгт 20 шахам төрлийн ажил, үйлчилгээний татварын хэмжээг Засгийн газраас тогтоохоор заажээ.

Дээр дурьдснаас үндэслээд дүгнэхэд, иргэн хувийн аж ахуй эрхлэх гэдэг нь иргэн хувийн өмчдөө тулгуурлан ашиг олох зорилгоор өөрийн зардал, эрсдлээр худалдаа арилжаа, ажил, үйлчилгээ явуулж байгаа аж ахуйн бие даасан үйл ажиллагаа юм.

Ийнхүү иргэн хувийн аж ахуй эрхлэхийн тулд дараахь нөхцлийг бүрдүүлэх үүрэгтэй. Үүнд:

Нэгд. Хувийн аж ахуй эрхэлж буй этгээд нь Иргэний хуулийн 15-р зүйлд заасан Иргэний эрх зүйн бүрэн чадамжтай байх шаардлагатай. Энэ шаардлагын үүднээс үзвэл, тухайн иргэн өөрийн үйлдлээр өөртөө эрх олж авах, үүрэг бий болгох чадвартай болох насанд хүрсэн байхаас гадна сэтгэцийн өвчний улмаас эрх зүйн чадамжгүй гэж тооцогдоогүй, эсхүл мансууруулах болон сэтгэцэд нөлөөлөх бодис, согтууруулах ундаа байнга хэрэглсний улмаас эрх зүйн чадамж нь хязгаарлагдаагүй байх ёстой.

Хоёрт. Хувийн аж ахуй эрхэлж буй иргэн нь тухайн нутаг дэвсгэрийн татварын албанд бүртгүүлж энэ тухай гэрчилгээ авсан байх ёстой. Уг этгээд гэрчилгээгээ ажил, үйлчилгээ хийх үедээ ажлын байр, тээврийн хэрэгсэлдээ ил байрлуулж, тогтоосон гудамж, талбайд болон хилийн боомтоор нэвтрэх үед биедээ авч явна.

Иргэдийн хуулийн этгээд байгуулахгүйгээр эрхэлж болох үйлдвэрлэл, ажил үйлчилгээний ихэнх нь иргэн дан өөрийн хүчээр эрхлэн явуулах боломжгүй ажил, үйлчилгээ байгаа нь ойлгомжтой. Ийм учраас иргэд хувийн аж ахуйг эрхлэхдээ бусдын хөдөлмөр, ажиллах хүчийг хөлслөх эрхтэй.

Хүнсний ногоо тарих, газар тариалан эрхлэх, авто засварын газар ажиллуулах зэрэгт хөлсний хөдөлмөр ашиглахгүй байхын аргагүй. Ажиллах хүчийг хөлслөх ажил нь Иргэний хууль, Хөдөлмөрийн хуулийн хүрээнд гэрээний үндсэн дээр хийгдэх ёстой.

Хуулийн этгээд байгуулахгүйгээр аж ахуй эрхэлж байгаа нь эд хөрөнгийн өмчлөгч иргэн өөрийн аж ахуйн үйл ажиллагааны улмаас бусдад учруулсан хохиролоо өөрөө бүрэн хариуцах ёстой. Учир нь уг иргэний аж ахуйг эрхлэхэд ашиглаж байгаа эд хөрөнгийг бусад эд хөрөнгөөс тусгаарлах боломжгүй тул уг иргэн шаардлага гарсан тохиолдолд өөрийн бүх эд хөрөнгө өрөө (хуулиар хураан авахыг хориглосноос бусад) хариуцлага хүлээнэ.

Хувийн аж ахуй эрхлэх ажлын эрх зүйн зохицуулалт үндсэндээ захиргааны эрх зүйн буюу татвар авах талаасаа зохицуулагдаж байна. Цаашид хувийн аж ахуйг эрхлэх ажлын иргэний эрх зүйн зохьцуулалтыг бий болгож, уг аж ахуйн тухай ойлголт, түүнийг эрхэлж буй иргэний эдийн хариуцлага, дампуурсныг хүлээн зөвшөөрөх зэрэгтэй холбогдсон харилцааг нарийвчлан зохицуулах шаардлагатай.

Энэ бүх арга хэмжээний гол зорилт нь иргэдийг өмчтэй болгож зах зээлийн харилцаа хөгжих бодит боломжийг бүрдүүлэхэд оршиж байгаа юм.

Ийнхүү Монгол улсад өмчийн эрх улам хөгжих эрх зүйн аятай орчин бүрдсээр байна. Гэвч иргэний шинэ хууль, түүнд нийцүүлэн гаргасан буюу өөрчилсөн гэх иргэний хууль тогтоомжид агуулгын хувьд маргаантай төдийгүй хүний эрхийг

хангах бодлогод нийцгүй зарим хэм хэмжээ тусгагдсаар байгаа нь эрдэмтэд, хуульчдын сонирхлыг зүй ёсоор татаж байна.

Өмчийн эрхийн зарим эгзэгтэй асуудлыг онцлон тусад нь авч үзэх нь онолын хувьд ч, Иргэний хууль болон иргэний хууль тогтоомжид холбогдох заалтыг цаашид боловсронгуй болгоход ч ач холбогдолтой гэж үзэж байна. Үүнд:

Нэгдүгээрт: Өмчлөлийн зүйлээ чөлөөтэй эзэмших, ашиглах, захиран зарцуулах өмчлөгчийн бүрэн эрх хэрхэн хэрэгжиж ирсэн, хэрхэн хэрэгжиж байгаад зохих дүгнэлт өгөх нь чухал.

Өмчлөгч өмчлөлийн зүйлээ чөлөөтэй ашиглах, эзэмших, захиран зарцуулах гэсэн агуулгаар нь үзэхэд өмчлөгч эдгээр эрхээ бодит байдалд бүрэн хэмжээгээр эдэлж чадаж байгаа эсэх, энэ бүрэн эрхээ эдлэх эрх зүйн орчин бүрдсэн эсэхийг анхаарч тодорхойлох нь эрдэмтэд бидний үүрэг билээ.

1994 оны Иргэний хуулиар иргэний эрх зүйн харилцаанд оролцогчид өмчлөлийн зүйлээ ашиглах, эзэмших, захиран зарцуулах адил тэгш эрх, боломж олгосон мэт хуулийн заалттай байсан. Жишээлбэл: Иргэний хуулийн 1-р зүйл: Иргэний харилцааг түүнд оролцогчдын эрх тэгш байдал, хүсэл зоригийн болон эд хөрөнгийн бие даасан байдлыг үндэслэн зохицуулна.

Өмчлөгч нь эд юмсыг өөрийн үйл ажиллагааны зорилго, дүрмийн дагуу эзэмших, ашиглах, зарцуулах эрхтэй (Иргэний хуулийн 75-р зүйл) гэж заасан боловч үнэн хэрэгтээ төр өмчлөгч иргэнтэй харьцуулахад өмчлөлийн эрхийн хувьд хамаагүй илүү эрх дарх эдэлж байсан бөгөөд иргэний өмчийг төрийн өмч, улсын орлогод хураан авах янз бүрийн үндэслэлийг Иргэний хуулиар тогтоосон байв. Иргэний хуулийн 134-р зүйл: “Гагцхүү хуульд заасан үндэслэл, журмын дагуу нийгмийн зайлшгүй хэрэгцээг үндэслэн бусдын эд хөрөнгийн үнийг төлж, төрийн өмчид дайчлан авах, эсхүл эрх зүйн зөрчил гаргасан этгээдийн эд хөрөнгийг үнэ төлбөргүй хурааж болно” гэж заасан нь иргэдийн өмчийг төрийн өмч (улсын орлого)-д хураан авах үндэслэл болж байсан юм.

Ийм агуулгатай заалт Иргэний хуулийн арван дөрвөн зүйлүүдэд дурьдагдаж байлаа. Эзэнгүй буюу эзэн нь тогтоогдоогүй эд хөрөнгө (Иргэний хуулийн 125-р зүйл), гээгдсэн эд хөрөнгийн эзэн нь нэг жилийн дотор тогтоогдоогүй (Иргэний хуулийн 127-р зүйл), газарт булсан, эсхүл орхигдсон дарагдмал мөнгө, үнэт зүйл (Иргэний хуулийн 128-р зүйл)-ийг шууд төрийн өмчид хураан авах, харин түүх, соёлын зүйлийг эвдэж гэмтээх зэргээр гамгүй эзэмшсэн бол шүүхийн шийдвэрээр дайчлан авах (Иргэний хуулийн 129-р зүйл)-аар заажээ.

Үүгээр зогсохгүй үүргийн эрх зүйн харилцаанд ч иргэний өмчийг төрийн өмчид хураан авах тухай цөөнгүй заалт мөрдөгдөж байв. Тухайлбал: нийгмийн ашиг сонирхолд харшилсан хэлцэл санаатай хийсэн (Иргэний хуулийн 45-р зүйл), хүчин төгөлдөр бус хэлцлийг халхавчилсан хэлцэл хийсэн (Иргэний хуулийн 48-р зүйл), хууран мэхлэх, хүч хэрэглэх, айлган сүрдүүлэх аргаар хийсэн хэлцэл нь хүчин төгөлдөр бус гэж тооцогдсон (Иргэний хуулийн 50-р зүйл) бол уг хэлцлээр авсан зүйлийг, эсхүл үнийг улсын орлогод хураахаар заасан байв. Мөн хадгалалтын хугацаа дууссан эд хөрөнгийг хадгалуулагчид олгох, тийм боломж байхгүй бол улсын орлогод хураана (Иргэний хуулийн 354-р зүйл). 1994 оны Иргэний хуулийн ниймэрхүү заалтыг үргэлжлүүлэн дурьдаж болох байна.

Эдгээр заалт нь үндсэндээ 2002 оны Иргэний хуулиар хасагдаж залруулагдсан нь өмчийн эрхийн агуулгад томоохон өөрчлөлт орж, баталгаа бий болсныг харуулж байна. 1994 оны Иргэний хуульд хадгалагдан үлдсэн социалист эрх зүйн зохьцуулалтыг уг шинэ төсөлд (хуульд-зохиогч) оруулаагүй бүрмөсөн татгалзсанаас үзэхэд энэ хууль томоохон өөрчлөлтийг агуулж байна гэж Германы эрдэмтэн Рольф Книйпер онцлон тэмдэглэсэн байна.³ 2002 оны Иргэний шинэ хууль батлагдсанаар өмчлөгчийн өөрийн бүрэн эрхээ хэрэгжүүлэх боломж ихээхэн нэмэгдэж баталгаа нь эрс сайжирсан гэж дүгнэж болно.

Гэвч 2002 оны Иргэний хууль хувийн өмчид халдах үндэслэлийг бүрэн арилгаагүй нь харамсалтай. Тухайлбал, Иргэний хуулийн (2002 он) 237-р зүйлийн 9 дэх хэсэгт: Нотариат өөртөө хадгалуулахаар шилжүүлсэн зүйлийг гурав хүртэл жил хадгалах бөгөөд энэ хугацаанд үүрэг гүйцэтгүүлэгч уг зүйлийг хүлээн аваагүй бол энэ тухай үүрэг гүйцэтгэгчид мэдэгдэж хадгалуулсан зүйлээ буцааж авахыг түүнээс шаардана. Хэрэв тогтоосон хугацаанд уг зүйлийг буцааж аваагүй бол түүнийг төрийн өмчид шилжүүлнэ гэж заажээ. Энэ заалт нь зохиогчийн үзэж байгаагаар иргэний өмчийн эрхэд зүй бусаар халдаж байгаа хэрэг юм.

Нотариатад хадгалуулсан зүйлийг ийнхүү төрийн өмчид шилжүүлснээр үүрэг дуусгавар болно гэж Иргэний хуулийн 237-р зүйлд заасан нь үүрэг дуусгавар болох эрх зүйн мөн чанарт нийцэхгүй байна. Үүрэг гүйцэтгэгч үүргээ зохих ёсоор гүйцэтгэж үүрэг гүйцэтгүүлэгч үүргийн гүйцэтгэлийг бодитойгоор хүлээн авсан нь үүрэг дуусгавар болох нийтлэг үндэслэл мөн. Гэтэл үүрэг гүйцэтгүүлэгч үүргийн гүйцэтгэлийг хүлээж аваагүй байхад үүргийг дуусгавар болгох нь үүргийн эрх зүйн үндсэн зарчимд тохирохгүй. Үүргийн гүйцэтгэлийг хүлээж авахаас татгалзсан гэх үндэслэл энд байхгүй байна.

Үүрэг гүйцэтгүүлэгч үүргийн гүйцэтгэлийг хүлээн авах хугацааг хэтрүүлсэн нь тухайн үед нотариатад хадгалуулсан зүйлийн зардлыг төлөх хөрөнгөгүй, эсхүл гадаадад удаан хугацаагаар явсан зэрэг хүндэтгэн үзэх шалтгаантай байж болно. Мөн үүрэг гүйцэтгэгч ч гэсэн эзгүй байсан байж болно. Энэ талаар тухайн зүйлд тодорхой заалт байхгүй байна.

Ийнхүү зөвхөн тодорхой хугацаанд үүргийн гүйцэтгэлийг хүлээн аваагүй бол өмчийн эрхээ алдаж, уг өмч хөрөнгийг төрийн өмчид шууд шилжүүлж байгаа нь иргэн (хуулийн этгээд)-ий өмчийн эрх ноштой зөрчигдөж байгааг харуулж байна. Ийнхүү төрийн өмчид шилжүүлэх асуудлыг ямар байгууллага, албан тушаалтны шийдвэрээр гүйцэтгэх нь тодорхойгүй байна. Ингээд зогсохгүй иргэний эрх зүйн харилцааны бусад оролцогчдын эрх, ашиг сонирхолд ч харшилж байгаа юм. Зохих хугацаагаар, хуульд зааснаар 3-аас доошгүй жил өмч хөрөнгийг хадгалж хамгаалсан нотариат хадгалалт хамгаалалтынхаа зардлыг төлүүлэх боломжгүй болж байна.

Үүрэг гүйцэтгэгч үүргийн гүйцэтгэлээ хадгалуулахаар нотариатад шилжүүлснээр үүргээ гүйцэтгэсэнд тооцогдож үүргээс чөлөөлөгдөх боловч нөгөө талын өмнө зан суртахууны хувьд ямар байдал орох нь тодорхой. Иргэний эрх зүйн харилцаанд оролцогчид харилцан ашигтай ажиллаж хүсэл зоригоо хэрэгжүүлсэн байх ёстой.

³ Доктор, профессор Рольф Книйпер, Монголын иргэний шинэ хуулийн төслийн тухай “ШИХИХУТАГ” сэтгүүл 2000 он, № 1, УБ. 24 дэх тал

Хоёрдугаарт: Иргэний хуулийн 453-р зүйлийн 2 дахь хэсэгт “Зээлдэгч зээлийн гэрээгээр хүлээсэн үүргээ биелүүлээгүй тохиолдолд барьцааны зүйлийг үл маргах журмаар зээлдүүлэгчид шилжүүлэхээр гэрээнд заасан бол тухайн барьцааны зүйлийг гэрээний хугацаа дууссан өдрөөс эхлэн зээлдүүлэгч захиран зарцуулах эрхтэй” гэж заажээ. Энэ заалт нь иргэний хууль тогтоомжийн өмчийн халдашгүй байдал, иргэний эрх зүйн харилцаанд оролцогчдын эрх тэгш байдлын зарчимд үндсэндээ харшилж байна гэж хэлж болно.

Энэ заалтаас үзэхэд иргэний эрх зүйн харилцаанд талууд тэгш эрхтэй оролцох ёстой байтал банк, зээлийн үйл ажиллагаа эрхлэх эрх бүхий байгууллага зээлдэгчид тэгш бус нөхцөл тулгасан шинжтэй байгаа нь харагдаж байна. Энэ нь мөнгө эзэмшиж байгаа давамгайл байдлаа шударга өрсөлдөөнд харшаар ашиглах, тухайлбал нөгөө талд ашиггүй, бүр ихээхэн хохиролтой, өмчид нь шууд халдах нөхцөл тулгах боломж олгож байгаагаараа “Шудрага бус өрсөлдөөнийг хориглох тухай” хуулийн заалт, агуулгад харшилж байна.

Гэрээний нөгөө тал өмчийн эрхэд дур мэдэн халдах эрх олж аваад зогсохгүй, барьцааны зүйлийг захиран зарцуулах эрхтэй болж байгаа нь хамгийн ноцтой явдал мөн. 1994 оны Иргэний хуульд ч ийм заалт байгаагүй. Ийнхүү үзвэл хүний эрх, өмчийн эрхийн хувьд ухарсан гэж хэлж болно.

Иргэний хуулийн 453-р зүйлийн 2 дахь хэсэгт “барьцааны зүйл” гэж заасан тул барьцаанд үл хөдлөх ба хөдлөх эд хөрөнгийн алиныг ч тавьж болох бөгөөд уг заалтад барьцааны үл хөдлөх буюу хөдлөх хөрөнгө гэж ялгаагүй. Харин Иргэний хуулийн 171-р зүйлийн 3 дахь хэсэгт: Үүрэг гүйцэтгүүлэгчийн шаардлагыг бүрэн буюу хэсэгчлэн хангаагүй бол үл хөдлөх эд хөрөнгө өмчлөх эрх түүнд шилжинэ гэж тохирсон хэлцэл хүчин төгөлдөр бус байна гэж заасныг үндэслээд Иргэний хуулийн 453-р зүйлийн 2 дахь хэсгийн заалт үл хөдлөх хөрөнгөд хамаарахгүй гэж тойруу замаар нотолж болно. Манай шүүхүүд ч ингэж үзэж байгаа нь зүйтэй байх.

Профессор Д. Наранчимэг бичихдээ: 2002 оны Иргэний шинэ хуульд иргэний эрх зүйн харилцаанд оролцогчдын хууль зүйн тэгш байдлыг хангах зарчмыг аль болох бүрэн дүүрэн баталгаажуулах үүднээс хэн нэгэн этгээдийн давуу эрхийг хязгаарласан зохицуулалт тусгасан юм. Тухайлбал, Иргэний хуулийн 171-р зүйлийн 3-ын заалт нь Банк болон банк бус санхүүгийн байгууллага зээлийн барьцаанд барьсан үл хөдлөх эд хөрөнгийг дур мэдэн захиран зарцуулах давуу эрхийг хязгаарласан гэж хэлж болно гэжээ.

Ингээд үзэхээр Иргэний хуулийн 453-р зүйлийн заалт нь гагцхүү хөдлөх хөрөнгөд хамааралтай болж байгаа юм.

Иргэний хуулийн 235-р зүйлд зааснаар хэрэв зээлдэгч үүргээ биелүүлээгүй бол барьцааны зүйл болох хөдлөх эд хөрөнгийг үл маргах журмаар зээлдүүлэгчид шилжүүлэхээр гэрээнд заасан бол гэрээний хугацаа дууссан өдрөөс эхлэн зээлдүүлэгч түүнийг захиран зарцуулах эрхтэй болж байна. Энэ заалт нь гэрээний эрх чөлөөний зарчимд харшилж байна. Гэрээнд ийм заалт оруулахгүй бол зээл олгохгүй тул зээлдэгч уг заалтыг зөвшөөрөхөөс өөр аргагүй байдалд орно.

Хуульч эрдэмтдийн дотор иймэрхүү санал үзэл баримтлал байгаа боловч эдийн засагчид, тухайлбал, Эдийн засгийн ухааны доктор, Монгол банкы тэргүүн дэд захирал А.Батсүх: Иргэний хуулийн 453-р зүйлийн 2 дахь хэсгийн заалтын утга санаа нь өмнө нь дурьдсан хөрөнгийн зах зээл дээр үүссэн гүнзгий гажуудлыг

арилгахад суурь ач холбогдолтой алхам болсон юм. Харин Иргэний хуулийн 171-р зүйлийн 1, 3 дахь хэсгийн заалт нь “ барьцаа хөрөнгийг эргэн төлүүлэх утга агуулгатай зөрчилдөж байгаа юм”. Ийм учраас “Иргэний хуулийн 171-р зүйлийн 1, 3 дахь хэсэгт хуульд тусгайлан заасан тохиолдолд тухайн төрлийн хэлшлийг хүчин төгөлдөр бус гэж үзэхгүй байх тодотголыг хийхгүйгээр энэ чиглэлээр хийгдсэн эрх зүйн шинэтгэл цогц болж чадахгүйд хүрэхээр байгаа юм”⁴ гэж дурьдсанаас үзэхэд уг заалтыг улам лавшруулан тодотгох саналтай байгаа юм. Энэ санал нь банк, санхүүгийн байгууллагын эрх ашигт одоогоор нийцэж байгаа мэт ойлгогдож байгаа боловч цаашид урьд гаргасан алдаагаа улам лавшруулахад хүргэж мэдэх талтай.

Нөгөө талаар Иргэний хуулийн 453-р зүйлийн 2 дахь хэсгийн заалтын дагуу зээлдэгч зээлийн гэрээгээр хүлээсэн үүргээ биелүүлээгүй бол барьцааны хөдлөх эд хөрөнгийг үл маргах журмаар зээлдүүлэгчид шилжүүлэх гэрээний хугацаа дууссан өдрөөс зээлдүүлэгч захиран зарцуулах эрх эдэлж болно. Үүнийг ч гэсэн эргэн харж үзэх ёстой болов уу.

Монгол улсын Хүний эрхийг хангах үндэсний хөтөлбөрт: “Эд хөрөнгийг өмчлөгчийн зөвшөөшөлгүйгээр өр зээлд дүр мэдэн сонгож, үнэлж авах... зэрэг ноцтой зөрчлийг арилгах арга хэмжээ авна” гэж заажээ.⁵

Банк, зээлийн үйл ажиллагаа эрхлэх байгууллага хөдлөх эд хөрөнгийг яаж үнэлж барьцаанд авахыг хэн ч гэсэн гадарлах байх. Энэ нь өмчийн эрх, зээлдүүлэгчийн ашиг сонирхолд нийцтэй байхгүй нь ойлгомжтой. Энэ санал нь Иргэний хуулийн заалтыг уг хууль, Шудрага бус өрсөлдөөний тухай хууль зэрэгт нийцүүлэх шаардлагаас урган гарч байгаа юм. “... иргэний эрх зүйн харилцааны субъектүүдийн эрхийн тэгш байдал, эрх, үүргийн болон ашиг сонирхолын нэгдэл, тэнцвэрийг аль болох шударгаар хангах харилцан ашигтай байх зарчимд нийцүүлсэн зохицуулалт зайлшгүй шаардлагатай болох нь өнөөгийн амьдарлын бодит практикаас урган гарч байгаа юм”⁶.

Гуравдугаарт. Иргэний шинэ хуульд (2002 он) өмчийн эрхийн холбогдолтой өөр нэг сонирхолтой заалт орсон байна. Монгол улсын Иргэний шинэ хууль нь уламжлал ёсоор эх газрын эрх зүйн тогтолцооны дагуу цогцолсон гэдэг нь маргаангүй тогтсон асуудал. Гэтэл Иргэний хуульд эх газрын эрх зүйн тогтолцоонд нийцгүй мэт заалт оржээ. Тухайлбал, Иргэний хуулийн хөрөнгө итгэмжлэх тухай 406-р зүйлд: “Хөрөнгө итгэмжлэх гэрээгээр итгэмжлэгч нь хөдлөх эд хөрөнгө буюу эрхийг итгэмжлэгдсэн өмчлөгчид шилжүүлэх, итгэмжлэгдсэн өмчлөгч нь итгэмжилсэн эд хөрөнгийг хүлээн авч итгэмжлэгчийн эрх, ашиг сонирхолд нийцүүлэн захиран зарцуулах үүрэг хүлээнэ” гэж заасан байна. Энэ заалтаас үзэхэд нэг эд хөрөнгөд хоёр өмчлөгч байхаар ойлгогдож байна.

Итгэмжлэгч нь итгэмжлэгдсэн өмчлөгчид эд хөрөнгөө өмч болгон шилжүүлж, тэр нь түүнийг захиран зарцуулах үүрэгтэй болж байна.

Бидний үзэж байгаагаар хөдлөх эд хөрөнгө нь итгэмжлэгдсэн этгээдийн

⁴ Доктор А. Батсүх, Банк, санхүү болон даатгалын эрх зүй, Монголын эрх зүйн шинэтгэл- 8 жил, УБ, 2003 он. 257 дахь тал

⁵ Төрийн мэдээлэл, 2003 он, № 42 /327/. 910-932 дахь тал

⁶ Д. Наранчимэг, Иргэний болон худалдааны эрх зүй, Монголын эрх зүйн шинэтгэл- 8 жил, УБ, 2003 он. 190 дахь тал

өмчлөлд бус, харин итгэмжлэгдсэн этгээдийн удирдлагад шилжүүлэх тухай яригдаж байгаа мэт.⁷

Иргэний хуулийн 406-р зүйлийн дараачийн хэсгүүдийн агуулгаас үзэхэд ийм ойлголт аяндаа төрж байна. Энэ зүйлийн 3 дахь хэсэгт: Итгэмжлэгдсэн өмчлөгч нь итгэмжилсэн эд хөрөнгийг өөрийн нэрийн өмнөөс итгэмжлэгчийн эрх, ашиг сонирхолд нийцүүлэн итгэмжлэгчийн зардал, эрсдлээр захиран зарцуулах үүрэгтэй гэж заажээ. Энэ нь өмчийн эрхийн Иргэний хуульд дурьдсан агуулгатай зөрж байна. Итгэмжлэгдсэн этгээд нэгэнт өмчлөгч юм бол бүх зардал, эрсдлийг хариуцах ёстой. Ингээд үзэхээр энэ зүйлийн заалт нь зөрчилтөй бөгөөд эд хөрөнгө нь итгэмжлэгдсэн этгээдийн өмчлөлд шилжээгүй байна. Иймд хууль тогтоогч аль хэр зөв нэр томьёо хэрэглэсэн болох, энэ нь манай иргэний эрх зүйн тогтолцооны мөн чанарт хэрхэн нийцэж байгаа нь эзгэлзээтэй байна.

Иргэний эрх зүйд эд хөрөнгө итгэмжлэн удирдуулах, итгэмжлэгдсэн өмч (траст-trust) хоёр хоорондоо ихээхэн ялгаатай ойлголт гэж зохиогч үзэж байна. Энэ талаар Оросын Холбооны Улсын хэвлэлд дурьдсан зүйлийг үндэслэлтэй гэж бодож байна. ОХУ-ын нилээд орчин үеийн гэгдэж байгаа Иргэний эрх зүйн сурах бичигт⁸ ОХУ-ын Иргэний хуульд заасан хөрөнгө итгэмжлэн удирдуулах, итгэмжилсэн өмч (траст) гэсэн институтууд нийтлэг зүйлгүй, огт өөр агуулгатай гэдгийг дурьдаад эд хөрөнгө итгэмжлэн удирдахад уг этгээд бусдын эд хөрөнгийг өмчлөгчийн ашиг сонирхлын үүднээс ашигладаг бөгөөд эд хөрөнгийн өмчлөгч болдоггүй. Гэхдээ эд хөрөнгө итгэмжлэн удирдаж буй этгээд нь уг эд хөрөнгийг гэрээний дагуу эзэмших, ашиглах, захиран зарцуулах боломжтой байдаг.

Харин итгэмжилсэн өмч нь (траст) итгэмжлэгч болох өмчлөгч нь нөгөө тал итгэмжлүүлэгчдээ эд хөрөнгийн гүйлгээнд өмчлөгчийн үүрэг гүйцэтгэх эрх олгож, итгэмжлэгчийн ашиг сонирхлын үүднээс ажиллаж, итгэмжилсэн хөрөнгөөс олсон ашгийг итгэмжлэгчид өгөх үүрэг хүлээлгэдэг нарийн тогтолцоотой харилцаа юм.

Ингэхдээ итгэмжлэгч, итгэмжлэгдсэн өмчлөгч өмчлөгчийн онцгой эрхийг хэрэгжүүлж, аль аль нь өмчийн эрхийн субъект болдог. Үүний гол агуулга нь итгэмжлэгч нь итгэмжлүүлэгчдээ “шудрага ёсны сэтгэлгээнд” тулгуурлан дээд зэргээр итгэл үзүүлдэгт оршдог гэж үздэг. Шудрага ёсны сэтгэлгээ нь Англи-Америкийн эрх зүйн тогтолцооны эрх зүйн шудрага ёсны эс ширхэг бүрээр нэгэнт боловсрогдсон зүйл юм.

Гэтэл ийм ойлголтыг эх газрын эрх зүйд хэрэглэж байгаагүй.

Трастыг эх газрын эрх зүйн үүднээс үзвэл ойлгомжгүй байдал үүсч байна. Трастын оролцогч бүр өмчлөгчийн онцгой эрхийг ямар нэг хэмжээгээр хувааж эдэлдэг тул өмчийн эрхийн нэгдмэл байдал алдагдаж трастын өмчлөгч нь хэн болохыг тогтооход бэрхшээлтэй болно. Харин ийм байдал нь Англи-Америкийн иргэний эрх зүйн тогтолцоонд зөрчилгүй гэдэг нь тодорхой. Энэ тогтолцооны дагуу бол өмчийн эрх нь хуваагдмал байж болох бөгөөд субъект бүр өмчийн аль нэг эрхийг эдэлж тухайн харилцааны субъект болж байдаг.

Манай иргэний эрх зүйн тогтолцоонд нэг эд хөрөнгөд хоёр өмчийн эрх байж

⁷ Иргэний шинэ хуульд “эд хөрөнгийг бусдын удирдлагад шилжүүлэх” гэсэн нэр томьёо хэрэглэсэн. Тухайлбал, Иргэний хуулийн 181-р зүйлийн 1 дэх хэсэгт шүүх эд хөрөнгийг бусдын удирдлагад шилжүүлэхээр шийдвэрлэж болох тухай заасан

⁸ Гражданское право, Учебник. Том 1. Издат. БЕК., 1998, Ответственный редактор-доктор юридических наук, профессор Е. А. Суханов, Москва. 490 дэх тал

болохгүй бөгөөд өмчийн эрх нь эсхүл өмчлөгчид бүрэн хадгалагдах, эсхүл өмчлөгч уг эрхийг бүрэн алддаг. Энэ нь өмчлөгч өөрийн үзэмжээр эд хөрөнгөө захиран зарцуулах урьдчилсан нөхцөл болдог. Ингэснээр өмчийн эрхийн хэрэгжилтэд ямар нэг зөрчил үүсэхгүй.

Харин хөрөнгө итгэмжлэн удирдуулахад итгэмжлэгч өмчийн эрхээ алдахгүй. Эд хөрөнгөө шилжүүлж байгаа нь эд хөрөнгөө захиран зарцуулж буй нэг арга гэж хэлж болно.

Итгэмжлэгдсэн өмчийн эрх зүйн зохицуулалтыг бий болгох оролдлого ОХУ-д гарч байсан юм. Итгэмжилсэн өмч (траст)-ийг Ерөнхийлөгчийн зарлигаар (1993 он) бий болгож байсан боловч ОХУ-ын Иргэний шинэ хууль гарах үеэр энэ асуудал хуулиас хасагдсан байна.

ОХУ-ын нэртэй эрдэмтэд В.В.Лаптев, С.А.Хохлов болон Санкт-Петербургийн Их Сургуулийн эрдэмтэд А.А.Иванов, Д.А.Медведев нар Англи-Америкийн эрх зүйн тогтолцооны нэг институт болох трастыг эх газрын эрх зүйн тогтолцооны баримжаатай орос оронд эдийн баялгийн эрхэд механикаар суулгах нь үр дүнд хүрэхгүй гэж үзэж байсан бол хууль зүйн шинжлэх ухааны доктор, профессор Е.А.Сухановын ерөнхий редакцийн дор гарсан Иргэний эрх зүйн сурах бичигт трастыг өргөн хэрэглэх нь өмчлөгчийн эрх, ашиг сонирхолыг сахин хамгаалах баталгааг алдагдуулж, ялангуяа төрийн болон орон нутгийн өмчийг трастаар өргөнөөр шилжүүлбэл эдийн засагт сөрөг үр дагавар авчрах нь тодорхой гэж дурьджээ.⁹

Монгол улсын Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулиар үйлдвэрийн газрын үйл ажиллагааг удирдуулах арга замыг тодорхойлсон боловч энэ хуулиас Иргэний хууль илүү хүчин чадалтай тул Иргэний хуулийн 406-р зүйлийн заалтыг хэрэглэх давуу боломж харагдаж байна. Иргэний эрх зүйтэй холбогдолтой бусад хууль нь Үндсэн хууль, Иргэний хуульд нийцэж байх ёстойг хуульчлан тодорхойлсон нь бидний хөдөлбөргүй баримтлах зарчим гэж үзвэл трастыг хэрэглэх боломж байсаар байна гэж үзэх үндэстэй.

Итгэмжлэгдсэн өмчийн тухай асуудлыг манай хэвлэлд тэмдэглэсэн нь¹⁰ олзуурхууштай. Залуу судлаач, докторант Х. Оюунцэцэг: Итгэмжлэгдсэн өмчийн зарчмаас татгалзаж иргэний хуульд өмчлөгчийн эрхийг хязгаарлах зарчмыг тусгасан. Энэ нь эрх зүйн бүлийн Англи-Америкийн эрх зүйн бүлээс ялгагдах онолын ялгаа гэдгийг тэмдэглээд итгэмжлэгдсэн (доверительная собственность) өмчийн тухай асуудлын агуулгыг авч үзсэн байна.

Энэ асуудалтай холбогдсон бас нэг анхаармаар зүйл нь “Хөрөнгө итгэмжлэх тухай” 406-р зүйлийн байрлалын асуудал Иргэний хуулийн 406-р зүйлд: “Хөдлөх эд хөрөнгө, эрхийг итгэмжлэгдсэн өмчлөгчид шилжүүлэх, итгэмжлэгдсэн өмчлөгч нь итгэмжилсэн хөрөнгийг хүлээн авах... үүрэг хүлээнэ” гэж зааснаас үзэхэд энэ зүйлийг буруу хэсэгт байрлуулсан мэт. Энэ зүйл нь “Ажил гүйцэтгэх, туслалцаа үзүүлэхтэй холбогдсон үүрэг” гэсэн хэсэгт байрлаж байгаа нь Иргэний хуулийн системчлэлийн үндсэн зарчимд нийцэхгүй байна. Агуулгаар нь үзвэл, “Бусдын өмчлөлд хөрөнгө шилжүүлэхтэй холбогдсон гэрээний үүрэг” гэсэн хэсэгт ормоор

⁹ Гражданское право, Учебник. Том 1. Издат. БЕК., 1998, Ответственный редактор-доктор юридических наук, профессор Е. А. Суханов, Москва. 489-492 дахь тал

¹⁰ Х. Оюунцэцэг, Удирдлагын академийн ахлах багш, доторант, Бусдын газар дээр барилга байгууламж барих эрх. “Иргэний хууль /Шинэлэг зохицуулалт/”, УБ. 2003 он. 34-35 дахь тал

юм шиг санагдана. Өөрөөр хэлбэл хөрөнгө шилжүүлэх агуулгатай харагдаж байна гэх зэрэг асуудлууд үүсч байна.

Өмчийн эрхийн энэ чухал асуудлыг хөндсөнөөр итгэмжлэгдсэн өмчийн асуудлыг цаашид хэрэглэх ажилд ихээхэн болгоомжтой хандаж Иргэний хуулиар тодорхойлсон өмчийн эрх нь өмчлөгчид хэвээр хадгалагдаж эд хөрөнгийг удирдаж буй этгээд нь эдийн баялгийн хязгаарлагдмал буюу эзэмшлийн эрхтэй байна гэсэн дүгнэлт иргэний хуулийн агуулга болон манай иргэний эрх зүйн тогтолцооны мөн чанараас урган гарч байгааг онцлон тэмдэглэж байна.

Гэвч цаашид Монгол улсын иргэний хууль тогтоомжийг Үндсэн хууль, Иргэний хуулийн агуулга, чиг хандлага, Хүний эрхийг хангах үндэсний хөтөлбөрийн дагуу боловсронгуй болгох, ялангуяа өмчлөх эрхийг хангах чиглэлээр хянан үзэх хэрэгтэй байна.

Манай улсын иргэний хууль тогтоомжийг өмчийн эрхийн тэгш байдал, хууль тогтоомжид амь бөхтэй хадгалагдан үлдсээр байгаа өмчийн халдашгүй байдалд харш, өмчийн эрхийг хэрэгжүүлэхэд учирч буй аливаа үндэслэл муутай хорио цээрийг арилгах, өмчийн эрхийг хангах эрх зүйн хамгаалалтыг хүчтэй болгох чиглэлээр хянан үзэж тодорхой арга хэмжээ авах шаардлагатай гэж үзэж байна.

Монгол улсын Их хурлаас 2003 оны 41-р хурлаараа баталсан “Монгол улсад хүний эрхийг хангах үндэсний хөтөлбөр”¹¹-т өмчлөх эрхийг хангах талаар тусгай бүлэг орсон нь уг асуудал ихээхэн ярвигтай, анхаарал татаж байдгийг харуулж байна. Дээрх хөтөлбөрийн 2, 3, 1, 5-д “Өмчлөгчийн эрхийг хягаарласан шинжтэй төрийн захиргааны төв, орон нутгийн байгууллага, албан тушаалтны гаргасан шийдвэрийг хянан үзэж зөрчлийг арилгаж байх арга хэмжээ тогтмол авч, шүүхийн шийдвэргүйгээр иргэдийн эд хөрөнгийг хураадаг, устгадаг, өмчлөгчийн зөвшөөрөлгүйгээр өр зээлд дур мэдэн сонгож, үнэлж авах, иргэдийн эд хөрөнгө эзэмших болон ашиглах эрхийг хууль бусаар хязгаарлах зэрэг ноцтой зөрчлийг арилгах, сэргийлэх арга хэмжээ авна” гэж заажээ.

Уг хөтөлбөрийн өмчлөх эрхийг хангах тухай заалтыг хэрэгжүүлэх ажлыг Улсын Их Хурлаас эхлэх ёстой болов уу. Жишээлбэл, Иргэний хууль, Хоршооны хууль, Газрын тухай хууль зэрэг хуулиудын өмчийн эрхийн тэгш байдал, халдашгүй байдлыг алдагдуулсан заалтыг өөрчлөх, хүчингүй болгох шаардлага зүй ёсоор тавигдаж байгаа нь энэ хэсэгт дурьдсан баримтаас харагдаж байгааг хууль тогтоогчдынхоо анхааралд толилуулж байна.

Дөрөвдүгээрт. Монгол улсын хууль тогтоомж нь Монгол улсын Иргэний шинэ хуулийн агуулга, зарчимд бүрнээ нийцэж байх ёстой. Гэтэл Монгол улсын Иргэний хууль батлагдаад 2 жил шахам хугацаа өнгөрч байгаа боловч Иргэний хуулийн үндсэн зарчим, агуулгад харшилсан бусад зарим хуулийн заалт засаж залруулагдахгүй байгаа нь хачирхал төрүүлж байна. Тухайлбал, Хоршооны тухай хуулийн 48-р зүйлд “Хоршооны үйл ажиллагаа дуусгавар болоход хуваах боломжгүй үлдэгдэл хөрөнгийг тодорхой зориулалтаар хэрэгжүүлэхийг хоршооны дүрэмд тусган заагаагүй бол уг хөрөнгийг нийтийн хэрэгцээнд зориулан ашиглуулахаар хоршооны төв оршиж байсан нийслэл, аймаг, сум, дүүргийн өмчид

¹¹ Төрийн мэдээлэл, УБ. 2003 он. Монгол улсад Хүний эрхийг хангах үндэсний хөтөлбөр. 942/327/, 910-932 дахь тал

шилжүүлнэ” гэсэн заалт амь бөхтэй хадгалагдсан хэвээр байна. Энэ заалт Иргэний хуулийн 1-р зүйлийн “Иргэний эрх зүйн харилцаанд оролцогчдын өмчийн халдашгүй байдлыг” хамгаалах нь иргэний хууль тогтоомжийн үндсэн зарчим гэсэн заалтад харшилж байна. Монгол улсын Иргэний хууль 2002 оны 1-р сарын 20-нд батлагдсанаас хойш 2002 оны 12-р сарын 12-нд Улсын Их Хурлаас Хоршооны тухай хуульд томоохон нэмэлт, өөрчлөлт оруулсан¹² боловч дээрх заалт хэвээр үлдсэн байна. Ингээд үзэхээр энэ нь хууль тогтоомжийг Иргэний шинэ хуульд нийцүүлэх ажил хангалтгүй байгааг харуулж байна.

Хоршооны тухай хуулийн 48-р зүйлийн энэ заалтыг Улсын Дээд Шүүхийн 2000 оны 1-р сарын 29-ний 02-р тогтоолоор тайлбарлахдаа “хуваах боломжгүй үлдэгдэл мөнгө” гэж хуульд байхгүй нэр томъёо хэрэглээд (мөнгө хуваагдахгүй гэсэн ойлголт байж болмооргүй), хоршооны үйл ажиллагаа дуусгавар болоход түүний хөрөнгөнөөс үлдсэн мөнгөн болон биет байдлаар гишүүдэд хуваан олгох боломжгүй хөрөнгө болон эд хөрөнгийн эрх хамаарах бөгөөд түүнийг тодорхой зориулалтаар шилжүүлэх талаар хоршооны дүрэмд заагаагүй бол хоршооны төв оршиж байсан нийслэл, аймаг, сум, дүүргийн (орон нутгийн) өмчид шилжүүлэхийг хамааруулна¹³ гэжээ.

Тавдугаарг. Газрын тухай хуульд иргэний хувийн өмчийн холбогдолтой зарим нэг эгзэгтэй асуудал байгаа нь зохиогчийн сонирхолыг зүй ёсоор татаж байна. Энэ нь газар дээр дур мэдэн барилга, байгууламж барьсан асуудлыг шийдвэрлэх арга замын тухай асуудал юм.

Төрийн өмчийн газар дээр дур мэдэн барилга, байгууламж барих, хашаа хатгаж буух зэрэг хууль бус үйлдэл нийслэл хотод цөөнгүй гарч байгаа нь Иргэний болон Газрын тухай хуулийг ноцтой зөрчиж байгаа, бас ч нилээдгүй хор уршигтай үйл ажиллагаа гэдэг нь нэн ойлгомжтой хэрэг.

Газрыг Монгол улсын иргэнд өмчлүүлэх болсноор энэ асуудал улам ч хурцаар тавигдах болсон билээ. Тийм учраас Газрын тухай хууль, Монгол улсын иргэнд газар өмчлүүлэх тухай хууль зэрэг сүүлийн үед гарсан зарим хуульд газрын харилцааны эрх зүйн зохицуулалт, хариуцлагын механизмыг сайжруулахад нилээд анхаарч байгааг ажиглаж болно. Энэ бүхэн нь зах зээлийн өнөөгийн нөхцөлд газар эзэмшин, ашиглах, өмчлөх нийгмийн харилцааны үндсэн асуудлын нэг нэгэнт болсныг харуулж байгаа юм.

Газрын тухай хуульд иргэд газар дээр зохих зөвшөөрөлгүйгээр барилга, байгууламж барьсан, эсхүл бусад хэлбэрээр түүнийг дур мэдэн эзэмшсэн бол аймаг, нийслэл, сум, дүүргийн Засаг дарга уг газрыг чөлөөлөх тухай хугацаатай мэдэгдэл өгч, түүнд заасан хугацаанд газрыг чөлөөлөөгүй бол аймаг, нийслэл, сум, дүүргийн Засаг дарга уг газрыг чөлөөлүүлэх арга хэмжээ авч, холбогдох зардлыг буруутай этгээдээс гаргуулна гэж Газрын тухай хуулийн 57-р зүйлийн 4 дэх хэсэгт заажээ. Уг хуулийн 59-р зүйлд газар чөлөөлөх, албадан нүүлгэх тухай Засаг даргын шийдвэрийг Цагдаагийн байгууллагын хүчээр гүйцэтгэх боломжийг тодорхойлжээ. Энэ бүгдээс үзэхэд газар албадан чөлөөлүүлэх, албадан нүүлгэх боломжийн механизм бүрдсэн байна.

¹² Төрийн мэдээлэл, УБ. 2002 он. 48 /285/, 1451-1453 дахь тал

¹³ Төрийн мэдээлэл, УБ. 2000 он. 14 /151/, 322 дахь тал

Гэвч Газрын тухай хуулийн 57-р зүйлийн 5 дахь хэсэгт дээрх журмаар буюу “газрын тухай хуулийн 4 дэх хэсэгт зааснаар газрыг чөлөөлөөгүй бол уг барилга, байгууламжийг шаардлагатай гэж үзвэл төрийн өмчлөлд үнэ төлбөргүй шилжүүлнэ” гэж заажээ. Энэ заалт нь урьдах хэсэгтэйгээ давхардсан шинжтэй, ихээхэн ерөнхий, тодорхой бус байгаагаас гадна дараах онцлон анхаармаар асуудал үүсч байна.

Үүнд: *Нэгдүгээрт*, Иргэний хувийн өмчийн үл хөдлөх хөрөнгө барилга, байгууламжийг захиргааны журмаар, үнэ төлбөргүй төрийн өмчлөлд хураан авч байна. Захиргааны журмаар эд хөрөнгө хураах явдал нилээд байгаа нь иргэдийн эрх зөрчигдөх нэг шалтгаан болсон байна.¹⁴ Өнөөдөр Монгол оронд бүрдэж буй эрх зүйн боловсруулалт, чиглэл иргэдийн өмчийг шүүхийн шийдвэргүйгээр төрийн өмчлөлд хураан авах аргаас татгалзаж байгаа билээ. Энэ нь ч өмчийн эрх нь хүний эрхийн үндсэн хэсгийн нэг гэсэн агуулгаар үзэж байгаатай холбоотой.

Монгол улсад Хүний эрхийг хангах үндэсний хөтөлбөрт¹⁵: “Шүүхийн шийдвэргүйгээр иргэдийн эд хөрөнгийг хураадаг, устгадаг, иргэдийн эд хөрөнгө эзэмших болон ашиглах эрхийг хууль бусаар хязгаарлах зэрэг ноцтой зөрчлийг арилгах, сэргийлэх арга хэмжээ авна гэж заасан байна. Иргэний эд хөрөнгийг шүүхийн шийдвэргүйгээр төрийн өмчлөлд хураан авч байгаа нь иргэн эрхээ шүүхээр хамгаалуулах зарчимд харшилж байна. Иргэний хуулийн 1-р зүйлд иргэний хууль тогтоомж нь эрхээ “шүүхээр хамгаалуулах зарчимд үндэслэнэ” гэж заажээ. Газрын тухай хуулийн хувийн өмчийг төрийн өмчлөлд хураан авах тухай заалт яахын ч аргагүй иргэний хууль тогтоомж мөн.

Хоёрдугаарт, Иргэн төрийн өмчийн газар дээр дур мэдэн барилга, байгууламж барьсан гэж засаг дарга үзвэл газар чөлөөлөх тухай мэдэгдэл өгөөд чөлөөлөөгүй тохиолдолд газрыг албадан чөлөөлөх арга хэмжээг авч хэрэгжүүлэх, эсхүл уг барилга, байгууламжийг төрийн өмчлөлд хураан авах шийдвэрийн алийг гаргах вэ гэдэг нь үндсэндээ Засаг даргын үзэмжээр шийдвэрлэгдэх болж байна. Газрыг мэдэгдэлд заасан хугацаанд чөлөөлөөгүй бөгөөд Засаг дарга “шаардлагатай гэж үзвэл” зөвшөөрөлгүй барьсан барилга, байгууламжийг төрийн өмчлөлд үнэ төлбөргүй хураан авах шийдвэр гаргах боломжтой болж байна.

“Шаардлагатай гэж үзвэл” гэсэн нэр томьёо, илэрхийлэл нь чухам ямар үндэслэл байх, Засаг дарга эхлээд газрыг албадан чөлөөлөх арга хэмжээг авах ёстой юу гэх зэрэг иргэд төдийгүй хуульч бидний хувьд ойлгомжгүй асуудлууд үүсч байна.

Ийм ноцтой үр дагавартай хэм хэмжээ тогтоогоод түүний талаар шүүхэд гомдол гаргах эрх ч нэр заагдаж ороогүй байна. Эдгээрээс үзэхээр энэ заалтын хувьд мэргэжлийн боловсруулалт, хандлага илтэд дутагдаж байна, зохиогчийн бодлоор иймэрхүү, ноцтой асуудалыг Иргэний хуульд заасан бол илүү нарийвчлалтай, тодорхой үндэслэлтэй, гомдол гаргах журам зэрэг хууль зүйн зайлшгүй зохицуулагдах асуудлыг тусгах арга барил талаасаа зохистой байсан болов уу.

“Амьдралаас яах аргагүй урган гарч байгаа зарим хэм хэмжээ дутагдалтай мэт, тухайлбал дур мэдэн барьсан байшин, хашааг албадан буулгах, газрыг хураан

¹⁴ Төрийн мэдээлэл, УБ. 2002 он. №38 /275/, 1235 дахь тал

¹⁵ Төрийн мэдээлэл, УБ. 2003 он. № 42 /327/

авах зэрэгтэй холбогдсон хэм хэмжээг Иргэний хуульд заасан бол өнөөдөр газарлуугаа улайран дайрч зөвшөөрөлгүй эзэмшиж байгаа нөхцөлд хэрэгтэй байсан”¹⁶.

Цаашид дээрх заалтыг хянан үзэж боловсронгуй болгох зүй ёсны шаардлага байгаа нь өмчийн эрхийг хангах нэг чухал асуудал гэж үзэж байна. Хүний Эрхийн Түгээмэл Тунхаглалын 17-р зүйлд: “хэний ч эд хөрөнгийг хувьдаа хураан авч болохгүй” гэж заасныг сануулахад илүүдэх юун.

Ийнхүү Иргэний шинэ хуулийн агуулга, үзэл баримтлалд нийцүүлэн гаргаж байгаа гэх зарим шинэ хуулийн заалт нь Монгол улс хүний эрхийн талаар баримталж байгаа байдалтай зэрэгцүүлбэл гарцаагүй ухралт гэж хэлж болно.

Өмнө нь нэгэнт батлагдаад хэрэгжиж буй хуультайгаа засаг төрийн бодлогоо нийцүүлэхийн оронд явуулж буй бодлогодоо нийцүүлэн хуулийг өөрчилж буй нь анхаарал татаж байна. Үүний улмаас нэгэнт олсон амжилтын түвшин болон хүний эрхийн байдлыг дордуулах явдал ажиглагдаж байна¹⁷, гэж Монгол Улсын Хүний Эрхийн Комиссын 2003 оны “Монгол улс дахь хүний эрх, эрх чөлөөний тухай илтгэл”-д дурьдсантай зохиогч санал нэг байгаагаа илэрхийлж байна.

¹⁶ О. Жамбалдорж, Монгол улсын Иргэний эрх зүй /ерөнхий үндэслэл/, 1-р дэвтэр, 2004 он. 43 дахь тал

¹⁷ Төрийн мэдээлэл, УБ. 2003 он. № 15 /300/

ХҮНИЙ ЭКОЛОГИЙН ЭРХ БА АГААРЫН БОХИРДОЛ

П.Оюунтунгалаг,
Цагдаагийн Академийн захиргааны
эрх зүйн тэнхмийн багш, магистр

Байгаль орчин /хүрээлэн буй орчин нь/ хүн өөрийн үндсэн эрх болох амьд байх, эрүүл мэндээ хамгаалуулах, хангалттай хоол хүнстэй байх, орон байртай байх болон аж амьдралыг тэтгэхэд хүрэлцэхүйц амьжиргаатай байх эрхээ эдлэх нийтлэг нөхцөл нь болдог билээ. Тиймээс өнөөдөр байгаль орчинд хохирол учруулах, бохирдуулах явдал нь зөвхөн байгаль орчны бус хүний эрхийн эсрэг гэмт хэрэг үйлдэж байна гэдгийг ухаарах цаг болжээ.

Хүн өөрөө байгалийн бүтээгдхүүн тул байгальгүйгээр хүнийг, тэр тусмаа агааргүйгээр төсөөлшгүй. Тиймээс өнөөдрийн бидний хөндөж буй асуудал болох агаарын бохирдлын талаархи аливаа улс орны төрийн бодлогын цөмд орших нь ойлгомжтой.

Хүний экологийн эрх нь шим мандалд амьдарч буй хүн төрөлхтөнд түгээмэл байдлаар олгогдсон чөлөөт боломж билээ. Хүний экологийн эрх гэдгийг өргөн утгаар нь тодорхойлохдоо байгаль орчинтой харилцан нягт уялдан бий болдог хүний төрөл бүрийн хэрэгцээг хангаж хамгаалахын тулд хүний эдлэх эрхийг үндэсний болон олон улсын эрх зүйн тогтолцоонд хүлээн зөвшөөрч баталгаажуулсан шинж байдал мөн хэмээн тодорхойлжээ.¹

Энэхүү эрхийн агуулгын хувьд үндсэн ба бусад эрх хэмээн ангилж үндсэн эрхэд эрүүл аюулгүй орчинд амьдрах эрхийг, бусад эрхэд гэм буруутай этгээд байгаль орчинд хортой нөлөөлснөөс учирсан хохирлыг нөхөн төлүүлэхээр нэхэмжлэх, байгаль орчинд хохирол учруулсан этгээдэд хариуцлага хүлээлгэхийг шаардах, байгаль орчинд хортой нөлөөлөх аливаа үйл ажиллагааг хязгаарлах, таслан зогсоох шийдвэр гаргахыг эрх бүхий байгууллагаас шаардах, байгаль орчны тухай үнэн зөв мэдээллээр хангагдах гэсэн эрхүүдийг хамааруулжээ.²

Хүний экологийн үндсэн эрх нь 20-р зууны сүүлийн хагасаас дэлхий нийтээр хүлээн зөвшөөрөгдөж, олон улсын төдийгүй улс үндэстний дотоодын хууль тогтоомжид бэхжигдэн баталгаажих болсоор даруй хэдэн арван жил болжээ.

Энэ нь хүн төрөлхтөн өөрийн оршин буй байгаль орчинд бий болсон сөрөг өөрчлөлтүүдийг мэдрэх, түүнээс урьдчилан сэргийлэх, түүнд зохистой хандах, нөгөө талаар энэ хүрээн дэх олон улсын хамтын ажиллагааг бэхжүүлэхийн чухлыг ухаарсантай холбоотой юм. Тухайлбал, Олон улсын хүний эрхийн анхны баримт бичгүүд болох “Хүний эрхийн түгээмэл тунхаглал” /1948/, “Эдийн Засаг Нийгэм Соёлын Эрхийн Тухай Олон Улсын Пакт” /1966/-ын агуулгаас үзвэл /хэдийгээр экологийн үндсэн эрхийг шууд нэрлэн заагаагүй ч/ хүний экологийн эрхэд

¹ О.Амархүү, “Монголын орчин цагийн экологийн эрх зүй”, УБ, 2004, 144-р тал

² Т.Сэнгэдорж, “Экологийн эрх зүй” УБ, 2001 он, 60-р тал

хамаарах “хүн бүр амьд явах эрхтэй”, “хүн бүр хуулийн өмнө тэгш бөгөөд ямар ч ялгаваргүйгээр хуулиар адилхан хамгаалуулах эрхтэй”, “Үндсэн хууль, бусад хуулиар олгогдсон эрх нь зөрчигдвөл хүн бүр эрх мэдэл бүхий үндэсний шүүхээр эрхээ бүрэн сэргээн тогтоолгох эрхтэй” гэсэн эрхүүдийг тунхагласан юм. Мөн “Эдийн засаг нийгэм соёлын эрхийн тухай олон улсын пакт”-д/12-р зүйл/ “Орчны эрүүл ахуйг бүх талаар сайжруулна” хэмээн заажээ.

1972 онд Стокгольм хотноо хуралдсан “Хүрээлэн буй орчин” бага хурлаас гаргасан Зарчмын тунхаглал /Декларация принципов/-д анх удаа олон улсын хэмжээнд “Хүн эрүүл аюулгүй орчинд амьдрах эрх”-тэй болохыг тунхагласан билээ.

Улмаар 1992 онд Бразилийн Рио-Де-Жанейро хотноо болсон НҮБ-ын “Хүрээлэн буй орчин” бага хурлаас гаргасан тунхаглалд: байгаль орчны тэнцвэрт байдал нь тогтвортой хөгжлийн тулгуур мөн болохыг дурдаад “Тогтвортой хөгжил гэдэг нь нийгмийн хөгжлийг тасралтгүй хангахад чиглэгдсэн, байгаль орчны даац чадавхид нийцсэн нийгэм, эдийн засгийн хөгжил юм” гэжээ.³

Тиймээс дэлхий улс орны хөгжлийн түвшинг зөвхөн эдийн засгийн өсөлтөөр хэмждэг хандлагаас хүн, байгаль орчин, нийгмийн хүчин зүйлсийн харилцан хамааралд нь авч үзэх тогтвортой хөгжлийн шинэ хандлага буюу экологийн баримжаат хөгжил рүү шилжиж буй үед Монгол улс ч дээрхи түгээмэл хандлагын дагуу тогтвортой хөгжлийн замыг сонгосон билээ.

Энэхүү хөгжлийн гол үзэл баримтлалыг хүний эрүүл аюулгүй орчинд амьдрах эрхийг хангах, мөн хүн ардынхаа сайн сайхан амьдралыг байгаль орчны даацад нийцүүлэн хангах явдлыг үндэсний хууль тогтоомжоор баталгаажуулахын хамт байгалийн нөөц баялгаа шавхалгүйгээр байгаль орчноо унаган төрхөөр нь хойч үедээ өвлүүлэн үлдээх зарчмыг удирдлага болгон улс орныхоо нийгэм эдийн засгийн эрчимтэй хөгжлийг хангах явдал хэмээн ойлгож байна. Энэ нь ч Рио-Де-Жанейрогийн тунхаглалын 1-р зарчимд дурьдсан “Тогтвортой хөгжлийг хангах чармайлтын цөм нь хүний төлөө тавих анхаарал байна. Хүн байгальтайгаа зохицон эрүүл бөгөөд үр бүтээлтэй амьдрах эрхтэй” гэснээр баталгаажиж байна.

Манай улсын хувьд 1992 онд батлагдсан Үндсэн хуульдаа “Монгол улсын иргэн нь эрүүл, аюулгүй орчинд амьдрах, орчны бохирдол, байгалийн тэнцэл алдагдахаас хамгаалуулах эрхтэй”, “Байгаль орчноо хамгаалах нь Монгол улсын иргэний журамт үүрэг мөн” хэмээн иргэний экологийн эрх, үүргийг анх удаа төрийн хуулийн хэмжээнд тодорхойлсон нь шинэ асуудал юм.

Төрийн чиг үүргийн нэг бие даасан функц нь экологийн чиг үүрэг мөн болохыг, энэ нь хүний эрүүл аюулгүй амьдрах эрхийг хангах зорилгоор байгаль орчинд хортой нөлөөлөхөөс болон байгаль орчны тэнцвэр алдагдахаас сэргийлэн хамгаалах байдлаар тодорхойлогдоно хэмээн үзжээ.

“Монгол улсын үндэсний аюулгүй байдлын үзэл баримтлал”-д экологийн аюулгүй байдлыг Үндэсний аюулгүй байдлын салшгүй хэсэг болгон авч үзэж, түүнд нөлөөлөх гадаад, дотоод хүчин зүйл, урьдчилан сэргийлэх арга замыг тодорхойлсон байна. Түүнчлэн “Монгол улсад хүний эрхийг хангах хөтөлбөр”-ийг 2003 онд Улсын Их Хурлаас баталж, хүний эрүүл аюулгүй орчинд амьдрах эрхийг хангах талаар тодорхой зорилтуудыг дэвшүүлжээ.

³ Анисимов.А.П. “Экологическое право России”, учебное пособие, М-2003. стр 37

1995 онд батлагдсан “Байгаль орчныг хамгаалах тухай хууль” байгалийн нөөцийг ашиглах, хамгаалах нөхөн сэргээхтэй холбогдсон бусад 20 гаруй хууль, тэдгээрийн хүрээнд батлагдан үйлчилж байна. Эдгээр нь бүхэлдээ иргэний экологийн эрхийг хангах, баталгаажуулах, мөн тэднээс экологийн үүргээ биелүүлэхтэй холбогдсон харилцааг зохицуулж байна.

Агаар нь хүн хийгээд аливаа амьд организмийн амьдралын зайлшгүй хэрэгцээ мөн бөгөөд байгалийн бусад объектод харьцуулахад барьцтай биш, урсгал хөдөлгөөнтэй, физик, химийн тодорхой шинжийг агуулж байдгаараа онцлог юм.

Энэхүү онцлог төрлийн байгалийн объектыг экологийн болон хүний үйл ажиллагааны сөрөг нөлөөлөөс хамгаалах, түүнээс урьдчилан сэргийлэх, улмаар хүний эрүүл аюулгүй орчинд амьдрах эрхийг хангахуйц нөхцлийг бүрдүүлэх зайлшгүй шаардлага зөвхөн нэг улс орны төдийгүй олон улсын хэмжээнд нэгэнт тулгамдсан асуудал болжээ.

Хүний амьдрах үйл ажиллагааны хэвийн нөхцлийг хангахад атмосферийн хэвийн найрлагатай агаар нь нэн чухал агаад агаарын хийн найрлага нь хүн амьтны оршин байгаа газрын гадаргад хамгийн ойр биосферийн давхаргад харьцангуй тогтмол байж, хүчилтөрөгч 20.95 хувь, азот 78.8 хувь, аргон 0.93 хувь, нүүрсхүчлийн хий 0.03 хувь, үлдэх 0.01 хувийг гелий, неон, криптон, азотын исэл гэх мэт идэвхигүй хийнүүд эзэлдэг байна.⁴

Агаарын цэвэр, бохир байгаа эсэхийг харьцуулах үзүүлэлт нь агаарт байхыг зөвшөөрсөн хортой бодисын зөвшөөрөгдөх дээд хэмжээ, физикийн хортой нөлөөний зөвшөөрөгдөх дээд хэмжээгээр тодорхойлогдох бөгөөд Монгол улсад хот суурин зэрэг хүн ам суурьшсан орчны агаарт байх химийн хортой бодисын зөвшөөрөгдөх дээд хэмжээг 340 гаруй бодис тогтоосноос гадна ажлын байрны бичил орчны агаарт 1300 гаруй химийн хортой бодист зөвшөөрөгдөх дээд хэмжээг тогтоон мөрдөж байна.

Сүүлийн 30 гаруй жилд Монгол улсад шинжлэх ухаан, техник технологи эрчимтэй хөгжиж, үйлдвэржүүлэлт, аж ахуй эрхлэлт, шилжилт хөдөлгөөн⁵ эрчимжиж, өнөөдөр нийслэл хотноо тус улсын нийт хүн амын 1/3 нь /924764/ төвлөрч, хүн амын 60-аас илүү хувь нь төвийн бүс нутагт оршин амьдрах болсноор байгаль орчинд үзүүлэх хортой нөлөөлөл улам бүр нэмэгдэхэд хүргэж байна. Иймд нийслэл хотын жишээн дээр агаарын бохирдолтын тоон үзүүлэлтийг авч үзэх нь зохимжтой гэж үзлээ.

Агаар бохирдуулах эх үүсвэрүүд улам бүр нэмэгдэж агаарын найрлагад нунтаг бодис, тоос, утаа, бусад хий, химийн хорт бодисоор өөрчлөлт оруулах, физик, химийн болон цацраг идэвхит бодисын хортой нөлөөлөл үзүүлэх, хэт өндөр давтамжтай дуу чимээ, доргион чичиргээн, соронзон урсгалаар нөлөөлөх нөлөөлөл зэргийг хамааруулах боловч “Байгаль орчны төлөв байдлын тайлан”-д тухайн эх үүсвэрийг:

- Дулааны цахилгаан станц
- Гэр хорооллын зуухны болон жижиг уурын зуухны дутуу шатсан утаа

⁴ Экологи. Ред.Д.Базардорж, УБ, 2002, 35-р тал

⁵ 1990 онд 562300

1995 онд 645800

1999 онд 760100

2000 онд 786500

- Автомашин ба бусад хөдөлгөөнт эх үүсвэр байна хэмээн дүгнэсэн байна.

Нийслэл хот дахь дулааны 3 дугаар станцаас жилд 62.000 тн агаар бохирдуулах бодис, өвлийн их ачаалалтай галлагааны үед цагт дунджаар 60 гаруй тонн үнсийг үнсэн санд, 4 тонн үнс, 4.5 шоо метр утаа, 6 кг хүхэрлэг хий агаарт цацагддаг байна.

Гэр хороолол нь хамрах талбайн хувьд ч хүрээлэн буй орчныг бохирдуулах нөлөөллийн хувьд ч нийслэл хотын агаарын бохирдлын томоохон эх үүсвэрийн тоонд орж байна.

Улаанбаатар хотод 92000 орчим айл өрх гэр хороололд амьдарч жилд 300000 орчим тонн нүүрс шатаадаг гэсэн судалгаа байдаг. Нэг тонн нүүрснээс 50 кг үнс, бусад бохирдуулах эх үүсвэр гардаг гэж үзвэл хэдий хэмжээгээр бохирдуулах нь ойлгомжтой байна.

Автомашин нь агаар бохирдуулагч бусад эх үүсвэрүүдтэй харьцуулахад нэгдүгээрт: жилээс жилд тоо нь өсөн нэмэгдэж байгаа, хоёрдугаарт: автомашины хөдөлгүүрээс ялгарах утааны найрлагад амьсгалын замын архаг өвчин үүсгэх, элэг, бөөр, уушгийг гэмтээх, зүрх судас, мэдрэлийн үйл ажиллагааг алдагдуулах, амьсгал боогдуулах, хорт хавдар үүсгэх үйлчилгээтэй CO, N₂O, CH, Pb, CO₂ гэх мэт 200 гаруй төрлийн хорт бодис агуулагдаж, эдгээр нь хүний амьсгалах түвшинд цацагдаж байдаг, гуравдугаарт: автомашин нь өөрөө хөдөлгөөнт эх үүсвэр тиймээс хорт хий тархах орон зайн хязгаар үгүй зэрэг онцлогтой юм.

Сүүлийн үед дэлхийн автомашины дийлэнх үйлдвэрийн гоёмсог загварын өндөр хүчин чадал, хуртай автомашинууд ихээр орж ирж байна. 2004 эхний 9 сарын байдлаар улсын хэмжээнд 154576 тээврийн хэрэгслэл, Улаанбаатар хотод 69614 тээврийн хэрэгслэл бүртгэгдсэн гэсэн тоон дүн байна. Үүнийг 1996 онтой харьцуулбал /1996 онд Улаанбаатар хотод 32623 тээврийн хэрэгслэл тоологдсон байна/ хотын тээврийн хэрэгслэлийн тоо 2 дахин нэмэгдсэн байна.

Гэвч эдгээр нь төр засгийн авто тээврийн бодлогоор зохицуулагдсан олон улсын стандартын шаардлага хангасан шинэ автомашин биш, хөрөнгө мөнгөний боломжид захирагдсан, гадаад улсад олон жил эдлэгдсэн, тухайн орны стандартын шаардлага хангахаа больсон хуучин автомашин зонхилж байна. Тухайлбал, тээврийн хэрэслүүдийг хэрэглэсэн жилийн байдлаар нь авч үзвэл 7-оос дээш жил ашигласан автомашин 60 гаруй хувийг эзэлж байна.

Түүнчлэн нийслэл хотын замын зохион байгуулалт нь өнөөгийн хөдөлгөөний ачаалал, шаардлагыг хангахгүй, оргил ачааллын үед зарим нь хаагдахад хүрч байна. Энэ тохиолдолд шатахуун зарцуулалтыг ихэсгэж, тэр хэмжээгээр агаарт зөвшөөрөгдөх хэмжээнээс илүү хорт бодис цацагддаг байна.

Дээрхи агаарын бохирдол нь хүний эрүүл мэндэд сөргөөр нөлөөлж, амьсгалын замын цочмог үрэвсэл, томуу, гуурсан хоолойн багтраа, сүрьеэ, хатгаа, харшил зэрэг өвчнөөр өвчлөх явдлыг улам бүр ихэсгэхэд хүргэж, улмаар зарим нь удамших хандлага ч сүүлийн жилүүдэд түгээмэл ажиглагдах болжээ." Агаар хамгаалах хөтөлбөр"-т 1999 оны байдлаар тэмдэглэсэнээр хүүхдийн амьсгалын замын өвчлөл 1980 оноос хойш 32 дахин, насанд хүрэгчдийнх 1.8 дахин ихэссэн хэмээн дурдсан байна. / хавсралт 1/

Агаарын бохирдлыг бууруулах мөн энэ талаар өнөөдөр бий болсон нөхцөл байдлаас гарах гарцыг эрэлхийлэх үүднээс дараахи саналыг дэвшүүлж байна.

- Агаарын бохирдолтой холбогдсон асуудлыг өнөөдөр Байгаль орчны яам, Эрүүл мэндийн яам, ЦЕГ болон холбогдох бусад байгууллагууд чиг үүргийнхээ хүрээнд хариуцан зохих үйл ажиллагаа явуулж байгаа боловч, үйл ажиллагааны уялдаа холбоо хангалтгүй, бие даасан шинжтэй байна. Иймд дээрхи байдалд дүн шинжилгээ хийж эрх олгогдсон байгууллагуудаас агаарын бохирдлыг бууруулах, хамгаалах, түүний төлөв байдлыг хадгалах үйл ажиллагааг “ нэг гарт” зангидах нь үр дүнтэй болов уу гэж үзэж байна.
- Бохирдуулагч нь бохирдуулсны хохирлыг хариуцах зарчмыг хэрэгжүүлэх хүрээнд “Агаар бохирдуулсны төлбөрийн тухай хууль”-ийг батлан гаргах шаардлагатай байна. Энэ нь нэг талаар иргэн, аж ахуйн нэгж байгууллага өөрийн экологийн үүргийг ухамсарлах, нөгөө талаар бохирдлоос хамгаалах, нөхөн эрүүлжүүлэх арга хэмжээг санхүүжүүлэх эдийн засгийн эх үүсвэрийг бүрдүүлэх юм.
- Бүсчилсэн хөгжлийн хөтөлбөрийн дагуу бүс нутгийн нийгэм эдийн засгийн амьдралыг сайжруулах замаар төвлөрлийг сааруулах, өөрөөр хэлбэл нийслэл хот руу урсах хөдөлгөөнийг оновчтой зохицуулах цэгцтэй бодлого үгүйлэгдэж байна.
- Байгаль орчныг хамгаалах чиглэлээр олон тооны төрийн бус байгууллагууд үйл ажиллагаагаа үр дүнтэй явуулж байгаа боловч агаарын бохирдлыг бууруулах, улмаар хүний эрүүл аюулгүй орчинд амьдрах эрхийг хангах, хамгаалах чиглэлээр дагнан үйл ажиллагаа явуулах төрийн бус байгууллагын оролцоог нэмэгдүүлэх, дэмжих
- Агаарын бохирдлыг бууруулахад энэ хүрээн дэх хяналт онцгой үүрэгтэй нь хэнд ч ойлгомжтой. Гэвч өнөөдөр хяналт бий болгох шалгуур байхгүй, байсан ч нэгдмэл бус байгаа нь үйл ажиллагааны нөлөөг бууруулж байна. Иймд хяналтын механизмыг боловсронгуй болгох нь зүйтэй юм.
- Эрдэмтэн судлаачид болон мэргэжлийн байгууллагын тусламжтайгаар тодорхой судалгаа, шинжилгээнд үндэслэн хот байгуулалтыг оновчтой болгох

ХҮНИЙ ЭРХ 2005/1

Хавсралт 1

Амьсгалын тогтолцооны өвчний шалтгаант нас баралт /0-15 нас/

Өвчний нэр	1999	2000	2001	2002	2003
Амьсгалын тогтолцооны өвчин	1150	858	730	672	485
Амьсгалын дээд замын цочмог халдвар	101	35	67	13	29
Уушигны хатгалгаа	930	762	580	609	433
Архаг бронхит	1	0	1	5	5
Амьсгалын тогтолцооны бусад өвчин	118	61	82	45	18

Нас баралтыг тохиолдлын тоогоор авсан болно.

Мэдээллийн эх сурвалж:- ЭТУГ, Статистик мэдээллийн алба

Эрүүл мэнд статистикийн мэдээлэл /1999-2003/

Амьсгалын тогтолцооны өвчлөл /0-15 нас/

Өвчний нэр	1999	2000	2001	2002	2003
Амьсгалын тогтолцооны өвчин	130496	119714	115978	126389	144812
Амьсгалын дээд замын цочмог халдвар	49205	43299	43124	51176	54385
Томуу	15398	11812	14679	13225	23052
Уушигны хатгалгаа	36010	40611	33902	34268	38039
Хурц бронхит	1435	9566	12853	15011	16385
Бронхэктази	132	85	66	45	55
Амьсгалын тогтолцооны бусад өвчин	28316	14341	11354	12664	12896

Мэдээллийн эх сурвалж:- ЭТУГ, Статистик мэдээллийн алба

Эрүүл мэнд статистикийн мэдээлэл /1999-2003/

Саяхан «Төрийн мэдээлэл» сэтгүүлийн хоёр ч тусгай дугаарт олон улсын гэрээ конвенцийг хэвлэсэн нь олон нийтийн анхаарлыг зүй ёсоор татаж байна. Үүнтэй холбогдуулан тус сэтгүүлийн редакцияас Гадаад Хэргийн Яамны Гэрээ, Эрх зүйн газрын захирал, доктор Б.Алтангэрэлээс доорх ярилцлагыг авснаа уншигчиддаа танилцуулж байна.

1. Асуулт: 2004 оны сүүлч, энэ оны эхээр «Төрийн мэдээлэл» сэтгүүлийн тусгай хоёр дугаарт Монгол улсын олон улсын гэрээнүүдийг эмхтгэн хэвлэсэн байна. Иймд яагаад ийм тусгай дугаар гарах болов, заавал яагаад «Төрийн мэдээлэл» сэтгүүлд хэвлэж байгаа талаар яриагаа эхлэх үү?

Хариулт: Монгол Улсын нэгдэж орсон олон талт гэрээг 2004 оны сүүлээс эхлэн «Төрийн мэдээлэл» сэтгүүлийн тусгай дугаар болгон гаргах болсон. «Төрийн мэдээлэл» сэтгүүлийн 1 дугаар тусгай дугаарт Монгол Улсын нэгдэж орсон хүний эрхийн олон талт гэрээ, 2 дугаар тусгай дугаарт Нэгдсэн Үндэстний Байгууллагын дүрэм, Олон улсын гэрээний тухай, Дипломат харилцааны тухай, Консулын харилцааны тухай гэх мэт олон талт гэрээ орсон байгаа бөгөөд 3 дугаар ботийг хэвлүүлэх ажилдаа ороод байна. Өмнө нь «Төрийн мэдээлэл» сэтгүүлд Монгол Улсын нэгдэж орсон олон талт гэрээг бус зөвхөн соёрхон баталсан тухай хуулийг нийтэлдэг байсан. Мөн манайд олон улсын олон талт гэрээг янз бүрийн эмхтгэлд хэвлэсэн тохиолдол нэлээд бий. Гэвч тэдгээр нь «Төрийн мэдээлэл» сэтгүүлд хэвлэгдээгүй учир албан ёсны болж чадаагүй юм. Олон улсын аливаа гэрээний албан ёсны орчуулга «Төрийн мэдээлэл» сэтгүүлд хэвлэгдсэнээр хуулийн хүчинтэй болж тэдгээрийг дотоодын хуулийн нэгэн адил шүүх, прокурор, өмгөөлөх зэрэг хуулийн байгууллага хэрэглэх боломжтой болж байгаа юм. «Төрийн мэдээлэл» сэтгүүл бол хуулийн албан ёсны хэвлэл учраас олон улсын гэрээг уг сэтгүүлд хэвлэснээр албан ёсны болж буй хэрэг.

2. Асуулт: Олон улсын энэ гэрээнүүд өмнө нь нийтлэгдэж л байсан, одоо албан ёсоор нийтлэгдлээ, үүний ялгаа болон давуу тал нь юу байж болох вэ?

Хариулт: Олон улсын гэрээний орчуулгыг гадаад хэргийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллага хариуцан гүйцэтгэнэ гэж Хууль, Улсын Их Хурлын бусад шийдвэрийн төсөл боловсруулах, өргөн мэдүүлэх журмын тухай хуулинд заасан байдаг. Энэ утгаараа Монгол Улсын нэгдэж орсон олон талт гэрээний албан ёсны орчуулгыг дахин ёсчлон гүйцэтгэж, орчуулгыг хянан сайжруулж «Төрийн мэдээлэл» сэтгүүлд нийтлүүлж буй нь хуулийн хэмжээний хүчин чадалтай болгож буйгаараа давуу талтай боллоо гэж үзэж байна.

3. Асуулт: Монгол улсын Үндсэн хуульд: «Монгол Улсын олон улсын гэрээ нь соёрхон баталсан буюу нэгдэн орсон тухай хууль хүчин төгөлдөр болмогц дотоодын хууль тогтоомжийн нэгэн адил үйлчилнэ» гэж заасан тэгэхээр олон улсын гэрээг хууль гэж үзэж болох уу?

Хариулт: Олон улсын гэрээг Монгол Улсын Үндсэн хуульд заасан гадаад бодлогын зорилго, зарчмыг үндэс болгон олон улсын эрх зүйн нийтээр хүлээн зөвшөөрсөн зарчим, хэм хэмжээнд нийцүүлэн байгуулдаг. Энэхүү зүйлд харилцахгүй олон талт гэрээнд Монгол Улс нэгдэн орж олон улсын эрх зүйгээр хүлээсэн үүргээ шударгаар сахин биелүүлдэг. Монгол Улсын олон улсын гэрээ нь соёрхон баталсан буюу нэгдэн орсон тухай хууль хүчин төгөлдөр болмогц дотоодын хууль тогтоомжийн нэгэн адил үйлчилнэ гэж Үндсэн хуулийн 10 дугаар зүйлд заасан байдаг юм. Гэвч одоогийн практикт олон улсын гэрээг дотоодынхоо хуулинд сайтар тусгаж өгөөгүйн улмаас олон улсын гэрээг тэр бүр дагаж мөрдөхгүй, олон нийтэд бүрэн нээлттэй бус байгааг тэмдэглэх нь зүйтэй. Харин Монгол Улс Үндсэн хуульдаа харшилсан олон улсын гэрээ, бусад баримт бичгийг дагаж мөрддөггүй тул тийм хоёр талт ч бай олон талт ч бай олон улсын гэрээ байгуулдаггүй заншилтай.

4. Асуулт: Олон улсын гэрээг олон нийтэд сурталчлах нь хэний үүрэг вэ?

Хариулт: Олон улсын гэрээг гадаад харилцааны асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллагаас эрхлэн тусгай эмхтгэл болгон хэвлэж байна гэж Монгол Улсын Олон улсын гэрээний тухай хуулинд бий. Ер нь гэрээг сурталчлах ажил түүнийг эмхтгэлд хэвлүүлснээр дуусгавар болдоггүй тэдгээрийг холбогдох яам, газрууд хууль гармагц өөрийн шугамаар сурталчилж, нийтлэх, түүний дагуу хот, орон нутагт сургалт, семинар зохион байгуулах зэргээр нийтэд хүргэдэг өөр өөрийн үүрэгтэй.

5. Асуулт: Цаашдаа олон улсын гэрээг үргэлжлүүлэн хэвлэх үү? Төрийн мэдээллийн дээрх тусгай дугааруудыг хэрхэн тарааж байгаа вэ?

Хариулт: Одоогоор Монгол Улсын нэгдэн орсон 180 гаруй олон талт гэрээ байна. «Төрийн мэдээлэл» сэтгүүлийн тусгай дугаарын эхний 2 ботид 57 олон талт гэрээг нийтэлсэн. Бид манай улсын нэгдэж орсон олон талт бүх гэрээг нийтлэх зорилго тавьж байгаа бөгөөд энэ нь ойролцоогоор «Төрийн мэдээлэл» сэтгүүлийн 20 гаруй боть болно гэсэн тооцоо гарч байгаа. «Төрийн мэдээлэл»-ийн энэхүү тусгай дугаарыг хэвлэгдмэгц Улсын Их Хурлын Тамгын газраас холбогдох байгууллагад тарааж байгаа.

**«ЭРҮҮДЭН ШҮҮХ БОЛОН БУСАД ХЭЛБЭРЭЭР ХЭРЦГИЙ, ХҮНЛЭГ
БУСААР ХҮНИЙ НЭР ТӨРИЙГ ДОРМЖЛОН ХАРЬЦАХ,
ШИЙТГЭХИЙГ ХОРИГЛОХ» ОЛОН НИЙТИЙН НЭЭЛТТЭЙ
ХЭЛЭЛЦҮҮЛЭГ, ХЯНАЛТ ШАЛГАЛТ ЯВУУЛАХ УДИРДАМЖ**

Нэг. Нээлттэй хэлэлцүүлэг, хяналт шалгалт явуулах үндэслэл:

- ХЭҮК нь Монгол Улсын Үндсэн хууль, хууль, олон улсын гэрээнд заасан хүний эрх, эрх чөлөөний тухай заалтын хэрэгжилтэнд хяналт тавьж, хүний эрхийг сахин хамгаалах, хөхиүлэн дэмжих байгууллага юм.
- Монгол Улсын Үндсэн хуульд хэнд боловч эрүү шүүлт тулгаж, хүнлэг бус, хэрцгий хандаж, нэр төрийг нь доромжилж болохгүй, өөрөө өөрийнхөө эсрэг мэдүүлэг өгөхийг шаардах, мэдүүлэг гаргуулахаар шахалт үзүүлэх, хүч хэрэглэхийг хориглоно гэж заасан.
- Монгол Улс Эрүүдэн шүүх болон бусад хэлбэрээр хэрцгий, хүнлэг бусаар, хүний нэр төрийг доромжлон харьцаж шийтгэхийн эсрэг НҮБ-ын Конвенцид 2000 онд нэгдэн орж, уг Конвенцийг хэрэгжүүлэх үүрэг хүлээсэн. Хэнд боловч эрүү шүүлт тулгаж, хүнлэг бус, хэрцгий хандаж болохгүй гэж Эрүүгийн байцаан шийтгэх хуульд заасан. Иймээс Үндсэн хууль, хууль болон Монгол Улсын олон улсын гэрээнд заасан эрүү шүүлтээс ангид байх эрхийн хэрэгжилтэнд хяналт шалгалт хийх нь ХЭҮК-ын бүрэн эрхэд хамаарч байна.

Хоёр. Нээлттэй хяналт шалгалт явуулах шаардлага, зорилго:

- Монгол Улс Эрүүдэн шүүхийн эсрэг Конвенцид нэгдэн орж Үндсэн хууль болон Эрүү, Эрүүгийн байцаан шийтгэх хуулиараа эрүү шүүлтийг хориглосон боловч эрүүдэн шүүх, хүч хэрэглэх, шахалт дарамт үзүүлэх замаар мэдүүлэг авсан, хэрэг тулган хүлээлгэсэн, улмаар хилс хэрэгт шийтгүүлсэн тухай гомдол санал ХЭҮК болон холбогдох бусад байгууллагад нэг бус удаа гарч байна.
- Урьдчилан хорих байр, шорон гяндангууд нь ахуй нөхцлийн хувьд эрүү шүүлтийг нөхцөлдүүлсээр байна.
- Сүүлийн жилүүдэд эрүүдэн шүүж, хилсээр хэрэг хүлээлгэдэг, хэрцгийн хүнлэг бусаар харьцдаг талаар хэвлэл мэдээллийн хэрэгслээр олон тооны мэдээлэл, ярилцлага, санал гомдол гарсаар байна.
- Эрүүгийн онц аюултай гэмт хэрэгт холбогдуулан эрүүдэн шүүж,

хилсээр хэрэг хүлээлгэж байсан ба улмаар энэ хэрэг нь шүүхээр цагаадаж, хэрэгсэхгүй болгосон ноцтой баримтууд байна.

- 2002 онд Монгол Улсын Их Хурлын Хууль зүйн байнгын Хороо Ганц худгийн цагдан хорих төвд хийсэн УЕПГ-ын шалгалтын дүнг хэлэлцээд энэ төвд хүч хэрэглэх, эрүүдэн шүүх замаар мэдүүлэг гаргуулж, хэрэг хүлээлгэдэг дутагдал оршиж байгааг тэмдэглэж, арга хэмжээ авахыг холбогдох байгууллагуудад даалгаж байжээ.
- Зарим тохиолдолд сэжигтэн яллагдагчийг хамт хоригдогсдоор нь хүч хэрэглэн дарамтлуулж, онц хүнд гэмт хэрэг хүлээлгүүлж байсныг Прокурорын байгууллагын шалгалтаар илрүүлж, шүүхийн тогтоолыг хүчингүй болгуулж байсан.
- Иймээс эрүү шүүлтийн өнөөгийн нөхцөл байдал, түвшинг тодорхойлох, шалтгаан нөхцлийг илрүүлэх, эрүү шүүлт гарахаас урьдчилан сэргийлэх үр нөлөөлтэй арга хэмжээг тодорхойлох, энэ талаархи нийтийн мэдлэг боловсролыг дээшлүүлэх, хууль хэрэгжүүлэх байгууллагын ажилтнуудад зөв сэтгэлгээ, чиг хандлага төлөвшүүлэхэд нээлттэй хяналт шалгалтын зорилго оршино.

Гурав. Хамрах хүрээ, хугацаа:

- Нээлттэй хяналт шалгалтыг Нийслэл, Орхон, Дархан-Уул, Төв, Дорнод, Хөвсгөл аймгийг хамруулан хийнэ.
- Нээлттэй хяналт шалгалтыг, 2005 оны 1-р сараас эхлэн явуулж, 2005 оны 12-р сард тайлан, санал, Зөвлөмж гаргана.

Дөрөв. Нээлттэй хяналт шалгалтын хүрээнд дараах үйл ажиллагааг явуулна:

- Монгол Улсын хууль тогтоомж, хуулийн байгууллагын үйл ажиллагаанд баримтлаж буй дүрэм, журам, зааврууд ОУ-ын стандарт шаардлагад нийцэж байгаа эсэх, эрүү шүүлтээс урьдчилан сэргийлэх үр нөлөөтэй арга хэрэгсэл болж байгаа эсэхэд дүн шинжилгээ хийх.
- Шүүгч, прокурор, өмгөөлөгч, зарим төрийн бус байгууллагын ажилтнуудтай зөвлөлдөх уулзалт зрхион багйуулж, нээлттэй хяналт шалгалтын талаар танилцуулж, санал бодлыг нь сонсох.
- УЕП-ын дэргэдэх Мөрдөн байцаах алба, ЦЕГ-ын дэргэдэх Хяналт шалгалтын газар ирж буй өргөдөл гомдлуудыг судалж дүн шинжилгээ хийх.
- Урьдчилан хорих байр, шоронгийн нөхцөл байдлыг судлан үзэх.
- Сэтгэцийн өвчтэй хүмүүсийг албадан эмчлэх эмнэлэг, архаг архичдын эмнэлэг зэрэг тусгай байруудын үйл ажиллагаа, ахуй

нөхцлийг шалгаж, судлах.

- Эрүүдэн шүүсэн, хэрцгийн хүнлэг бус харьцсан төрийн байгууллагын албан тушаалтантай хариуцлага тооцох механизм, хуулийн зохицуулалтыг судалж, дүгнэх.
- Шүүхийн статистик мэдээ, тайланд дүн шинжилгээ хийж, эрүү шүүлттэй холбоотой шийдвэрлэгдсэн хэрэгүүдийг судалж үзэх.
- Цагдан хорих төвүүдэд хоригдож буй хүмүүсийн дунд анкетийн судалгаа явуулж, эрүү шүүлтийн ул мөр байгаа эсэхэд үзлэг хийх.
- Олон нийтээс эрүү шүүлтийн талаар мэдээлэл хүлээн авч, дүн шинжилгээ хийх.
- Тодорхой иргэдээс ирсэн мэдээллийг олон нийтийн нээлттэй хэлэлцүүлгээр хэлэцэх.

Тав. Нээлттэй хяналт шалгалтын дүнг гаргах:

- Нээлттэй хяналт шалгалтын ажлын нэгдсэн тайланг боловсруулж, холбогдох байгууллагын саналыг авах.
- Нээлттэй хяналт шалгалтын тайланг үндэслэн санал, Зөвлөмж гаргах.
- Ажлын тайлан, Зөвлөмжөөр олон нийтийн нээлттэй хэлэлцүүлэг хийх.
- Холбогдох байгууллагуудад санал, Зөвлөмж хүргүүлэх.
- Телевизийн нэвтрүүлэг бэлтгэх.

ХҮНИЙ ЭРХИЙН ҮНДЭСНИЙ КОМИСС



МОНГОЛЫН ӨМГӨӨЛӨГЧДИЙН ХОЛБОО

Монгол Улсын Өмгөөлөгчдийн Холбоо
Төв
Сүхбаатар-107
Улаанбаатар
Утас: (3311) 33001
Факс: (3311) 33001

2005-02-18

ТНХЗН

МОНГОЛ УЛСЫН ХҮНИЙ ЭРХНИЙ ҮНДЭСНИЙ КОМССЫН ДАРГА С.ЦЭРЭНДОРЖ ТАНАА

"Эрүүдэлтэй үзүүлэлтүүд бүхий хэргүүдийг шүүхэд
хүлээн барихад хэргийг гэрээгээр шийдвэрлэн
хөндөг, цахиргааны хэрэгтэй нь" цахиргааны
хөндөг шийдвэр гаруулах ажилыг дэмжих тухай

Эрүүл мэндийн дарга ая!

Монгол улсын Үндэсний эрүүдэлтэй үзүүлэлт бүхий хэргийг шүүхэд хүлээн барихад хэргийг гэрээгээр шийдвэрлэн хөндөг, цахиргааны хэрэгтэй нь" цахиргааны хөндөг шийдвэр гаруулах ажилыг дэмжих тухай

Хүний эрхийн Үндэсний эрүүдэлтэй үзүүлэлт бүхий хэргийг шүүхэд хүлээн барихад хэргийг гэрээгээр шийдвэрлэн хөндөг, цахиргааны хэрэгтэй нь" цахиргааны хөндөг шийдвэр гаруулах ажилыг дэмжих тухай

Хүний эрхийн эрүүл мэндийн үйлдэл хэргийг шийдвэрлэн хөндөг, цахиргааны хэрэгтэй нь" цахиргааны хөндөг шийдвэр гаруулах ажилыг дэмжих тухай

Та бусад ажиллагаа эхлүүлж байгаа байсан болон эхлүүлж ажилыг гүйцэтгэх ажилыг дэмжих тухай

Хууль эрх зөрчилгүй үйлдэл гаргасан байхгүй



С.ЦЭРЭНДОРЖ

С.ЦЭРЭНДОРЖ

S. Tserendorj С.ЦЭРЭНДОРЖ



AMNESTY INTERNATIONAL MONGOLIA

Холбооны Байгууллага Улаанбаатар, Улаанбаатар, Хөвсгөл-41 | Улаанбаатар | Монгол
Холбооны Байгууллага Улаанбаатар, Улаанбаатар, Хөвсгөл-41 | Улаанбаатар | Монгол
Telephone/Facsimile: 976-11-334700
E-mail: amnmg@amnesty.org

2020 оны 1 сарын 20

2020 оны 1 сарын 20

Бүтэц Засаг Засагчийн Комиссийн
дэргэц гишүүдэд захидал

Хуульчилсан үндэстэн, хүйс, өмчлөлийн үндэстэн
тусгай гишүүдэд захидал

Эцэс-Улаан Бүтэц Засаг Засагчийн Комиссийн гишүүдэд захидал
Хуульчилсан үндэстэн, хүйс, өмчлөлийн үндэстэн тусгай гишүүдэд захидал
Хуульчилсан үндэстэн, хүйс, өмчлөлийн үндэстэн тусгай гишүүдэд захидал

Хуульчилсан үндэстэн, хүйс, өмчлөлийн үндэстэн тусгай гишүүдэд захидал
Хуульчилсан үндэстэн, хүйс, өмчлөлийн үндэстэн тусгай гишүүдэд захидал
Хуульчилсан үндэстэн, хүйс, өмчлөлийн үндэстэн тусгай гишүүдэд захидал

Хуульчилсан үндэстэн, хүйс, өмчлөлийн үндэстэн тусгай гишүүдэд захидал
Хуульчилсан үндэстэн, хүйс, өмчлөлийн үндэстэн тусгай гишүүдэд захидал
Хуульчилсан үндэстэн, хүйс, өмчлөлийн үндэстэн тусгай гишүүдэд захидал

Хуульчилсан үндэстэн, хүйс, өмчлөлийн үндэстэн тусгай гишүүдэд захидал
Хуульчилсан үндэстэн, хүйс, өмчлөлийн үндэстэн тусгай гишүүдэд захидал
Хуульчилсан үндэстэн, хүйс, өмчлөлийн үндэстэн тусгай гишүүдэд захидал

Хуульчилсан үндэстэн, хүйс, өмчлөлийн үндэстэн тусгай гишүүдэд захидал
Хуульчилсан үндэстэн, хүйс, өмчлөлийн үндэстэн тусгай гишүүдэд захидал
Хуульчилсан үндэстэн, хүйс, өмчлөлийн үндэстэн тусгай гишүүдэд захидал

Хуульчилсан үндэстэн, хүйс, өмчлөлийн үндэстэн тусгай гишүүдэд захидал



Хуульчилсан үндэстэн, хүйс, өмчлөлийн үндэстэн тусгай гишүүдэд захидал
Хуульчилсан үндэстэн, хүйс, өмчлөлийн үндэстэн тусгай гишүүдэд захидал
Хуульчилсан үндэстэн, хүйс, өмчлөлийн үндэстэн тусгай гишүүдэд захидал

Regional Non-Governmental Organisation (RNGO) in Mongolia
Non-Governmental Organisation (NGO) No. 011017

Олон нийтийн хүний эрхийн боловсролыг дэмжих чиг үүргийнхээ хүрээнд ХЭҮК-оос энэ оны 1 дүгээр улиралд зохион байгуулсан сургалт, семинар болон бусад арга хэмжээнүүдийн талаарх товч мэдээллийг дараах хүснэгтэд оруулан уншигч авхай танаа толилуулж байна.

№	Сэдэв	Зорилтот бүлэг	Оролцогчдын тоо	Хаана	Огноо
1	Нийслэлийн шүүхийн шийдвэр гүйцэтгэх албаны ажилтнуудад зориулсан сургалт /3 өдрийн сургалт/	ШШГА-ны ажилтнууд	Тус бүр 60	ШШГА	2005.01.10, 17, 24
2	"Эрүүдэн шүүхийн эсрэг Конвенци"	Цагдаагийн байгууллагын ажилтнууд, Цагдаагийн Академийн сонсогч нарт /Хөдөө орон нутаг, нийслэл, дүүргийн Цагдаагийн хэлтсийн эрүүлжүүлэх байрны эмч нар нийт/	25	Цагдаагийн Академи	2005.02.15
3	"Хүний эрх ба үндэстний цөөнхийн эрх"	ИТХ төлөөлөгч нар	26	Хөвсгөл-Цагааннуур	2005.02.21-22
4	"Төсөл хэрхэн бичих"	ТББ	40	Хөвсгөл-Цагааннуур	2005.02.21-22
5	"Хүний эрх ба үндэстний цөөнхийн эрх"	ИТХ төлөөлөгч нар	30	Хөвсгөл – Мөрөн	2005.02.24-25
6	"ЭБША дахь хүний эрх"	Шүүх, прокурор, өмгөөлөгч, цагдаа, ШШГА-ны ажилтнууд	68	Хөвсгөл – Мөрөн	2005.02.25
7	"Хүний эрх-мэргэжлийн хяналт"	МХА-ны байцаагч нарт	28	Хөвсгөл – Мөрөн	2005.02.25
8	"Хүний эрх"	Дундговь аймгийн 10 сум, аймгийн ИТХ-ын төлөөлөгч нар	50	Дундговь аймаг	2005.03.09
9	"Эрүүл мэндээ хамгаалуулах эрх ба өвчтний эрх"	АУИС-ийн 1-р курсийн оюутнууд	70	АУИС	2005.03.10
10	"ЭБШ ажиллагаанд хүний эрхийг хангах нь"	Дүүргүүдийн цагдаагийн хэлтсийн хэрэг бүртгэгч, мөрдөн байцаагч нарт	70	СХДүүрэг	2005.03.15
11	"Хүний эрх"	ИТХ-ын тэргүүлэгч нар	30	Төв аймаг	2005.03.24
12	Хууль зүйн үндэсний төвөөс зохион байгуулдаг хуульчдын давтан сургалтын үеэр хүний эрхийн сургалтыг тогтмол зохион байгуулах	Нийслэл, дүүргийн шүүгч нарт.	32	ХЗҮТ	2005.03.25
13	"Хүний эрх – прокурорын хяналт"	Нийслэл, дүүрэг, аймгуудын орлогч прокуроруудад	34	Цэцийн дугуй зал	2005.03.28,-29
14	"Орон тооны бус зөвлөлийн гишүүдэд – Хүний эрх"	Орон тооны бус зөвлөлийн гишүүдэд	23	ХЭҮК-ын мэдээлэл лавлагааны төв	2005/03.30
15	"Цаг хэмнэлт"	Дотоод сургалт	12	ХЭҮК-ын мэдээлэл лавлагааны төв	2005.03.31



НҮБХХ нь мэдлэг, туршлага, нөөцийг холбож, улс орнуудын өөрчлөлтийг олон нийтэд хүргэх замаар илүү сайн сайхан амьдралыг цогцлон байгуулахад хүмүүст туслах зорилго бүхий НҮБ-ын дэлхий нийтийн хөгжлийн сүлжээ юм.

Эрхэм Уншигчид аа!

Та бүхэн манай сэтгүүлийн талаарх санал, үзэл бодлоо доор хаягаар ирүүлнэ үү.

Хүний Эрхийн Үндэсний Комисс

Хаяг: Улаанбаатар хот, Эрх чөлөөний талбай, Засгийн газрын XI байр, 5 дугаар давхар

Утас: 318082, 262971

Факс: 327136, 320284

Цахим шуудан: nco@mongol.net

Цахим хуудас: <http://www.nhrc-mn.org>